

GOBI
MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

АГУУЛГА

МАНАЙ КОМПАНИ

- 07 Компанийн ерөнхий танилцуулга
- 09 Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, уриа үг
- 10 Түүхэн замнал
- 12 ТУЗ-ийн даргын мэндчилгээ
- 14 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

2022 ОНД БИД

- 18 Бидний амжилт, онцлох үйл явдлууд
- 25 2022 оны санхүүгийн үр дүн
- 28 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл
- 30 Санхүүжилтийн мэдээлэл

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 34 Дотоод зах зээл
- 36 Гадаад зах зээл
 - 37 Экспортын борлуулалт
 - 38 Онлайн борлуулалт
- 46 Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлт
- 48 Коллекцууд
- 55 Брэндүүд

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ (БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ)

- 62 Тогтвортой хөгжлийн удирдлага
- 63 Байгаль орчин
- 71 Нийгэм
- 83 Засаглал
 - 84 Засаглалын бүтэц, үйл ажиллагаа
 - 86 Засаглалын бодлого
 - 88 Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүн
 - 89 Хувьцаа эзэмшигчид
 - 90 Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд, эцсийн өмчлөгчийн мэдээлэл
 - 91 Хувьцаа эзэмшигчдийн хурал
 - 92 Төлөөлөн удирдах зөвлөл
 - 98 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
- 103 Дотоод хяналтын тогтолцоо
- 114 Компанийн бүтэц
- 118 Менежмент багийн удирдлагууд
- 121 Компанийн хувьцааны арилжааны мэдээлэл
- 122 Ногдол ашиг

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 126 Хараат бус аудиторын тухай мэдээлэл
- 127 Говь ХК болон түүний охин компаниудын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан



МАНАЙ КОМПАНИ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	"Говь" хувьцаат компани	
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах	
Компанийн албан ёсны хаяг	Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК	
	Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК	
	Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: info.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Монгол: gobi.mn Европ: gobicashmere.com Америк: gobicashmere.com/us Их Британи: gobicashmere.com/uk Хятад: gobicashmere.cn	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж	
Компанийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500	
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН	
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9-р сарын 5-ны өдөр	
Ажилтнуудын тоо	1,548	
Үйлдвэрийн хүчин чадал	1,150 тонн түүхий ноолуур боловсруулах 1,050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 640,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
Дэлгүүрийн тоо	Дотоод Улаанбаатар хот 2 Дархан хот 1 Онлайн дэлгүүр 1	Гадаад Охин компани 4 Салбар дэлгүүр 1 Франчайз дэлгүүр 22 Онлайн дэлгүүр 6

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, УРИА ҮГ

АЛСЫН ХАРАА

Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт

ЭРХЭМ ЗОРИЛГО

Загварлаг, чанартай, нийцэмжит үнэтэй ноолууран хувцсаа дэлхийд таниулж, хүн бүрийг гоёно

УРИА ҮГ

Ноолууран хувцсыг хүн бүрт

ҮНЭТ ЗҮЙЛС



ХҮНДЭТГЭЛ



Бид олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бөгөөд харилцан хүндэтгэлтэйгээр санал бодлоо солилцдог.



ГАЛ ЭРМЭЛЗЭЛ & ЧИН СЭТГЭЛ



Бид хийж бүтээх чин сэтгэл, зорилгодоо хүрэх тууштай хүсэл эрмэлзэл дүүрэн хамт олон.



ШУДАРГА & ИЛ ТОД БАЙДАЛ



Бид бүх талуудын оролцоог ижил түвшинд чухалчлан, үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэдэг.



ТӨГӨЛДӨРШИЛ & ХАРИУЦЛАГА



Бид нийгэм, хүрээлэн буй орчин, оролцогч талуудад болон хийсэн үйлдэл, үр дүндээ хариуцлагатай хандаж, тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлж ажилладаг.




БҮТЭЭЛЧ БАЙДАЛ



Бид шинэ санаа, бүтээлч өөрчлөлтийг эрэлхийлж, хүлээлтээс давсан үр дүн рүү тасралтгүй тэмүүлдэг.

ТҮҮХЭН ЗАМНАЛ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Говь ХК маань 1981 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгч, харилцагчид болон компанийн удирдлага, ажилтнуудынхаа хичээл зүтгэл, хүч хөдөлмөрийн үр дүнд үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлсээр байна.

Манай компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ТОП 20 компанийн нэгийн хувьд компанийн засаглалын зарчмууд болон олон улсын засаглалын сайн туршлагауудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, тасралтгүй сайжруулж хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх болон мэдээллийн ил тод байдлаар хангаж ажиллах тал дээр манлайлсаар ирсэн билээ. Өнгөрөгч онд манай компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 1,556-аар нэмэгдэж нийт 23,172 хувьцаа эзэмшигчтэй болсон байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ тогтвортой, ногоон хөгжил рүү шилжин бизнесүүдийн хэтийн төлөв, зорилго өөрчлөгдөж буй бөгөөд компаниуд өөрийн үйл ажиллагаан дах байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-д үзүүлэх үр нөлөөг тооцон оролцогч талуудын урт хугацааны үнэ цэнэ, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэж байна. Үүнтэй уялдан олон улсын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулан дэлхийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй манай компанийн хувьд үйл ажиллагааны бүхий л шатандаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулж, ажилтнууд болон оролцогч талуудынхаа эрх ашгийг ханган, засаглалын түвшинд үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан ажиллахыг зорьж байна.

2022 оны хувьд ТУЗ-ийн түвшинд БОНЗ болон тогтвортой байдлын асуудалд анхаарал хандуулж ажиллах зорилт тавин, 4-р сард “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”-ыг баталсан бөгөөд тус үүрэг амлалтын хүрээнд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа тодорхойлон баталж, ТУЗ-ийн хурлуудаараа дамжуулан хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавин, удирдлагын багийг чиглүүлэн ажиллалаа.

Мөн байгууллагын соёлыг сайжруулах, ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх дээр удирдлагын багийн зүгээс төлөвлөгөө гарган шат дараатай хэрэгжүүлэн ажилласан бөгөөд энэ онд хийсэн онцлох ажил маань ажилтнуудынхаа хүүхдүүдэд зориулсан байгууллагын дэргэдэх “ГОВЬ-ийн багачууд” цэцэрлэгийн үйл ажиллагааг эхлүүлсэн явдал байлаа. Бидний хэрэгжүүлж буй ажлыг үнэлэн Нийслэлийн засаг даргын тамгын газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан арга хэмжээгээр Говь ХК-ийг 2022 оны гэр бүлийн хөгжлийг дэмжигч шилдэг үйлдвэрлэл, аж ахуйн нэгж байгууллагаар тодруулан шагнасан юм.

2022 онд КОВИД-19-ийн нөлөөлөл бүрэн арилагүй тул дэлхийн хэмжээнд том гүрнүүдийн геополитик болон гео-эдийн засгийн тэмцэл хурцдаж манай улсын ойролцоох бүс нутаг дайны байдалд хүрч байгаа зэрэг компанийн борлуулалтад шууд бусаар үзүүлэх нөлөөллүүд байсан хэдий ч манай компани 193.4 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан бөгөөд борлуулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 34 хувь өссөн үзүүлэлттэй байлаа.

Бид ирээдүйн урт хугацааны хөгжил дэвшлийг том зургаар харан, олон улсын зах зээлд илүү танигдах, өрсөлдөх, цаашлаад дэлхийн брэнд болох зорилгоор 2019 оноос хойш стратегийн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсээр байгаа бөгөөд үүгээрээ бид ирээдүйн өсөлт дэвшлийнхээ суурийг сайн бэлтгэж чадсан гэж дүгнэж байна.

Цаашид бид олон улсын зах зээлд брэндийн танигдалтаа улам бүр нэмэгдүүлж, дэлхийн өнцөг булан бүрд Говь брэндээр хүмүүсийг гоёж, өмнөх жилүүдэд оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөх, борлуулалтаа нэмэгдүүлэн ашигтай ажиллах болон хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллана.

Биднийг үргэлж дэмжин ажилладаг ажилтнууд, үнэнч хэрэглэгчид, түншүүд, хувьцаа эзэмшигчид болон бүхий л хамтрагч оролцогч талууддаа маш их баярлаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Удирдахуйн ухааны доктор (Ph.D), профессор Д.ГЭРЭЛМАА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Ноолууран хувцсыг хүн бүрт” уриатай Говь ХК нь үүсгэн байгуулагдаад 42 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа бөгөөд түүхэн энэ хугацаанд байгууллагын маань үе үеийн удирдлага, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлж, үндэсний хэмжээнд нэр хүндтэй шилдэг компани болоод зогсохгүй олон улсын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ шууд борлуулдаг дэлхийн хэмжээний брэнд компани болохыг зорин ажиллаж буйгаа дурдахад таатай байна.

2022 оны эхний хагаст ковидын нөхцөл байдал бүрэн арилаагүй хэдий ч оны дунд үеэс Монгол улс хилээ нээх шийдвэрийг гаргасантай холбоотой сүүлийн 2 жил тасраад байсан жуулчдын урсгал нэмэгдэн аялал жуулчлалын салбар сэргэж, манай улсад ирэх жуулчдын тоо нэмэгдсэн. Энэ нь манай дотоодын борлуулалтад эерэг нөлөөг үзүүлж 93.5 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өмнөх оноос 40% өссөн үзүүлэлттэй байлаа.

Онлайн борлуулалтын хувьд Говь брэндийг дэлхийн хэрэглэгчдэд таниулах зорилгоор маркетингийн зардлын зарцуулалт өмнөх 2 жилд өндөр байсан бол 2022 онд өмнөх оноосоо 28% бууруулсан бөгөөд нэг харилцагчийг татах дундаж зардлыг Европын зах зээлд 15 евро болгон 3.1 дахин бууруулж чадсан. Мөн нийт бүртгэлтэй хэрэглэгчдийн тоог өмнөх оноос 400 мянгаар нэмэгдүүлж нийт 653 мянгад хүргэсэн бөгөөд 54.3 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өмнөх оноос 33% өссөн үр дүнтэй байлаа. 11-р сард Их Британи улсад охин компани байгуулж борлуулалтын сувгаа нэмэгдүүлсэн бөгөөд онлайн борлуулалтын гол суваг болох www.gobicashmere.com веб сайт дээр олон улсын зах зээлд туршлагатай түншүүдтэй хамтран ажиллаж, брэндийн дүр төрх бүрдүүлэлт, зураг авалт, контентуудаа сайжруулан ажилласан бөгөөд веб сайтын дизайн хөгжүүлэлтийг хийн шинэчилж 7-р сард цоо шинэ өнгө төрхтэйгөөр ашиглалтад оруулсан.

Өнгөрөгч онд нэгдсэн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон ISO14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалтыг амжилттай авсан. Түүнчлэн бид утасны үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч Япон улсын чадварлаг, туршлагатай үйлдвэртэй хамтран ажиллаж, туршлага солилцоноор ноолууран утасныхаа чанарыг сайжруулж чадсан бөгөөд 12-р сараас эхлэн Италийн нэрт загвар зохион бүтээгчтэй хамтран ажиллаж эхэлснээр бүтээгдэхүүний загвар, дизайнаа хөгжүүлэн сайжруулж, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.

Манай компани Тогтвортой хөгжлийн бодлогынхоо “Аз жаргалтай ажилтан” зорилтын хүрээнд ажилтнуудынхаа ажил амьдралыг тэнцвэртэй байлгах, ажлын байрны таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, сурч хөгжих боломжийг нээх, ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

Бид 2023 ондоо ноос, ноолуур үйлдвэрлэлийн салбартаа цалин урамшуулаараа тэргүүлэх бодлого баримтлан ажиллах бөгөөд зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, олон улсад үйл ажиллагаагаа улам тэлж, улс орныхоо эдийн засгийн сэргэлтэд хувь нэмрээ оруулахад бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллахын сацуу нийгэм болоод байгаль орчиндоо ээлтэй, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэгч хариуцлагатай компани байхын төлөө ажиллах болно.

Та бүхэнд эрүүл энхийг хүсэж, цаашдын ажил үйлсэд тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БААТАРСАЙХАН



2022 ОНД БИД

БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

“АЛТАН БАТЛАМЖ” ГАРДАН АВЛАА.



Говь ХК-ийн Анхан шатны үйлдвэр нь Тогтвортой ноос ноолуурын эвслийн "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 2 дахь жилдээ амжилттай орж "Алтан батламжлал"-ын болзол хангаж чадлаа.

Энэхүү батламжлалыг авснаар Говь ХК нь малын тавлаг байдлыг хангаж, малчдын амьжиргааг дэмжиж, байгаль орчинд ээлтэйгээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болохоо баталгаажуулж байгаа юм.



“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮҮРЭГ АМЛАЛТ”-ЫГ БАТАЛЛАА.

Говь ХК-ийн 2022 оны 4-р сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар компанийн “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”-ыг 5 хамрах хүрээнд 14 чиглэлтэйгээр баталлаа.



ИХ-УУЛ СУМЫН МАЛЧИД ГОВЬ ХК-Д ШИЛМЭЛ ХЭЭЛТҮҮЛЭГЧ БЭЛЭГЛЭЛЭЭ.

Говь ХК нь ХААИС болон малчидтай хамтран “Тогтвортой ноолуур гурван талт төсөл”-ийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү төсөл нь Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Баянхонгор аймгийн Жинст сумуудад хэрэгждэг бөгөөд Үйлдвэрлэл – Шинжлэх ухаан – Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлж улмаар ноолуурын чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой юм. Төслийн үйл ажиллагааг дэмжин Хөвсгөл аймгийн Их-Уул сумын малчид түүхт 90 жилийн ойгоо тохиолдуулан нийт 90 үржлийн шилмэл хээлтүүлэгч бэлэглэснийг сумын Засаг дарга Б.Мянганбаяр төлөөлөн гардууллаа.



“ТОП-100”-ААР ШАЛГАРЛАА.

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг таван үзүүлэлтээр үнэлэн шалгаруулдаг “ТОП-100” аж ахуйн нэгжийн шалгаруулалтад Говь ХК нь 20-р байранд орж, өмнөх жилээс 11 байраар урагшлан амжилтаа ахиуллаа.

“BUSINESS CLINIC” УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.



Coachingolia багийнхны “Leadership coaching” хөтөлбөрийн эхний үе шат “Business Clinic” уулзалт Говь ХК дээр амжилттай зохион байгуулагдлаа.

Coachingolia-г үүсгэн байгуулагч Coach Д. Шинэбаяр (Shine Dagva), Coachingolia багийн менежментийн багийн зөвлөх Арчибалд Миллер-Бейквелл нарын хамтран боловсруулсан “Business Clinic” сургалтын анхдагч нь Говь ХК-ийн менежментийн багийн гишүүд байлаа.

Арчибалд Миллер-Бейквелл нь Английн хатан хаан Хоёрдугаар Элизабетийн менежментийн багийн гишүүн, Британийн армийн офицер асан, генерал цолтой бөгөөд Эдинбургийн гүн, хунтайж Филиппийн хувийн нарийн бичгийн дарга, зөвлөх, санхүүгийн захирлаар ажилладаг байжээ.

ОЛОН УЛСЫН ОНЛАЙН ХУДАЛДААНЫ www.gobicashmere.com ВЕБ САЙТЫГ ШИНЭЧИЛЛЭЭ.



Говь ХК 2019 оноос дэлхийн зах зээлийг чиглэн борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор олон улсын онлайн худалдааны www.gobicashmere.com веб сайтыг нээж байсан бол 2022 онд маркетингийн хүрээнд олон улсын зах зээлд туршлагатай харилцагчидтай хамтран ажиллаж, брэндийн дүр төрх бүрдүүлэлт, зураг авалт, контентуудаа сайжруулан ажиллаж, АНУ-ын Half Helix

агентлагаар веб сайтын дизайн хөгжүүлэлтийг хийлгэн шинэчилж 7-р сарын 22-ны өдөр цоо шинэ өнгө төрхтэйгөөр ашиглалтад орууллаа.

Веб сайтаа шинэчилснээр сайтын хурд хоёр дахин нэмэгдэж, илүү хялбараар хүссэн бүтээгдэхүүнээ захиалах боломжийг хэрэглэгчдэд олгож буй юм.

“ГОВЬ-ИЙН БАГАЧУУД” АЖИЛТНУУДЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙГ НЭЭЛЭЭ.



2022 оны 9-р сарын 5-ны өдөр “ГОВЬ-ИЙН БАГАЧУУД” ажилтнуудын хүүхдийн цэцэрлэгийг компанийнхаа түүхт 41 жилийн ойн баяраар амжилттай нээлээ.

“ГОВЬ-ИЙН БАГАЧУУД” цэцэрлэг нь бага, дунд, ахлах, бэлтгэл гэсэн 4 бүлэгтэй, 120 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, стандартын шаардлага хангасан цэцэрлэг болж тохижуулан Улсын тэргүүний 46-р цэцэрлэгийн салбар бүлгэм болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

ISO 45001:2018, ISO 14001:2015 СТАНДАРТУУДЫН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДАН АВЛАА.



Олон улсын Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 45001:2018, Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001:2015 стандартуудыг хэрэгжүүлэн 2022 оны 4 болон 7-р саруудад баталгаажуулалтын аудитад амжилттай орсон бөгөөд 9-р сарын 21-ний өдөр стандартуудын гэрчилгээгээ гардан авлаа. Баталгаажуулалтын аудитыг Олон улсын аудитын SGS байгууллага хийж гүйцэтгэсэн.

МУ-ЫН ЕРӨНХИЙ САЙД БЕРЛИН ДЭХ САЛБАР ДЭЛГҮҮРТЭЙ ТАНИЛЦЛАА.



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ХБНГУ-д Албан ёсны айлчлал хийх үеэрээ Говь ХК-ийн Берлин дэх салбар дэлгүүрээр зочилж, үйл ажиллагаатай танилцлаа.

Говь ХК-ийн Берлин дэх салбар дэлгүүр нь 2016 оны 11-р сарын 21-нд нээгдсэн бөгөөд өнөөг хүртэл үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн ажилласаар байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Европын Холбоо төдийгүй олон улсын зах зээлд онлайн худалдааны сувгаар бизнесээ өргөжүүлэн тэлж, Монгол хүний ур ухаан шингэсэн ноолууран бүтээгдэхүүнээр дэлхийн хүн зонийг гоёх бидний их үйлсэд амжилт хүслээ.



ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГААР ТОДОРЛОО.

Нийслэлийн засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан арга хэмжээгээр 2022 оны гэр бүлийн хөгжлийг дэмжигч шилдэг үйлдвэрлэл, аж ахуйн нэгж байгууллагаар Говь ХК-ийг тодруулан шагналаа.




ИТАЛИЙН ДИЗАЙНЕР ЖОРЖИО СПИНА ГОВЬ ХК-ИЙН ЕРӨНХИЙ ДИЗАЙНЕРААР АЖИЛЛАХААР БОЛЛОО.

Говь ХК Итали улсын алдарт дизайнер Жоржио Спинатай хамтран ажиллах гэрээг үзэглэлээ. Италийн болон бусад загварын ордны дизайнеруудтай хамтран ажиллаж байсан тэрээр өдгөө монгол ноолуурыг урладаг Говь брэндийн ерөнхий дизайнераар ажиллан өөрийн уран сэтгэмжийг ноолууран утсаар илэрхийлэн коллекц гарган хамтран ажиллахаар болсон байна.


Монгол малчны хотноос дундын дамжлагагүйгээр үйлдвэрийн аргаар боловсруулсан ноолууран утсаар Итали дизайнераын ур ухаанаа шингээн урласан коллекцийг хэрэглэгчдэд хүргэхэд уг хамтын ажиллагааны үр дүн оршиж байгаа юм.

БОРЛУУЛАЛТ

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/




БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2007 ОНООС ХОЙШ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 151.3 тэрбум төгрөг



2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 151.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23.2 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37.3 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-ийг нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




2022 онд нийт 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 55% буюу 1.6 тэрбум төгрөг нь барилга байгууламж, 8% буюу 230 сая төгрөг нь тоног төхөөрөмж, 31% буюу 926 сая төгрөг нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгө оруулалт, 6% буюу 189 сая төгрөг нь биет бус хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ

Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 199.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнийг нэр төрөл болон он цагалбараар дэлгэрүүлэн доор харуулав.

ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ



ГОВЬ ХК 2022 ОНД /2021 оны гүйцэтгэлтэй харьцуулав/

↑ 34%

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
193.4 тэрбум төгрөг

↑ 82%

ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)
(7.0) тэрбум төгрөг

↑ 40%

ДОТООД БОРЛУУЛАЛТ
93.5 тэрбум төгрөг

↑ 24%

ГАДААД (ЭКСПОРТ) БОРЛУУЛАЛТ
45.6 тэрбум төгрөг

↑ 33%

ГАДААД (ОНЛАЙН) БОРЛУУЛАЛТ
54.3 тэрбум төгрөг

↓ 28%

МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ
28.9 тэрбум төгрөг

↑ 47%

ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН
847.6 мянган ширхэг

↑ 14%

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
1.0 сая ширхэг

↓ 24%

КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭ
193.7 тэрбум төгрөг

↑ 5%

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР, ШИМТГЭЛ
22.0 тэрбум төгрөг

↑ 367%

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
3.0 тэрбум төгрөг


↓ 5%

ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ
223.4 тэрбум төгрөг


2022 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2021 он	2022 он		
		Гүйцэтгэл 2021	Гүйцэтгэл 2022	Өсөлт/бууралт	
				тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	144,344	193,428	49,083	34%
Дотоод борлуулалт	сая.төг	66,660	93,500	26,841	40%
Гадаад борлуулалт - Экспорт	сая.төг	36,822	45,586	8,763	24%
Гадаад борлуулалт - Онлайн	сая.төг	40,862	54,342	13,479	33%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо/ш	мян.ш	891	1,012	121	14%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	85,543	97,767	12,223	14%
НИЙТ АШИГ	сая.төг	58,801	95,661	36,860	63%
Бохир ашгийн хувь	хувь	41%	49%	-	8%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	100,189	100,815	627	1%
Маркетингийн зардал	сая.төг	39,884	28,876	(11,008)	-28%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	(41,388)	(5,155)	36,233	88%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	-29%	-3%	-	26%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	(3,276)	4,842	8,118	248%
Татварын өмнөх ашиг	сая.төг	(38,112)	(9,997)	28,115	74%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	сая.төг	(37,946)	(6,998)	30,948	82%
Цэвэр ашгийн хувь	хувь	-26%	-4%	-	22%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	185,732	198,582	12,850	7%
ҮЙЛДВЭРЛЭЛ					
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ш	474	674	200	42%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ш	72	136	64	88%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ш	30	38	8	25%
Пальто	мян.ш	15	16	2	11%
Пиджак	мян.ш	4	6	2	67%
Ээрмэл утас	тонн	174	168	(6)	-3%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,527	1,548	21	1%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	94,528	124,953	30,425	32%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	644	3,009	2,365	367%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	270,733	292,284	21,551	8%
Банкны зээл	сая.төг	234,159	223,448	(10,711)	-5%
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	299,858	298,112	(1,746)	-1%
Бараа материал	сая.төг	138,030	128,809	(9,222)	-7%

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
/тэрбум төгрөг/ **↑34%**




БОХИР АШГИЙН ХУВЬ




2022 оны ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2021 онтой харьцуулахад борлуулалтын орлого 193.4 тэрбум төгрөгт хүрч 34% өсөлттэй байсан бол бохир ашгийн хувь 8 пунктээр өсч 49% болж сайжирсан.

ЦЭВЭР АШИГ
/тэрбум төгрөг/ **↑82%**




НИЙТ ХӨРӨНГӨ
/тэрбум төгрөг/ **↓1%**




Компанийн 2022 оны цэвэр ашиг (алдагдал) -7.0 тэрбум төгрөг ба тайлант үеийн алдагдал нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна.

МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ
/тэрбум төгрөг/ **↓28%**




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШГИЙН ХУВЬ




Нийт маркетингийн зардлын 97%-ийг гадаад зах зээлд зарцуулдаг. 2022 онд гадаад зах зээлд брэнд танигдалт нэмэгдсэнээр нэг харилцагчийг татах маркетингийн зардлыг өмнөх оноос 3.1 дахин бууруулж чадсан бөгөөд нийт маркетингийн зардал 28% буурсан үзүүлэлттэй байна.

БАРАА МАТЕРИАЛЫН ЭРГЭЦ
/хоног/ **↓29%**




АВЛАГЫН ЭРГЭЦ
/хоног/ **↓71%**




2022 онд түүхий эд татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2021 оноос 29%-р буурч 504 хоног болж сайжирсан. Мөн борлуулалтын авлагын эргэцийг 2021 оноос 71%-р бууруулсан буюу 2 хоногийн эргэцтэй болж сайжирсан үзүүлэлттэй байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН ТОО
/мянган ширхэг/ **↑47%**




БОРЛУУЛСАН ТОО
/мянган ширхэг/ **↑14%**



2022 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 47%, борлуулсан бүтээгдэхүүний тоо 14%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Бүтээгдэхүүний нэр төрлөөр нь аваад үзвэл сүлжмэл бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний 75-80%-ийг эзэлж байна. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 16%, борлуулсан бүтээгдэхүүний 22% эзэлж байгаа нь өмнөх оноос 7 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Харин оёмол бүтээгдэхүүн нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 4.4%, борлуулсан бүтээгдэхүүний 3.5%-ийг эзэлж байна.

МӨНГӨН УРСГАЛ



2022 онд үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний хүрээнд орох мөнгөн гүйлгээ 211.5 тэрбум төгрөг байгаагаас борлуулалтын орлого 210.3 тэрбум төгрөг байна. Харин гарах мөнгө гүйлгээнд нийт 176.3 тэрбум төгрөг зарцуулснаас 127.9 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 22.0 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 26.4 тэрбум төгрөг тус тус төлж цэвэр үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ сайжирсан үзүүлэлттэй байна. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хүрээнд 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд 27.3 тэрбум төгрөгөөр зээлийн дүнг бууруулсан үзүүлэлттэй байна.

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлант үеийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Группийн толгой компани болох Таван Богд Трейд ХХК болон түүний хамаарал бүхий компаниудтай хийсэн ажил гүйлгээг сонирхлын зөрчилтэй буюу холбоотой талуудтай хийсэн хэлцэлд тооцсон болно. Жил бүрийн эхэнд ТУЗ-ийн хараат бус гишүүд нь тухайн жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсөн этгээдүүдийн жагсаалтыг баталдаг бөгөөд жилийн эцэст компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс ТУЗ-д сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй хийгдсэн хэлцлийн тайлангаа тавьж, ТУЗ-ийн Эрсдэл аудитын хороо болон хараат бус гишүүд тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

Говь ХК-ийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 90-р хуудаснаас харж танилцах боломжтой.

1.2022 оны холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл /мян.төг/

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

1.1 Холбоотой талууд		Холбоо хамаарал	
Хувьцаа эзэмшигчид			
Таван Богд Трейд ХХК		Дээд шатны хянагч этгээд	
Хиде Интер ХХК		Хувьцаа эзэмшигч,	
Зэргэлдээ охин компаниуд			
Дээд шатны хянагч этгээдийн охин компаниуд			
Бусад холбоотой талууд			
Хараат, хамтарсан компаниуд, үндсэн удирдлагын багийн гишүүдийн хяналтан дор байдаг холбоотой талууд			
1.2 Холбоотой талуудын дансны үлдэгдэл		2021	2022
Холбоотой талуудаас авах дансны авлага			
Бусад холбоотой талууд		30,222	17,222
Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/			
Дээд шатны хянагч этгээд		185,445	-
Зэргэлдээ охин компаниуд		771	42,268
Бусад холбоотой талууд		109	5,316
Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/			
Дээд шатны хянагч этгээд		25,622,107	30,980,732
Холбоотой талаас авсан зээл			
Бусад холбоотой талууд		-	10,025,578

Жич: Холбоотой талуудын дансны үлдэгдэл нь барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй. Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Трейд ХХК-иас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Дэлгэрэнгүйг Тодруулга 18-аас харна уу. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй.

1.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Дараах ажил гүйлгээг Таван Богд Группийн толгой компанитай хийсэн:

	2021	2022
Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт	1,256,062	1,356,559
Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт	39,134	7,789
Дээд шатны хянагч компаниас авсан түрээсийн орлого	-	22,090
Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал	2,032,887	2,219,369
Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн:		
	2021	2022
Бусад холбоотой талаас авсан санхүүжилт	41,483,084	105,506,586
Бусад холбоотой талаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	41,483,084	105,506,586
Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт	454,406	1,202,395
Бусад холбоотой талаас авсан худалдан авалт	42,641	28,918
Бусад холбоотой талд хийсэн борлуулалт	142,468	134,599
Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого	255,979	347,349
Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал	272,418	853,494

Дараах ажил гүйлгээг дээд шатны хянагч компанийн хараат компани болох Хаан Банктай хийсэн байна.


	2021	2022
Хаан банкнаас авсан санхүүжилт	39,237,105	19,310,000
Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	47,237,105	9,310,000
Хаан банкинд хийсэн борлуулалт	1,115,012	22,002
Хаан банкнаас авсан худалдан авалт	-	1,302,303
Хаан банкинд төлсөн хүүгийн зардал	207,648	194,904

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

2. 2022 онд холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний харьцуулалт /мян.төг/

САНХҮҮЖИЛТИЙН ЗАРДАЛ	2021	2022
Нийт санхүүжилтийн зардал	25,474,286	26,000,427
Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал	2,305,305	3,267,767
Эзлэх хувь /холбоотой тал/	9.0%	13%

Нийт санхүүжилтийн зардал




Говь ХК нь 2022 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 3,267,767 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 13%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 7.3% байна.

Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

ХУДАЛДАН АВАЛТ	2021	2022
Нийт худалдан авалт	8,293,815	60,911,143
Гадаадын худалдан авалт	4,957,126	10,241,714
Дотоодын худалдан авалт	3,336,689	50,669,429
Холбоотой талаас авсан худалдан авалт	454,406	2,587,862
Эзлэх хувь /нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	5.5%	4.2%
Эзлэх хувь /дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	13.6%	5.1%

Нийт худалдан авалт



Дотоодын худалдан авалт



Говь ХК нь 2022 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 2,587,862 мянган төгрөг буюу нийт худалдан авалтын 4.2%, дотоодын худалдан авалтын 5.1%-ийг эзэлж байна.

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн "Худалдан авалтын бодлого", "Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам", "Ажил үйлчилгээ худалдан авах журам", "Сонгон шалгаруулах хорооны журам"-ын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН НЭР	Валют	Жилийн хүү /%/	Дуусах хугацаа /он/	Зээлийн үлдэгдэл 2022.01.01	Зээлийн үлдэгдэл 2022.12.31
1. Монгол Улсын Хөгжлийн Банк	MNT	11.50%(3%)	2022	33,333,333	33,333,333
2. Худалдаа Хөгжлийн Банк	MNT	8.00%	2022	990,000	-
3. Хас банк	MNT	13.20%(14.40%)	2023	10,000,000	9,566,000
4. Голомт банк	USD	7.20%	2023	9,685,920	-
5. Монгол Улсын Хөгжлийн Банк	MNT	12.00%	2023	42,900,000	42,900,000
6. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А)	USD	6.79%	2024	7,251,491	6,262,910
7. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б)	USD	7.49%	2024	10,877,236	9,394,364
8. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2)	USD	6.93%	2024	12,431,128	11,273,235
9. Голомт Банк	MNT	11.00%	2025	-	20,000,000
10. Хаан Банк	MNT	3.00%	2024	-	10,000,000
11. Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	EUR	4.25%	2027	51,567,840	29,352,160
12. Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	MNT	5.25%	2027	45,121,860	51,366,280
Нийт зээлийн дүн				224,158,808	223,448,282

Монголбанкны ханш /төгрөг/		
	2022.01.01	2022.12.31
USD	2,848.80	3,444.60
EUR	3,222.99	3,669.02

САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН НЭР	Валют	Жилийн хүү /%/	Дуусах хугацаа /он/	Зээлийн үлдэгдэл 2022.01.01	Зээлийн үлдэгдэл 2022.12.31
1. Хаалттай Бонд	MNT	9.00%	2022	10,000,000	-
Нийт зээлийн дүн				10,000,000	-






БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ


2022 онд дотоод зах зээл 93.5 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 40%-ийн өсөлт үзүүлэв. Мөн нийт 459 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 14%-ийн өсөлттэй байв.




ЖУУЛЧДЫН УЛИРЛЫН НЭЭЛТ

2022 оны 5-р сард Монгол улс хилээ нээсэнтэй холбоотой сүүлийн 2 жил тасраад байсан жуулчдын урсгал нэмэгдэн аялал жуулчлалын салбар сэргэж, манай улсад ирэх жуулчдын тоо нэмэгдсэн. Говь ХК-ийн зүгээс 6-р сард аялал жуулчлалын улирлын нээлтийг зохион байгуулж Аялал жуулчлалын холбоо, аяллын байгууллагууд болон хөтөч жолооч нартай хамтран ажиллах гэрээ байгуулан жуулчдын борлуулалтыг идэвхжүүлэхэд анхаарч ажилласан нь дотоодын борлуулалтад эерэг үр нөлөөг үзүүлсэн.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



ХУДАЛДАН АВАГЧДЫН ТОО



2022 оны дотоодын нийт борлуулалтын 20%-ийг жуулчдын борлуулалт эзэлсэн ба үнийн дүнгээр нь аваад үзвэл өмнөх оноос 32 дахин өссөн байна. Харин дэлгүүрээр үйлчлүүлсэн нийт худалдан авагчдын тоо 220 мянгад хүрсэн нь өмнөх оноос 26% өссөн үзүүлэлт бөгөөд нийт худалдан авагчдын 13%-ийг жуулчид эзэлсэн байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2 ДУГААР САР



Хэрэглэгчийн тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрт засвар шинэчлэлийн ажлыг хийв.

3 ДУГААР САР



Үйлдвэрийн дэргэдэх “Хими цэвэрлэгээний хүлээн авах”-ыг хуучин Outlet дэлгүүрийн байр луу шилжүүлж, үйлчилгээний зай талбайг томруулан шинэчлэв.

5 ДУГААР САР



Бид хувь захиалгын байрыг тохижуулан шинэчилж, VIP өрөөг мөн тусгаарлан үйлчлүүлэгчид тав тухтай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэв.

7 ДУГААР САР



Төрийн соёрхолт С.Саранцацралт зураачтай хамтран “НААДАМ” коллекцийг амжилттай гаргасан нь хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн өндөр үнэлгээг авав.


11 ДҮГЭЭР САР



Чингис хааны музейд зориулан “ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРӨГ”-ийг дэлхийн хамгийн том ноолууран давуун дээр 5.52x3.52 метр хэмжээтэй урлан дурсгав.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

Говь ХК-ийн гадаад зах зээл нь Монголоос гадаад харилцагчид руу шууд борлуулж буй экспортын борлуулалт, гадаад дахь охин компаниараа дамжуулан борлуулж буй онлайн борлуулалт гэсэн үндсэн 2 борлуулалтын сувгаас бүрддэг.



2022 онд гадаад зах зээлд нийт 99.9 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 29%-ийн өсөлт үзүүлэв.


Гадаад зах зээлийг бүтцээр нь аваад үзвэл 46%-ийг экспортын борлуулалт, 54%-ийг онлайн борлуулалт эзэлж байна.



ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ



2022 онд экспортын зах зээлд харилцагчийн тоог цөөлөн, масс захиалга өгдөг стратегийн түнш харилцагчидтай хамтран ажиллан, үйлдвэрлэлийн бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласан. Үүний үр дүнд 2021 онд нийт 84 харилцагчид бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн бол 2022 онд 40 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлэн харилцагчийн тоогоо 52% бууруулж, 312 мянган ширхэг бүтээгдэхүүнийг 45.6 тэрбум төгрөгөөр борлуулсан нь өмнөх оноос 24% өссөн үзүүлэлттэй байлаа.



2022 оны сүүлийн байдлаар 8 улсын 20 хотод 22 франчайз дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.


ОНЛАЙН БОРЛУУЛАЛТ

www.gobichashmere.com

Говь ХК нь гадаад борлуулалтын сувгаа хөгжүүлэн Монгол хүний ур ухаан шингэсэн ноолууран бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулан, бизнесээ өргөжүүлж, улсынхаа экспортын хэмжээг нэмэгдүүлэн Монгол ноолуурыг дэлхийд таниулахаар ажиллаж байна. Онлайн борлуулалтын зорилтот зах зээлүүд болох Европын Холбоо, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэсэн 3 бүсэд төвлөрөн дэлхийн өнцөг булан бүр дэх эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ шууд борлуулж байна.

2022 оны хувьд дэлхийн томоохон компаниудтай хамтран ажиллаж Говь брэндийн онлайн дэлгүүрийн веб сайтынхаа дизайн, идэвхжүүлэлт болон бүтээгдэхүүний зураг авалтаа сайжруулах зэрэг борлуулалтаа дэмжих томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид хөгжил дэвшлийнхээ дараагийн том шат руугаа алхаж, дэлхийн өнцөг булан бүрд Говь брэндийг хэрэглэгчид өмсдөг болох, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг өсгөх, бизнесийн үйл ажиллагаагаа урт хугацаандаа улам бүр тогтвортой болгон, улс орныхоо ирээдүй, хойч үед өвлүүлэх баялаг бүтээгч болохын төлөө ажиллах зорилго тавин ажиллаж байна.



ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗАХ ЗЭЭЛ	CTR			CR			CPA		
	2021	2022	Өсөлт/бууралт	2021	2022	Өсөлт/бууралт	2021	2022	Өсөлт/бууралт
EU-UK-US	0.59%	1.36%	131%	0.75%	1.93%	157%	€95.02	€63.48	-36%
CN	1.79%	3.30%	84%	0.67%	0.69%	3%	¥296	¥190	-33%

Товчилсон үгийн тайлбар

EU – Европын Холбоо
UK – Их Британи
US – Хойд Америк
CN – Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Үзүүлэлтүүдийн тайлбар

CTR /Click through rate/

- Нийт сурталчилгаа харсан тооноос хэдэн хувь нь click буюу үйлдэл хийснийг илэрхийлэх хувь

CR /Conversion rate/


- Нийт веб рүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

CPA /Cost per Acquisition/

- Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй маркетингийн зардал

ЗАХ ЗЭЭЛ	Захиалгын тоо /ширхэг/			Борлуулсан бүтээгдэхүүн /мянган ширхэг/			Борлуулалтын орлого /тэрбум төгрөг/		
	2021	2022	Өсөлт/бууралт	2021	2022	Өсөлт/бууралт	2021	2022	Өсөлт/бууралт
EU	57,402	64,401	20%	93.8	127.3	36%	25.2	32.6	29%
UK	4,898	4,741	-97%	5.7	7.5	32%	1.9	1.9	1%
US	22,884	26,156	14%	49.5	51.4	4%	9.4	13.7	46%
CN	14,132	20,288	44%	16.3	25.8	58%	4.4	6.1	40%
Нийт	99,316	115,586	16%	165.3	212.0	28%	40.9	54.3	33%

Тайлбар: 2021 онд EU зах зээлээс UK вэбийн борлуулалт хийгдэг байсан ба 2022 оны 11 сарын 15-нд UK-д охин компани байгуулснаар тухайн зах зээлээс борлуулалтаа шууд хийдэг болсон.




ЕВРОПЫН ХОЛБОО, ИХ БРИТАНИ, ХОЙД АМЕРИКИЙН ЗАХ ЗЭЭЛ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Zalando Marketplace дахь борлуулалтын сувгаа нэмэв.

Европын томоохон худалдааны суваг болох Zalando Marketplace дахь борлуулалтын сувгаа нэмж Австри, Франц, Швед улсуудад бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.



Зураг авалтын өнгө төрхөө сайжруулав.

Герман улсад төвтэй Studio Cherie-тэй хамтын ажиллагаа эхлүүлж зураг авалтын өнгө төрхөө сайжруулан веб стандарт зураг авалт болон идэвхжүүлэлтийн зураг авалт дээр хамтран ажиллаж байна.

2022 онд ICONIC, WHOLEGARMENT, KIDS, APRES SKI гэсэн 4 коллекцийн зураг авалт хийсэн бөгөөд веб хуудсанд байршуулах бүх бүтээгдэхүүний стандарт зурагнуудыг шинэчлэн авч, арын фон өнгийг жигдрүүлсэн.


Веб сайтаа шинэчлэв.

АНУ-ын Half Helix агентлагтай хамтран www.gobicashmere.com веб сайтын дизайн UX&UI, бүтээгдэхүүний тайлбар зураг авалтуудаа сайжруулан шинэчилж 7 сарын 22-нд цоо шинэ өнгө төрхтэйгөөр ашиглалтад оруулсан.

Ингэснээр веб сайтын хурд 2 дахин нэмэгдэж дэлхийн стандартад нийцсэн бөгөөд хэрэглэгчийн худалдан авалт хийх хүртэлх үйлдлийн тоог бууруулж илүү хялбар бөгөөд ойлгомжтой болгож чадсан юм.

Instagram хаягаа албан ёсоор баталгаажуулав.

Компанийн gobicashmere.com Instagram хаяг баталгаажин Verified Badge-аа авч, албан ёсны цэнхэр тэмдэглэгээтэй болсон. Энэхүү цэнхэр тэмдэглэгээ нь зөвхөн албан ёсны, баталгаажсан брэнд болон хэрэглэгчдэд олон шат дамжлагын хяналт, шалгуурын үндсэн дээр олгогддог тул брэндийн нэр хүндийг өсгөхөд нэг алхам урагшилсан.



“Дэлхийн №1 ноолууран пальто үйлдвэрлэгч компани” болохоо баталгаажуулав.

Говь ХК нь дэлхийн зах зээлийн олон шатлалт худалдааны шалгуурыг хангаж “Дэлхийн №1 ноолууран пальто үйлдвэрлэгч компани” болохоо баталгаажууллаа.

Энэхүү худалдааны тэмдгийг АНУ-ын Худалдааны яамны харьяа агентлаг болох АНУ-ын Патент, барааны тэмдгийн албанаас олгодог бөгөөд ийнхүү албан ёсоор тус баталгаажуулалтыг авснаар Хойд Америкийн зах зээлд монгол ноолуураа таниулан сурталчлах таатай боломж бүрдэж байгаа юм.



Брэндийн органик хайлтыг сайжруулж эхлэв.

9-р сараас SEO компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхаарч ажиллаж эхэлсэн.



Нью-Йорк хотод рор-уп дэлгүүр нээв.

Нью-Йорк хотын төв А бүсэд байрлах SHOWFIELDS худалдааны төвд GOBI Cashmere рор-уп дэлгүүр 9-р сарын 28-ны өдөр нээлтээ хийсэн. Нээлтийн үйл ажиллагаан дээр 5W x SHOWFIELDS компаниуд хамтран эвентэд оролцсон. Энэхүү дэлгүүрийг 2023 оны 3-р сар хүртэл 6 сарын хугацаанд ажиллуулахаар төлөвлөж байгаа бөгөөд брэнд танигдалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ бодитоор танилцуулахад чухал үр дүнтэй юм.



Их Британи улсад охин компаниа байгуулав.


Их Британи улс нь 2020 онд Европын борлуулалтын 11% эзэлж байсан ба цаашид улам өсөх боломжтой зах зээлийн нэг байсан. Гэвч 2021 онд Европын холбооны гишүүн улсаас гарснаас хойш Европын борлуулалтын 8% эзлэх болж буурсан. Иймээс 2022 онд Их Британи улсад охин компаниа байгуулан 11-р сард веб хуудсаа ашиглалтад оруулснаар зах зээлээ тэлсэн.



Их Британид ЗPL үйлчилгээг нэвтрүүлэв.

Их Британид шинээр ЗPL үйлчилгээг нэвтрүүлэн Tarlu компанитай хамтран ажиллаж эхэлсэн. Мөн агуулахын менежментийн системийг Shopify-тай хамтран хэрэгжүүлсэн.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Тайлбар: x - дахин


2022 онд онлайн борлуулалтын сувгийн нийт бүртгэлтэй харилцагчдын тоо 653 мянгад хүрсэн нь өмнөх оноос 2.6 дахин өссөн үзүүлэлт байв.

Бүртгэлтэй харилцагчдыг ангиллаар нь аваад үзвэл нэг удаагийн худалдан авагчийн тоо 139 мянгад хүрч өмнөх оноосоо 1.6 дахин, давтан худалдан авагчдын тоо 77 мянгад хүрсэн нь өмнөх оноос 2.2 дахин, харин мэдээлэл авагчийн тоо 437 мянгад хүрсэн нь өмнөх оноос 3.4 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

НЭГ ХАРИЛЦАГЧИД НОГДОХ ЗАРДАЛ /евро/




2022 онд гадаад борлуулалтын нэг харилцагчийг татах дундаж зардал өмнөх оноосоо 3.1 дахин буурч 15 евро болсон. Энэ нь манай компанийн маркетингийн зардлын зарцуулалт илүү оновчтой болж, дэлхийн зах зээлд Говь брэнд танигдалт нэмэгдэж байгааг илтгэх чухал үзүүлэлт юм.



ЕВРОПЫН ХОЛБОО

Европын холбооны зах зээлд 2022 онд 32.6 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж 29%-ийн өсөлттэй ажилласан. Мөн нийт 127 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос 36% өссөн үзүүлэлттэй байлаа.




БОРЛУУЛАЛТЫН СУВАГ	Борлуулалт /сая төгрөг/		Өсөлт/бууралт %	Борлуулалтад эзлэх хувь
	2021	2022		
Веб хуудас	21,346	27,400	28%	84%
Zalando	765	1,089	42%	3%
Салбар дэлгүүр	3,072	4,065	32%	13%
НИЙТ	25,182	32,554	29%	100%

Борлуулалтын сувгаар нь задлаад үзвэл веб хуудсаар хийсэн онлайн борлуулалт 27.4 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 28% өсөлттэй, Европын томоохон Marketplace болох Zalando-ийн онлайн борлуулалт 1.1 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 42% өсөлттэй байсан бол Герман улс дахь салбар дэлгүүрийн борлуулалт 4.1 тэрбум төгрөг буюу 32% өсөлттэй байв.


ИХ БРИТАНИ

Их Британи улсын зах зээлд 2022 онд 1.93 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийсэн бөгөөд 7.5 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос 30% өссөн үзүүлэлттэй байлаа. Цаашид борлуулалтаа улам нэмэгдүүлэн ажиллахаар зорьж байна.



ХОЙД АМЕРИК

Хойд Америкийн зах зээлд 2022 онд 13.7 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж 46%-ийн өсөлттэй ажилласан. Мөн нийт 51 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос 4% өссөн үзүүлэлттэй байлаа.



БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



3PL үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв.

Хятадын зах зээлд 3PL үйлчилгээг амжилттай нэвтрүүлж Японы Sagawa групп компанийн БНХАУ дахь охин компани RUNBOW-тэй агуулахын үйлчилгээ авах гэрээг 6-р сард байгуулан агуулахаа Шанхай хот руу нүүлгэв. Ингэснээр хэрэглэгч нартаа захиалгыг нь илүү хурдан шуурхай, найдвартай хүргэн өгч үйлчлэх боломжийг бүрдүүлж чадсан.




Beidou зургийн студитэй хамтран ажиллав.


Хэрэглэгчдийн онцлог, сонирхол, мэдрэмжид нийцүүлэн Beidou зургийн студитэй хамтран ажиллаж 632 бүтээгдэхүүний зураг авалтыг Хятад улсын Гуанжоу хотод хийв. Ингэснээр Хятад улс дахь хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ илүү хүргэх боломжийг нэмэгдүүлсэн.

БНХАУ

Хятадын зах зээлд 2022 онд 6.1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж 40%-ийн өсөлттэй ажилласан. Мөн нийт 26 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос 58% өссөн үзүүлэлттэй байлаа.



БОРЛУУЛАЛТЫН СУВАГ	Борлуулалт /сая төгрөг/		Өсөлт/бууралт %	Борлуулалтад эзлэх хувь
	2021	2022		
Tmall	2,104	3,421	63%	56%
Taobao	875	557	-36%	9%
Tiktok	123	138	12%	2%
JD	633	583	-10%	9%
Wechat	21	1	-95%	0%
B2B	634	1,447	128%	24%
НИЙТ	4,389	6,147	40%	100%



Говь ХК нь 2020 онд компанийн үйл ажиллагааны процессууд дээрээ программ хөгжүүлэлтийг шат дараатай хийн, гадаад болон дотоод хэрэглэгч харилцагч талуудын хэрэглээг хялбарчлах, цаг хугацааг хэмнэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цахим шилжилтийг хэрэгжүүлэн ажиллах зорилт тавьсан.

2022 оны хувьд Мэдээлэл технологийн газрын зүгээс дотооддоо программ хөгжүүлэлтийг хийн Хууль, гэрээний цахим систем, Төлбөр, худалдан авалтын цахим системийг хийн бүрэн ашиглалтад оруулснаар ажилтнуудын үнэт цагийг хэмнэх, цаасны хэрэглээг бууруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг үр дүнг үзүүлсэн.

Мөн компанийн хэмжээнд шинээр хэрэгжүүлж эхлэх шүгэл үлээх тогтолцооны цахим системийг хөгжүүлэн ашиглалтад оруулсан бөгөөд уг систем нь мэдээлэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангаж чадсан бөгөөд ашиглахад хялбар ойлгомжтой болсноороо компанийн хэмжээнд ёс зүйтэй шударга орчныг бүрдүүлэхэд томоохон хувь нэмрийг оруулсан юм.

Түүнчлэн компанийн хэмжээнд Microsoft Teams-ийг нэвтрүүлснээр дотоод болон гадаад хэрэглэгчидтэй харилцаа холбоо тогтоох албан ёсны бөгөөд аюулгүй сувагтай болж мэдээлэл солилцоог энгийн хялбар, үр дүнтэй болгож чадсан.

Манай компанийн хувьд үйлдвэрлэлийн нарийн нягт олон процессуудтай тул программ хөгжүүлэлтийг хийж үйл ажиллагаа, санхүү бүртгэлийн системтэйгээ уялдуулан холбох нь бүтээмжид шууд нөлөөлдөг. Энэ онд анхан шатны үйлдвэрийн программын хөгжүүлэлтийг 91% гүйцэтгэлтэй амжилттай хийсэн.

Цаашид бид үйлдвэрлэл, үйл ажиллагаа, тогтвортой хөгжил болон гадаад дотоод борлуулалтын үйл ажиллагаатайгаа нэгдсэн байдлаар уялдсан цахим шилжилтийг шат дараатай хийхээр төлөвлөж байгаа бөгөөд 2023 онд Product Lifecycle Management-ийн Centric 8 системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр мөшгөлтийн системийг нэвтрүүлэн бүтээгдэхүүний эх сурвалжийг бүрэлдэхүүн тус бүрээр нь тогтоох, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг үр бүтээмжтэй хийх, өртөг тооцооллыг бүрэн автоматжуулах, бараа материалын эргэцийн удирдлагыг сайжруулах зэрэг олон боломжийг бүрдүүлэх юм.


Мөн түүнээс гадна ERP систем буюу бүтээгдэхүүний батлагдсан бодит загвар үйлдвэрлэлийн дамжлагаас хэрэглэгчийн гарт хүртэлх санхүү бүртгэл, үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт, агуулахтай холбоотой нөөц төлөвлөлтийг удирдах нэгдсэн системийн судалгааны ажлыг дуусган, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



ЖАККАРД ХЭЭТЭЙ НЭХМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ

Хээний онцлог болон өнгөнүүдийн ялгарлыг нарийн гаргах давхар үүсмэл нэхээстэй шааль нөмрөгний загварууд дээр 2022 онд туршилтын ажил хийгдэж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд худалдаанд гаргахаар ажиллаж байна. 2022 оны 12-р сард Алтай таван богд жаккард хөнжлийг худалдаанд гаргасан нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн шинэлэг бүтээгдэхүүн болж чадсан.



НАРИЙН ДААВУУНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ

Орчин үеийн загварын чиг хандлагын дагуу материал хөгжүүлэлтийн хүрээнд металл утас болох саатай утасны холиотой нарийн даавууны туршилт хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэн эцсийн бүтээгдэхүүн болгон хэрэглэгчдэд хүргэсэн.



WHOLEGARMENT ЗАГВАРЫН ХӨГЖҮҮЛЭЛТ

Дэлхийд анхдагч болсон WHOLEGARMENT машин дээр оёдолгүйгээр 3D хэмжээст сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулан загварын хөгжүүлэлтийг тасралтгүй хийн, капсул коллекц гарган, масс үйлдвэрлэлийг эхлүүлж олон улсын зах зээлд хэрэглэгчдэдээ хүргэсэн.



УТАСНЫ ЧАНАР САЙЖРУУЛАЛТ

Япон улсын Taiyoseni үйлдвэр дээр очин туршлага судалж, ээрэх машины тохиргоо, утас үйлдвэрлэх технологи ажиллагааг сайжруулснаар утасны тасралт 63% буурч, бүтээмж болон чанар сайжирсан.



ДАХИН БОЛОВСРУУЛСАН УТСААР ХИЙСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Орчин үед дэлхий нийтээр хог хаягдлаа багасгах эко хэрэглээнд анхаарлаа хандуулж хэрэглэгч сонголтоо хийхдээ байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг сонгодог болж, үйлдвэрлэгч бүтээгдэхүүнээ байгаль орчинд сөрөг нөлөө бага байх хэв маягийг зорин ажиллаж байна. Иймд манай Говь брэнд нь байгальд ээлтэй үйлдвэрлэлийн хүрээнд түүхий эдийн хаягдлаа дахин боловсруулж утас гарган, хүний биед тав тухтай загварлаг 100% ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдэдээ хүргэсэн.

ДЭЛХИЙН АЛДАРТ ДИЗАЙНЕРУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА



MARTIN PARKER

Говь ХК нь Английн дизайнер Martin Parker-тай 2019 оноос 2022 он хүртэл 2020, 2021, 2022 оны коллекцууд дээр хамтарч ажилласан. Martin Parker нь NEXT, Marks & Spencer, Debenhams, Pure Cashmere болон өөрийн Cut & Pin брэндүүдэд ажиллаж байсан ноолууран бүтээгдэхүүний салбарын туршлагатай дизайнер юм.

2022 оны хувьд түүнтэй хамтарсан SS-ийн Lounge Lizard-ийн коллекцийн зураг авалтыг UK-д хийж, West Coast коллекцийн зураг авалтыг Los Angeles-д тус тус хийж гүйцэтгэсэн. Хамгийн сүүлд ажилласан FW 22/23-ийн Retro, Rock 'n' Roll, Iconic коллекцууд 2022 намар борлуулалтад гарч, SS 23-ийн хавар зуны эрч хүчийг мэдрүүлсэн, өнгөлөг Mexicana Коллекци хүртэл амжилттайгаар хамтран ажиллалаа.



BETTINA LIRSCH

Хувцас загвар, тогтвортой хөгжлийн чиглэлээр 30 гаруй жилийн туршлагатай дизайн болон бүтээгдэхүүн хөгжлийн менежер Bettina Lirsch нь ZEGNA, Marni, Samsung зэрэг алдартай компаниудад зөвлөх болон дизайн хөгжүүлэлтийн менежерээр ажиллаж байсан туршлагатай.

Говь ХК нь 2022 оны 8-р сараас эхлэн бүтээгдэхүүний өмсгөл, мерчендайзинг төлөвлөгөө, веб сайтын өнгө төрх, бүтээгдэхүүний идэвхжүүлэлт, брэндийн лого судалгаа сайжруулалт зэрэг мерчендайзинг, дизайн болон борлуулалттай холбоотой олон зөвлөгөөг амжилттай авч ажиллаж байна.



GIORGIO SPINA

Дэлхийн загварын ертөнцийн төв гэгддэг Итали улсын алдарт дизайнер Жоржио Спина нь сүлжмэл утас болон хувцасны чиглэлээр мэргэшсэн дизайнер бөгөөд, түүний бүтээсэн сүлжмэл утсаар Dior, Giorgio Armani, LV, Max Mara, Chanel, Brunello Cucinelli, Alexander Wang, Moncler мөн Zegna зэрэг томоохон брэндүүд өөрсдийн загвараа урлаж хэрэглэгчдийн хүртээл болгож байснаараа онцлог юм.

Жоржио Спина нь Говь брэндийн ерөнхий дизайнераар ажиллах болсноор брэндийн өнгө төрх болон загвар, дизайныг хөгжүүлж, дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчиддээ хүргэхээр зорилт тавин ажиллаж байгаа билээ.

КОЛЛЕКЦУУД

Манай компанийн Дизайн хөгжүүлэлтийн газрын мэргэшсэн чадварлаг хамт олон 2022 онд борлуулалт, ашигт ажиллагаагаа дэмжих, хэрэглэгчдэдээ тогтмол шинэлэг бүтээгдэхүүнээр бэлэг барих зорилгоор сар бүр шинэ коллекц гаргаж, маркетингийн шинэлэг хэлбэрүүдийг ашиглах зорилт тавин ажилласан.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үндсэн коллекцтой зэрэгцүүлэн цөөн тоо ширхэгтэй капсул коллекцийн шинэ өнгө төрхтэй загварын хөгжүүлэлт дээр ажилласан бөгөөд үндсэн 5 коллекц, нэмэлт 17 капсул коллекцийг дотоод болон гадаадын зах зээлд хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ хүргэсэн.

ҮНДСЭН КОЛЛЕКЦ



БАРЛАСАН ШААЛЬ & ЦАГААН САР КОЛЛЕКЦ

Монгол хүний ур ухаан Итали технологийн гайхамшиг хосолсон "Нүүдэлчин амьдрал" барласан шаалийг Говь брэнд сар шинийн баярт зориулан урласан. Энэхүү бүтээл нь Монгол орны хөдөө тал нутгийн 4 зүг 8 зовхист байрлах газар зүйн үзэсгэлэнт байгалийн тогтоц, ан амьтан, аж ахуйн нүүдэлчин амьдралын онцлогийг нар зөв эргэх амьдралын алтан тойрогт багтаан урласан бүтээл юм.



RED КОЛЛЕКЦ

Гал халуун сэтгэл, дурлал хайрын бэлгэдэл, нэр хүнд, өөртөө итгэлтэй чанар, идэвхтэй амьдрал, эрч хүчийг тодотгодог улаан өнгийг сонгон авч тус коллекцоо гаргасан бөгөөд эмэгтэй хүний эрхэмсэг бардам зан чанар, сэтгэл татам хараа булаам дүр төрхийг тодотгосон силуэттэй загваруудыг улаан өнгөөр илүү хүчирхэг болгосноороо онцлогтой юм.



ГОВЬ ХАВАР/ЗУН 22
LOUNGE LIZARD КОЛЛЕКЦ

Бүхий л зүйлс шинэчлэгдэн өөрчлөгдөж, хувирч хувьсаж байдаг энэ цаг үед давтагдашгүй өнгө загваруудаас өөрчлөлтийг мэдрэх боломжтой. Зөөлөн ягаан, тод ягаан, цайвар шаргал, шоколадан бор болон шаргал туяатай өнгүүд таныг тодотгож эрч хүчийг сэргээсэн.



COAT КОЛЛЕКЦ

Классик хэрнээ өвөрмөц загварын шийдлүүдтэй орчин үеийн загварлаг хэв шинжийг тодотгосон энэхүү шинэ загварууд нь ямар ч насны бүсгүйчүүд, эрчүүд өдөр тутамдаа өмсөж болохуйц гэдгээрээ онцлог юм. Өдөр бүр, цаг тутамд бүхий л зүйл шинэчлэн өөрчлөгдөж, хувирч хувьсаж байгаа энэ цагт давтагдашгүй өнгө загвараар урласан ПАЛЬТО-ноос өөрчлөлтийг мэдрүүлэхийг зорьсон.



PINK КОЛЛЕКЦ

Говь брэнд дэгжин бөгөөд энхрий харагдуулах 2022 оны хаврын тренд болох сул өмсгөлтэй майк, кебель сүлжээтэй даашинз, богино кардиган, берет малгай, мөнгөлөг саан холиотой классик даашинз хантаазны хослол, oversize пальто зэргийг энэхүү коллекцдоо багтаасан.



ГОВЬ ХАВАР/ЗУН 22
WEST COAST КОЛЛЕКЦ

ЗЭРЭГ хандлага ӨӨДРӨГ сэтгэлийг илэрхийлэх Арт Деко урсгалын барилгуудын хурц, тод дулаан суурьтай, шохойн пастел өнгөнүүдээс санаа авсан. Энэхүү сэдэв нь одоо үед хэрэгтэй байгаа эерэг хандлага, өөдрөг байдлыг илэрхийлэхэд хамгийн тохиромжтой юм.



KIDS 2022 КОЛЛЕКЦ

Үргэлжийн адал явдал дурлаж байдаг хүүхдүүдэд хамгийн тав тухтай мэдрэмжийг төрүүлэх, инээд хөөрөөр бялхаж байдаг бяцхан үрсэд нь зөөлөн дулаан мэдрэмжийг бэлэглэх, бүхнээс хайр татам байдалд нь загварлаг төрхийг цогцлоох ноолуурыг бид бяцхан үрсэд зориулж урласан.



WHITE КОЛЛЕКЦ

Сэтгэл сэргээсэн зуны улирал ирэхтэй зэрэгцэн ариун сэтгэл, эрхэмсэг, тууштай байдлын илэрхийлэл болсон цагаан өнгийн загваруудаас бүрдсэн White коллекц-г хэрэглэгчиддээ танилцуулан хүргэсэн. Ноолууран ширхэгтийг саан утастай хослуулан гаргасан хагас бариу болон бариу хэлбэрийн загваруудаас бүрдсэн энэхүү коллекцоороо бид эмэгтэй хүний нандин болон тансаг эрхэмсэг байдлыг онцлохыг зорьсон.



ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 22-23 RETRO КОЛЛЕКЦ

Энэхүү коллекц нь 70-аад оны тренд болсон аливаа дүрэм журамд хязгаарлагдан баригдахгүй өөрийнхөө байх тэр л эрх чөлөө, эрч хүчийг мэдрүүлсэн чиг хандлагыг уусгаж өгснөөрөө онцлог юм. "Говь" брэндийн классик өнгөнүүд болох хар, саарал, тэмээний шаргал өнгөнүүдийг 70-аад оны чиг хандлагын гүн тод өнгөнүүдтэй хослуулж өгснөөр эрч хүчтэй, хүчирхэг байдлыг илэрхийлсэн.



CASHMERE REBORN КОЛЛЕКЦ

Хүн төрөлхтний тасралтгүй хүсэл, хэрэгцээгээр удирдуулсан зах зээлийн энэ эрин үед технологийн дэвшил бүхий л салбарт нөлөөлж эх дэлхийд эерэг болон сөрөг өөрчлөлтүүдийг авчирч эхэлсэн. Эдгээр эерэг өөрчлөлтүүдийн нэг нь үйлдвэрлэлийн хаягдал багатай бүтээгдэхүүн болон дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологиуд нэвтэрч буй явдал юм. Говь брэнд нь энэхүү коллекцоороо түүхий эдийн хаягдлаа дахин боловсруулж утас гарган, хүний биед тав тухтай загварлаг 100% ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ санал болгосон.



NAADAM КОЛЛЕКЦ

SARANTSATSRALT SER-OD X GOBI
Монгол наадам бол Монголд хайртай хүн бүрийн бахархан тэмдэглэх баяр юм. Үүнтэй адил Cashmere for all буюу бидний урласан ноолуурыг нас хүйс, зан байдал хувь хүний ялгаатай байдлыг харгалзахгүйгээр хүн бүхэн хэрэглэж болох бүтээгдэхүүн билээ. Энэхүү коллекц нь урлагаар дамжуулан үндэснийхээ хэв шинжийг, Монгол ахуй, байгалийн үзэсгэлэнг тодотгон дүрслэн бүтээснээрээ онцлог юм.



CASHMERE & SILK КОЛЛЕКЦ

Зуны нарлаг өдрүүдэд өмсөхөд хамгийн тохиромжтой сэрүү татам торго болон ноолуурын холиотой загваруудыг энэхүү коллекцоор дамжуулан хэрэглэгчиддээ санал болгосон. Шулуун болон хагас бариу өмсгөл зонхилсон Lounge wear хэв маяг бүхий энэхүү загварууд нь их хотын завгүй амьдарлын хэв маяг болон өдөр тутмын эрх чөлөөт хэв маягт бүрэн тохирсноороо хувцас загварын байнгын сонголт байх болно.



ГОВЬ НАМАР/ӨВӨЛ 22-23 ROCK'N ROLL КОЛЛЕКЦ

Хүчирхэг өнгө аясыг тодотгосон энэхүү коллекц нь шинэ төрлийн сүлжмэлийн нэхээс болон торон мэт сул нэхээсийг олон төрлийн хээгээр баяжуулан хар, ягаан, хилэн улаан өнгөтэй хослуулж өгсөн шинэлэг дүр төрхийг бүрдүүлсэн онцлогтой коллекц юм.



TRENCH & COAT КОЛЛЕКЦ

Говь брэнд нь загвар дурсамжийн илэрхийлэл болсон загварлаг "Пальто болон ЦУВ" шинэ коллекцоо намрын пальтоны улирлын нээлт болгон танилцуулав.



**ОРГАНИК НАМАР/ӨВӨЛ 22-23
APRES SKI КОЛЛЕКЦ**

Монгол орны онгон тагшин үзэсгэлэнт газар нутаглан амьдрах тайгын иргэд, цаатан соёл, өв уламжлалаа хадгалан өнөөг хүртэл байгаль эх дэлхий, ан амьтадыг хайрлан хамгаалж уламжлалт ёс заншлаа дээдлэн ирсэн ард түмэн билээ. Бид "Говь Органик" 22-23 намар өвлийн коллекцоо цаатан үндэстнээс аж ахуйгаас загварын урам зориг аван кебель болон бохо хээг онцлон бүтээв.



WHOLEGARMENT КОЛЛЕКЦ

Говь брэнд WHOLEGARMENT-ын загварын сонголтыг нэмэн капсул коллекцийн хөгжүүлэлтийг хийж эрхэм хэрэглэгчдэдээ олон төрлийн загваруудыг санал болгож байна. Энэхүү загваруудыг өдөр тутамдаа өмссөнөөр "Second skin" буюу хувцас өмсөөгүй мэт хөнгөн, тав тухтай мэдрэмжийг мэдрэх бөгөөд олон төрлийн хувцастай зохицдоогоороо онцлог юм. Говь брэнд Монголд анх удаа 2013 онд Wholegarment машиныг масс үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бөгөөд Wholegarment загваруудыг одоог хүртэл тасралтгүй хөгжүүлсээр ирсэн билээ.



LUREX КОЛЛЕКЦ

Шинэ жил бол өөрийгөө гэрэлтүүлэх хамгийн гайхалтай шалтгаануудын нэг. Цас бударч баярын уур амьсгал ирэхтэй зэрэгцэн саатай загваруудаас бүрдсэн өдөр тутамдаа болон баяр ёслолын үеэр өмсөхөд тохиромжтой ээлжит капсул коллекцоо танилцуулж хэрэглэгчиддээ хүргэсэн. Ноолуур болон саан утасны хослол нь үнэхээр сэтгэл татам...



X-MAS КОЛЛЕКЦ

Шинэ жилийн баярыг илтгэсэн улаан, цэнхэр өнгөний хослол бүхий сувдан хатгамал чимэглэлтэй тус загваруудад тухтай, хээнцэр, баярын уур амьсгал бүрдүүлэхүйц загвар дизайныг шингээн урласан. Ганган чимэглэлд дарагдсан гацуур мод, хүүхэд бүрийн хүсэн хүлээдэг цөмөөхэй балет зэрэг нандин хүсэл мөрөөдлийн биелэл нь үргэлж тантай хамт байг хэмээн билэгдэв.



BLACK КОЛЛЕКЦ

Хар өнгө нь хүчирхэг дүр төрхийг бүрдүүлдэг бөгөөд энэхүү коллекц нь нас харгалзахгүй бүх насныхан олон төрлийн хувцастай тохируулж өмсөж болох давуу талыг олгосноороо онцлог юм.



BURGUNDY КОЛЛЕКЦ

Улаан хүрэн өнгө нь хүнд өөртөө итгэх итгэл болон сүр хүчийг давхар илтгэдгээрээ маш хүчтэй өнгөний төрөлд багтдаг. Энэхүү хүчтэй өнгийг эмэгтэйлэг дур булаам байдлын илэрхийлэл болсон бариу силуэт, урт ханцуй болон чимэглэл гинж, гоёлын хуваалт, судал сүлжээтэй хослуулснаараа онцлогтой.



ACCESSORIES КАПСУЛ КОЛЛЕКЦ

100% ноолуураар урласан дахин давтагдашгүй загвар, өнгө зохицлын илэрхийлэмж бүхий Говь брэндийн аксессуар болох малгай, ороолт, бээлий, оймс нь хөнгөн, дулаан, тав тухтай мэдрэмжийг төрүүлэх юм.



БРЭНДҮҮД

GOBI

MONGOLIAN CASHMERE

Бүх насныханд зориулсан сонгодог загварын хувцас, аксессуар болон гэр ахуйн бүтээгдэхүүнээр дэлхийд танигдсан GOBI MONGOLIAN CASHMERE брэнд



GOBI ORGANIC

MONGOLIAN CASHMERE

Байгалийн үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг химийн будаг болон цайруулагч ашиглалгүйгээр урласан GOBI ORGANIC брэнд






Дэлхийн шилдэг дизайнерууд ур ухаанаа шингээн урласан дээд зэргийн чанартай, тансаг зэрэглэлийн YAMA брэнд



Орчин үеийн загварын чиг хандлагад нийцүүлэн бүтээлээ урладаг, тод өнгө, загваруудаар эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн шинэ залуу үеийн GOYO брэнд





Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр дулаахан, таатай, хөнгөн мэдрэмжийг бэлэглэх загварлаг үрсийн KID GOYO брэнд



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчин | Нийгэм | Засаглал

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Аливаа бизнесийн байгууллага зөвхөн ашгийн төлөө ажилладаг цаг үе ард үлдэж тогтвортой хөгжил, тэр дундаа нийгмийн сайн сайхны төлөө нэгдмэл зорилгыг бий болгон хамтран ажилладаг үе бидний өмнө ирээд байна.

Сонирхогч талуудын тогтвортой хөгжлийн мэдлэг ойлголт нэмэгдсэнээр аливаа компанийн амжилтыг зөвхөн санхүүгийн тайлангаар нь биш, харин ажилтан, хэрэглэгч, нийгэмдээ бүтээж буй үнэ цэнэ, хувь нэмрээр нь үнэлэн, тогтвортой хөгжлийн ногоон шилээр харж дүгнэдэг болоод байна.

Дээр дурдсан нийгмийн хүлээлт шаардлагаас гадна “Хариуцлагатай үйлдвэрлэл” эрхлэх нь компанийн нэр хүнд, үйл ажиллагааны тогтворжилт, өсөлт хөгжил мөн хэрэглэгчдийн сэтгэл хангалуун байдал, хөрөнгө оруулагчдын итгэл найдвар, санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэх, урт хугацаандаа компанийн үйл ажиллагааны зардлыг бууруулах зэрэг олон давуу талтай.

Говь ХК нь салбартаа түүчээлэгч байгууллагын хувьд цаг үетэйгээ хөл нийлүүлэн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “Хариуцлагатай үйлдвэрлэл”-д шилжих шаардлагатай гэж үзсэн. Уг шилжилтийг хийхэд зайлшгүй шаардлагатай ажлуудыг тодорхойлж, дорвитой арга хэмжээ авах зорилгоор 2021 оны 11 сард Тогтвортой хөгжлийн хэлтэстэй болсон билээ.

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд тус хэлтэс нь байгууллагын хэмжээнд баримтлах Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого, ойрын 3 жилийн зорилго зорилтыг тогтвортой хөгжлийн удирдлага, байгаль орчин, нийгэм, засаглал, салбарын үйл ажиллагаа гэсэн 5 хамрах хүрээнд боловсруулан батлуулж компанийн нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтоо нэгтгэх буюу Тогтвортой хөгжлийн соёлыг бий болгоход зорьж ажиллалаа.

Дээрх амлалт, зорилтуудын биелэлт нь зөвхөн байгууллагын удирдлага болон тогтвортой хөгжил хариуцсан ажилтнуудын зорилт биш, харин байгууллага хамт олны мэдлэг ойлголт, ажилтан бүрийн оролцоо, ханган нийлүүлэгчдийн хувь нэмрийн нэгдэлтэй салшгүй холбоотой юм.

БАЙГАЛЬ ОРЧИН

“ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” ШИЛЖИЛТИЙН ЯВЦ



ГОВЬ ХК – ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО /2022 – 2025/

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн бодлого нь байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд компанийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой явуулах, бүтээмж болон үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэл ба боломжийн хяналтыг сайжруулахад оршино.

Энэхүү бодлогын хэрэгжүүлэлт нь нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх сонирхогч талуудын хамтын ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг хангаж, компанийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулан, улмаар Монгол ноолууран хувцсаа дэлхийд таниулахад чиглэдэг.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

“Хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй гол асуудал бол уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин ба түүний тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөц баялгийг хамгаалах юм” гэдгийг сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд учирч буй байгалийн гамшиг, аюулт үзэгдлүүдээс харж болохуйц байгаа билээ. Харамсалтай нь та бидний хаана амьдарч буйгаас үл хамааран энэ асуудал дэлхийн хүн бүхэнд хамаатай. Тиймээс бид хожимдохоосоо өмнө уг асуудлын шийдлийг хамтдаа эрэлхийлж, хамтдаа ажил хэрэг болгоход хүн бүр гар бие оролцон хувь нэмрээ оруулах нь чухал.

Говь ХК нь үйлдвэрлэлийн бүх шат дамжлагадаа байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, байгалийн нөөц баялгийг хариуцлагатайгаар ашиглах зорилгоор Байгаль орчны удирдлагын “НОГООН ТОГТОЛЦОО”-г бий болгон тасралтгүй сайжруулан ажилладаг ба ажилтнуудынхаа байгаль орчинд хандах хандлага, мэдлэгийг сайжруулан “НОГООН СОЁЛ”-ыг төлөвшүүлэхээр зорьж байна. Энэ хүрээндээ Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт ISO 14001:2015-г үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.


Бид байгаль орчны хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгын “7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх”, “9. Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх”, “12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих”, “13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах”, “15. Хуурай газрын экосистемийг хамгаалах” гэсэн зорилгуудыг чиг үүргээ болгосон болно.



Бид дараах үзүүлэлтүүдийг онцлон, сайжруулалтыг хангах 3 жилийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэлтэд төвлөрөн ажиллаж байна.

<p>Эрчим хүч хэмнэх</p> <p>-20%</p> <p>Ус хэмнэлт ба дахин ашиглалтыг нэмэгдүүлэх</p> <p>+10%</p>	<p>Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх</p> <p>+15%</p> <p>Хог хаягдлын дахин ашиглалтыг нэмэгдүүлэх</p> <p>+30%</p>	<p>Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй CO₂-н ялгаруулалтыг бууруулах</p> <p>-10%</p> <p>“Хариуцлагатай” коллекцийн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх</p> <p>Боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ.</p>
---	---	--

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛГО 2025 БОЛОН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ 2025:

- Хүлэмжийн хийн ялгарлыг 10%-аар бууруулах
- Дахин цэвэршүүлсэн усны хэмжээг 10%-аар нэмэгдүүлэх
- Ногоон байгууламжийн талбайг 15%-д хүргэх
- Эрчим хүчний хэрэглээг 15%-аар бууруулах
- Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 20%-аар нэмэх
- Хог хаягдлын 30%-ийг дахин боловсруулах

УС

Үйлдвэрлэл явагдаж буй газар бүрд байгалийн нөөцийн асуудал болон байгальд үзүүлэх сөрөг нөлөө яригдах нь гарцаагүй. Ялангуяа байгалийн үнэт нөөц болох усыг зохистой хэрэглээг эрхэмлэх нь үйлдвэрлэгч бидний үүрэг билээ. Үүний тулд усны ухаалаг менежменттэй байх зайлшгүй шаардлагатай юм.

Манай байгууллага усыг дараах 3 зориулалтаар ашигладаг бөгөөд усны хэрэглээний нормыг цех бүрд тоолуураар нарийвчлан хянаж, усыг ариг гамтай бөгөөд үр ашигтай зарцуулахыг хичээдэг. Үүнд:

1. Үйлдвэрийн техникийн болон технологийн хэрэгцээнд
2. Ахуйн хэрэгцээнд
3. Усалгаа, гал унтраах зориулалтаар

Усны хэрэглээгээ төвлөрсөн шугамаас авдаг ба 1 ба 2-р шатны ус зөөлрүүлэгч шүүгчийг ашиглан усны хатуулгийг 2 дахин бууруулснаар үйлдвэрийн усны хатуулаг 2.5 мг-экв/л болж, ноос ноолуурын бүтээгдэхүүний чанар, технологийн усны стандартын шаардлагыг бүрэн хангадаг.

Говь ХК нь 2022 онд 125.1 мянган м³ ус ашигласан тооцоо гарсан бөгөөд цэвэрлэх байгууламжаараа дамжуулан 13,000 м³ бохир ус буюу нийт хэрэглээний 10%-ийг дахин цэвэршүүлэн ариутгах татуургын стандартад нийцүүлэв. 2022 онд авч хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:

- Усны хэмнэлттэй цорго суурилуулснаар 9 тонн ус хэмнэв.
- Агааржуулалтын хөргөлтийн усыг анхан шатны угаах үйлдвэрт дахин ашигласан бөгөөд нийт усны хэрэглээний 2.3% буюу 2.9 тонн литр усыг хэмнэсэн.
- Гал тогоо хоол үйлдвэрлэлийн хэсэгт цэвэр усны үндсэн шугам хоолой дээр ионжуулагч цэвэршүүлэгчтэй бөгөөд үйлдвэр, цех, оффисын орчинд ус цэвэршүүлэгч төхөөрөмжүүдтэй. Улирал тутам графикайн дагуу шүүлтүүрүүд сольж, цэвэр усны дээжийн шинжилгээг нийт 3 удаа хийлгэсэн.

Цаашид саарал усны технологийг нэвтрүүлэх, цэвэршүүлэх байгууламжийнхаа хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, усны мэргэжилтнүүдээ чадавхжуулах зэрэг ажлуудыг хийхээр төвлөрөн ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧ, CO₂-ЫН ЯЛГАРУУЛАЛТ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

Үйлдвэрлэл үйлчилгээний цар хүрээ өсөн нэмэгдэхийн хэрээр түүнд зарцуулагдаж байгаа эрчим хүчний хэрэглээ ч мөн адил өсөх хандлагатай байна. Цаашлаад улс эх орны эрчим хүчний хомсдолоос үүдсэн бизнесийн тасралтгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь 1,500 гаруй ажилтан төдийгүй оролцогч талуудынхаа өмнө хүлээсэн үүрэг гэж үзэж байна.

Манай байгууллага эрчим хүч хэмнэх арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд 2022 онд авч хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:

- Жил бүр хөдөлгүүрийн эрчим хүчний зарцуулалтыг бууруулах зориулалттай давтамж хувиргагч (инвертер) төхөөрөмжийг эрчим хүчний өндөр хэрэглээтэй төхөөрөмжүүдэд суурилуулав. Уг төхөөрөмжийг суурилуулснаар моторын эрчим хүчний зарцуулалтыг 30 хүртэлх хувиар багасгаж чадсан.
- “Хэмжиж чадвал Хэмнэж чадна” Байгууллагын цахилгаан эрчим хүчний хэрэглээг 24 цагийн турш хүний оролцоогүйгээр хянах боломжтой ухаалаг тоолууруудыг суурилуулав.
- Байгууллагын хэмжээнд эрчим хүчний хэмнэлттэй, хөдөлгөөн мэдрэгчтэй лед гэрлийг суурилуулав.

Тайлант онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2021 оноос 47%-аар өссөн боловч үйл ажиллагаандаа хэрэглэсэн эрчим хүчний хэрэглээ нь өмнөх онтой бараг ижил буюу 1.2%-ийн өсөлттэй байсан нь эрчим хүч хэмнэлтийн үр дүн юм.

Эрчим хүчний хэмнэлт нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шууд бусаар нөлөөлдөг бөгөөд тайлант онд 252 мян.кВт.ц эрчим хүч хэмнэснээр 189 тонн CO₂ ялгарахаас сэргийлж чадсан байна.

Бид Тогтвортой хөгжлийн бодлогодоо ногоон эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчийг (нарны панел) үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр тусгасан. Уг зорилтыг хэрэгжүүлснээр 2025 оны дотор жилийн нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний 14%-ийг (одоогийн дэд бүтэцдээ тулгуурлан тооцоолсон болно) сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжтой болох бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг дараах байдлаар бууруулна гэж төлөвлөж байна. Үүнд:



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Манай компани хог хаягдлын менежментийн хүрээнд холбогдох журмуудыг 2021 оны 10 сард шинэчлэн баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Хог хаягдлын журамд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах аргаар тусгасан байдаг.

Говь ХК-ийн үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг дараах байдлаар ангилан үзэж болно. Үүнд:

- Аюултай хог хаягдал
- Технологийн хог хаягдал
- Ахуйн хог хаягдал (хүнсний болон оффисоос гарч буй хог хаягдал)
- Худалдан авалтын дараах хог хаягдал

АЮУЛГҮЙ ХОГ ХАЯГДАЛ

Говь ХК нь MNS 6458:2014 стандартад нийцсэн химийн хорт болон аюултай бодисын 432 м² агуулахтай. 2021 онд нэгж бүтээгдэхүүнд ашигласан химийн бодисын хэмжээ нь 2.28 литр байсан бол 2022 онд ээрэх үйлдвэрийн будах алба зарим цайруулах бодисоос татгалзсанаар 2.21 литр болж 0.7 литрээр буурсан.




2022 онд байгууллагын хэмжээнд зай хураагуур цуглуулах зориулалтын хайрцгийг 13 цэгт нэмж байршуулснаар аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдалтай нийлэн хөрс, агаар, ус бохирдуулахаас урьдчилан сэргийлсэн бөгөөд 2,802 ширхэг баттерей цугларсныг мэргэжлийн байгууллагад шилжүүлснээр 2,802 м³ хөрсийг хордуулж, 22,416 тонн гүний усыг бохирдохоос сэргийлсэн.

ТЕХНОЛОГИЙН ХОГ ХАЯГДАЛ

Говь ХК нь түүхий эдийн анхан шатны боловсруулалтаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий цогц үйлдвэртэй.

Үйлдвэрлэлд ашиглахаар татан авсан нийт түүхий эдийн хувьд 50% нь хог хаягдал болдог. Уг хаягдлын 50%-ийг хялгас эзлэх ба бусад үйлдвэрийн түүхий эд болох боломжтой учир тус үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Үлдсэн хувийг бордоо (шороо, хаг, өтөг бууц) болгон ашиглаж эхлээд байна. Иймд түүхий эдээс гарч буй хог хаягдал нь бүрэн дахин ашиглагдах боломжтой байгаа юм.



Ээрэх, сүлжих, нэхэх, оёх шат дамжлагуудын явцад гарсан хаягдал буюу технологийн үлдэгдлийг 2022 онд CashmeReborn коллекцийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, мишок, хөнжил, дэрний дүүргэлт (зулхай), малын нэмнээ зэрэгт дахин ашигласан ба бусад бүтээлч санаачлагыг үргэлж дэмжин, ажил хэрэг болгохоор зорин ажиллаж байна.

АХУЙН ХОГ ХАЯГДАЛ

Ахуйн хог хаягдлыг цаас, хуванцар, хүнс, аюултай хог хаягдал ба бусад гэж 5 төрлөөр ангилдаг. 2022 онд 307 тонн хог хаягдал үүссэн ба үүний 26.3%-ийг гэрээт компаниудад шилжүүлэн дахин боловсруулсан.

ХҮНСНИЙ ХОГ ХАЯГДАЛ


Байгууллагын хэмжээнд 2022 онд сар бүр 440 кг буюу нийт 5.3 тонн хүнсний хаягдал гарсан. Үүнийг амьтны хоол тэжээл болгон ашиглахаар хувь хүнтэй байгуулсан хэлцлийн хүрээнд нийлүүлж хүнсний хаягдалдаа зохицуулалт хийж байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН ДАРААХ ХОГ ХАЯГДАЛ – САВ БАГЛАА БООДОЛ

Аливаа бүтээгдэхүүн хэрэглэгчдийн гарч хүрсний дараа сав баглаа боодол нь хог хаягдал болж хувирдаг. Худалдан авалтын дараах хог хаягдлыг багасгахын тулд Говь ХК сав баглаа боодолдоо нэг удаагийн гялгар уут хэрэглэхээс татгалзаж, дахин ашиглах боломжтой мяндсан уутыг хэрэглэсээр ирсэн. 2023 оны 3 дугаар улирлаас эхлэн хамгийн минимал, ногоон шийдэлтэй савлагааны иж бүрдэл бүхий бүтээгдэхүүн санал болгохоор судалгаа, хэрэгжүүлэлтийн баг бүрдүүлэн ажиллаж байна.

ХАРИУЦЛАГАТАЙ КОЛЛЕКЦУУД

Бид түүхэн хөгжлийнхөө явцад олон зуун жилийн түүхтэй ард иргэдийнхээ уламжлалт нүүдэлчин ахуйг орчин үеийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, инновацитай хослуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлж ирсэн төдийгүй хэрэглэгчдэдээ чанар, нийцэмжит үнэ, загвар, тогтвортой байдлыг амладаг.



Энэ амлалтынхаа хүрээнд хариуцлагатай коллекцуудынхаа үйлдвэрлэлийн тоо хэмжээг жил бүр нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд ингэснээр тогтвортой үйлдвэрлэл эрхлэх зорилгодоо хүрэхэд улам ойртож байгаа гэдэгтээ эргэлзэхгүй байна.

ОРГАНИК КОЛЛЕКЦ

Монгол ноолуур нь байгалийн 4 төрлийн өнгөтэй гэдгээрээ бусад улсын ноолуураас давуу талтай. Бид энэхүү давуу талаа ашиглан ямар ч будагч болон цайруулагч бодис ашиглахгүйгээр байгальд болон хүний биед хамгийн ээлтэй бүтээгдэхүүнийг энэхүү "Органик" коллекцоороо хэрэглэгчдэдээ хүргэдэг.

Органик коллекцийн онцлог:

- Ноолууран утсыг будахад химийн бодис хэрэглэдэггүй, усны өндөр хэрэглээнээс зайлсхийдэг.
- Эрчим хүчийг хэмнэж, CO₂-ын ялгаруулалтыг бууруулдаг.
- Ноолууран утасны байгалийн бүтцийг алдагдуулахгүйгээр, чанарыг нь хэвээр хадгалдаг.
- Байгалийн өнгө нь халуун дулаан мэдрэмжийг төрүүлдэг.

Органик коллекцийн давуу талыг тоогоор илэрхийлбэл:




3D БУЮУ WHOLEGARMENT КОЛЛЕКЦ - ОЁДОЛГҮЙ НООЛУУРАН

Оёдолгүй ноолууран бүтээгдэхүүн нь уламжлалт сүлжмэл бүтээгдэхүүнээс залгаа оёдолгүйгээрээ ялгаатай ба Shima Seiki сүлжмэлийн машинаар загварын программчлалын дагуу бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжин үйлдвэрлэдэг.

3D коллекцийн онцлог:

- Биед тав тухтай бөгөөд оёдол, холбоос байхгүй тул эмзэг арьстай хүн өмсөхөд нухаж холгохгүй.
- Байгаль орчинд ээлтэй. Эрчим хүч, ус бага зарцуулдаг, ажлын цагийн бүтээмж өндөр тул эдийн засгийн хувьд хэмнэлттэй.
- Технологийн үлдэгдлийг багасгадаг. Энэхүү коллекцийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд өнгө болон хээний зохицлоос шалтгаалсан технологийн хаягдал гардаггүй.
- Бүтээгдэхүүний насжилт өндөр. Нэхээс жигд, өндөр чанартай, үйлдвэрлэлийн хугацаа богино ба эдэлгээ удаан байдаг.

3D коллекцийн давуу талыг тоогоор илэрхийлбэл:



НИЙГЭМ

CASHMERE BORN КОЛЛЕКЦ - ХАЯГДАЛГҮЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Сүүлийн жилүүдэд байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах, ухамсартай үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Говь ХК олон санал санаачилга гаргаж байгаагийн нэг нь 2022 онд хэрэглэгчдэд хүргэсэн "CashmeReborn" коллекц юм. Уг коллекцоор бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад үүссэн технологийн үлдэгдлийг дахин ашиглаж, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж байна.

CashmeReborn коллекцийн онцлог:

- Хаягдалгүй үйлдвэрлэл. Энэ нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өндөр ач холбогдолтой.
- Ус, эрчим хүчний хэрэглээ, CO₂-ын ялгаруулалтыг бууруулдаг.
- Тус коллекцийн бүтээгдэхүүнүүд нь дахин давтагдашгүй өнгө, загвартай.

CashmeReborn коллекцийн давуу талуудыг тоогоор илэрхийлбэл:



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Говь ХК нь Тогтвортой хөгжлийн бодлогодоо “Нийгэм”-ийн хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгын “1. Ядуурлыг устгах”, “3. Эрүүл мэндийг дэмжих”, “5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах”, “8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох”, “10. Тэгш бус байдлыг бууруулах” гэсэн зорилгуудыг чиг үүргээ болгон Хүний нөөцийн хариуцлагатай менежмент буюу дотооддоо чиглэсэн, Нийгмийн хариуцлага буюу гадагшаа чиглэсэн гэж хоёр чиглэлд хуваан, тус бүрд нь тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ

Бид Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч, хувийн хэвшлийн томоохон ажил олгогчдын нэгийн хувьд ажилтнуудынхаа ажлын байрыг тогтвортой хадгалж нийгмийн асуудлыг нь хамтдаа шийдэж ажиллалаа. Мөн өмнөх онтой харьцуулахад шинээр 58 ажлын байр бий болгосон бөгөөд нийт 1,548 ажилтныг тайлант онд ажлын байраар ханган ажиллалаа.

Салбарын онцлогоос шалтгаалан манай байгууллагын хүний нөөцийн дийлэнх нь эмэгтэйчүүдээс бүрдэх бөгөөд удирдах, шийдвэр гаргах түвшинд ч эмэгтэйчүүдийн оролцоо давамгайлдаг. Тухайлбал, нийт ажилтны 68%, ТУЗ-ийн гишүүдийн 56%, Менежмент багийн 63%, дунд шатны удирдлагын багийн 80%-ийг эмэгтэйчүүд эзлэхээс гадна менежментийн багт Z үеийнхний төлөөлөл цөөнгүй ажиллаж байна.


Хүний нөөцийн бодлого журамд заагдсаны дагуу хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт зэргийг бид хүлээн зөвшөөрдөггүй. Цаашид тусгай хэрэгцээт ажилтны тоог нэмэгдүүлэх, ажлын байрны орчныг сайжруулах ажлуудыг үе шаттайгаар хийхээр төлөвлөж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ


НИЙТ АЖИЛТНУУДЫН ТОО 1,548




ХҮЙСИЙН ХАРЬЦАА




НАСНЫ АНГИЛАЛ



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



АЖИЛЛАСАН ЖИЛ



ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ




ГАДААД, ДОТООД СУРГАЛТАД ДАВХАРДСАН ТООГООР ХАМРАГДСАН



ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛЬ, КОМПАНИЙН ШАГНАЛААР ШАГНУУЛСАН



Хүний нөөц нь аливаа байгууллагын бүхий л нөөцүүд дундаас хамгийн үнэт нөөц баялаг билээ. Манай компани хүний нөөцийн удирдлагын дараах хамрах хүрээнд онцгойлон төвлөрч ажиллаж байна. Үүнд:



2022 оны хувьд дээрх хамрах хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан.

АЖИЛТНУУДЫГ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧНООР ХАНГАХ

Байгууллагуудын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд бол амин чухал үзүүлэлт билээ. Манай хамт олон “Нэгдүгээрт аюулгүй байдал” зарчмыг баримтлан, осол, осолд дөхсөн тохиолдол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдол, хугацаа алдсан гэмтлийн давтамжийг 0 байлгахыг зорьдог.

Уг зорилтын хүрээнд төлөвлөгөөний дагуу 2022 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэгт хэвийн бус нөхцөлд ажилладаг 300 ажилтан хамрагдсан. Тухайн ажилтнуудын үзлэгийн хуудас болон Эрүүл мэндийн байгууллагаас өгөгдсөн нэгдсэн тайлан, зөвлөмжийг хэрэгжүүлэх 3-5 жилийн “Эрүүл мэнд” хөтөлбөр, түүнд үндэслэн жил бүр ажилтнуудын “Эрүүл мэндийг чанаржуулах, хэвээр хадгалах төлөвлөлт” гарган ажиллаж байна.

2022 онд ХЭМАБ-ын хэлтсээс “Аюултай санагдвал ажлаа зогсоо” уриан дор аюулгүй ажиллагааг алхам тутамдаа ханган ажиллах зорилгоор давхардсан тоогоор 15,144 хүн/цагийн сургалт, зааварчилгаа өгч, 2,396,160 хүн/цаг нийт ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдалд онцгойлон анхаарч хугацаа алдсан гэмтэл осолгүй ажиллалаа.

Үүнээс гадна, манай байгууллага нь өөрийн ажлын байрандаа уламжлалт болон орчин үеийн эмчилгээг хослуулсан үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг яаралтай тусламжийн нэгжтэй. Тус нэгж нь ажилтнуудад эрүүл мэндээ анхаарах, урьдчилан сэргийлэх, эмчийн үзлэгт хамрагдах, анхны тусламж шуурхай авах боломжоор хангадаг. Энэ нь ажилтны цаг хугацаа, мөнгө санхүүг хэмнэх, эрүүл мэндийг хамгаалах өндөр ач холбогдолтой.

Ирэх жилүүдэд бид ажилтнуудынхаа “Сэтгэл зүйн эрүүл мэнд”-ийг дэмжих ажил болон “Цахим эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.



САЛБАРТАА ТЭРГҮҮЛЭХ ЦАЛИН УРАМШУУЛАЛ ОЛГОХ

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн бодлогод ажилтнуудын цалин урамшуулалтай холбоотой дараах заалтуудыг тусгасан байдаг.

- Ажлын байрны шаардлагын дагуу хөдөлмөр эрхлэх орчныг бүрдүүлж, ажилд авах, цалин олгох, шийдвэр гаргах, сургалт хөгжүүлэлт хийх, урамшуулал олгох, ажлаас гарах, тэтгэвэрт гарах зэрэгт ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш боломжоор ханган ажиллана.
- Мерит зарчмыг баримтлан ажилтны ур чадварыг үнэлж урамшуулан, чадварлаг хүний нөөцийг татах, тогтвортой ажиллах соёлыг бэхжүүлнэ.
- Хүний нөөцийн эргэцийг 20% хүртэл бууруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг 80% -аас дээш байлгах аар зохицуулан ажиллана.

Говь ХК-ийн цалингийн дундаж нь 2021 оны Монгол улсын цалингийн дундаж үзүүлэлтээс 12%-аар илүү ба эрэгтэй, эмэгтэй ажилтнууд цалингийн зөрүүгүй байгаа нь тэдний хөдөлмөрийг эрх тэгш үнэлж байгаагийн илрэл болно.

2023 оноос мэргэжлийн өндөр ур чадвартай, эерэг хандлагатай, хариуцлагатай ажилтнуудыг эх орондоо, хайртай дотны хүмүүсийнхээ дэргэд ажиллан, ур чадвараа үнэн зөвөөр үнэлүүлж, үүндээ тохирсон цалин урамшуулал авах таатай нөхцөлийг бүрдүүлэхээс гадна салбартаа тэргүүлэх цалин урамшуулалтай байгууллага болохоор зорин ажиллаж байна.

АЖЛЫН БАЙРНЫ ТААТАЙ ОРЧИН, АЖИЛ – АМЬДРАЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ



Сүүлийн жилүүдэд цар тахлын нөлөөллөөс гадна тогтвортой хөгжлийн мэдлэг ойлголт нэмэгдсэнээр ажлын таатай орчны талаарх сэдвүүд дэлхийн улс орнуудад хүчтэйгээр хөндөгдөх болсон. /Ялангуяа хамт олны ёс зүйтэй харилцаа, ажлын байрны тав тух, ажлын цагийн уян хатан байдал гэх мэт/

Өнгөрсөн онд манай байгууллага хүний нөөцдөө чиглэсэн доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Ажилтнууддаа ажил - амьдралаа тэнцвэртэйгээр зохицуулах боломж олгох зорилгоор уян хатан цагийн хуваарьтай болсон. Ингэснээр ажилтнууд үр хүүхдийнхээ цэцэрлэг, сургуулийнх нь цагийг ажлынхаа цагтайгаа тохируулах, ажлын хажуугаар сурах хөгжих боломж нэмэгдэх, замын түгжрэл, хоцролтоос үүсдэг санхүү болон сэтгэл санааны хохирлыг багасгах зэрэг давуу талуудтай юм.
- Ажилтнуудаа эрүүл тэжээллэг хоолоор хангах зорилгоор байгууллага өөрийн цайны газрыг 2 байршилд ажиллуулдаг. Манай мэргэжлийн тогооч нар “Тогооч нарын холбоо”-ны сургагч багштай зөвлөлдөн хоолны цэсийг шинэчилсэн ба 3 төрлийн давстай болон давсгүй төрлөөр хоолны сонголттойгоор витаминаар баялаг хүнсээр ажилтнууддаа үйлчилж байна. Ингэснээр ажилтнуудад мөнгө, цагаа хэмнэн, өөртөө цаг гаргах боломжийг олгодог.
- Байгууллагын ажилчдын автобусаар өдөрт 240 ажилтан үйлчлүүлдэг ба сард 5,280, жилд 63,360 иргэн монгол улсад машин унах шаардлагагүй болсон нь Улаанбаатар хотод 114.4 тонн CO₂ ялгаруулалтыг багасгахад өөрийн хувь нэмрийг оруулсан.
- 2022 онд байгууллагын яаралтай тусламжийн нэгж нь давхардсан тоогоор 3,774 ажилтанд өдөр тутмын үзлэг, эрүүл мэнд, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хамгийн олон давтамжтайгаар хийгдсэн үйлчилгээ нь тарилга (судас, булчин, дусал), шарлага, уламжлалтын эмчилгээ (бумба, зүү, төөнүүр гм) байлаа.
- Ажилтны сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх замаар байгууллагын соёлыг сайжруулах ажлын хүрээнд ажилтны ажиллах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор ажилтнуудын саналд үндэслэн ажлын байрны орчин нөхцөлийн засвар болон тохижилтын ажилд анхаарч, байнгын сайжруулан ажиллаж байна.

Говь ХК улсынхаа томоохон ажил олгогч байгууллагын хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагын дэргэдэх ажилтнуудынхаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгтэй болсон. **“ГОВЬ-ИЙН БАГАЧУУД”** цэцэрлэг нь бага, дунд, ахлах ба бэлтгэл гэсэн 4 бүлэгтэй, 120 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, стандартын шаардлага хангасан тохижилттойгоор Улсын тэргүүний 46-р цэцэрлэгийн салбар бүлгэм болон үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна.

Энэ нь манай байгууллагын 1,500 гаруй ажилтны 70% орчим нь эмэгтэйчүүд бөгөөд тэднийг тав тухтай ажиллах боломжоор хангах, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн хараат бус байдал, цаашлаад ажил болон хувийн амьдралын тэнцвэрт байдлаа хадгалахад нь эергээр нөлөөлөх чухал ажил гэж бид үзэж байна.



АЖИЛТНУУДЫН ХУВИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ БОЛОН МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРАА САЙЖРУУЛАХ БОЛОМЖООР ХАНГАХ

Тогтвортой үйлдвэрлэлд байгууллага хамт олноороо шилжихийн үндэс нь бүх шатны ажилтнууд Тогтвортой хөгжлийн нэгдсэн мэдлэг ойлголттой байх, ногоон соёлыг хэвшүүлэх, хэрэгжүүлэх явдал юм. Энэ хүрээнд Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн хэлтсээс Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд соёл түгээх аян болон 9,487.5 хүн/цагийн сургалт зохион байгууллаа.

Бид 2023 оноос компанийн “Шинэ ажилтны сургалт”-ын агуулгад Тогтвортой хөгжлийн ойлголтыг тусгаж байгаа бөгөөд ажилтан бүрийг компанийн уг соёлд нэгтгэх зорилготой юм.

Бид 2022 онд ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн хувьд чадавхжуулах нийт 246 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 8,662 ажилтан хамруулсан.

2022 онд ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан шилдэг ажилтнуудаа Итали, Франц, Герман, Япон, Солонгос зэрэг улс орнуудад урт болон богино хугацааны мэргэжлийн сургалтуудад хамруулж олон улсын стандартад нийцсэн ур чадварыг эзэмшүүлснээр Монголдоо чадварлаг хүний нөөцийн баялгийг бий болгоход хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Мөн шаардлагатай тохиолдолд ажилтнуудаа эх орноосоо олон улсын нэр хүндтэй байгууллагуудын сургалтуудад онлайнаар хамрагдах боломжоор ханган ажилладаг.

Цаашдаа компанийн хэрэгцээ шаардлага, ажилтны хувийн болон карьер төлөвлөлтөд үндэслэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтын хүртээмжийг нэмэхийг зорьж байна.

АЖИЛТНУУДЫН ЧӨЛӨӨТ ЦАГАА ЗӨВ БОЛОВСОН ӨНГӨРҮҮЛЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ

Үүнээс гадна ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, хамтдаа хөгжих, цагийг үр ашигтай өнгөрөөх, биеийн болон оюуны хөгжлийг дэмжих зорилгоор нийт 12 төрлийн “сонирхлын клуб”-ыг нээн үйл ажиллагааг нь тогтворжууллаа. Мөн энэхүү сонирхлын клубуудын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор спорт заал, иогийн өрөө, дартсын өрөө болон багийн ажиллагааны өрөөг ашиглалтад орууллаа.




НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Тогтвортой хөгжлийн бодлогын нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр төсөл, хөтөлбөр санаачилж, шаардлагатай төсөв батлан, хөрөнгө оруулалт хийж, гүйцэтгэлийг 90%-аас дээш ханган тогтвортой нийгмийг хамтдаа бүтээхэд өөрийн хувь нэмрийг оруулахаар тусгасан. Энэ зорилгын хүрээнд 2022 онд хийгдсэн дараах ажлуудыг онцолж байна.



ОРОЛЦОО ТӨСӨЛ

Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх уг төслийн оролцогчдыг дадлагажуулах үйл ажиллагаанд Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүд болон Төв аймагт нийт 4 удаагийн арга хэмжээнд оролцож, 3 удаагийн үйлдвэрийн аяллыг зохион байгуулах, ажлын байраар хангах зэргээр хамтран ажиллалаа.



АХМАДЫН АСРАМЖИЙН ГАЗАР

Нэхмэлийн үйлдвэрийн хамт олон технологийн үлдэгдлээ ашиглан холголтоос хамгаалах дэр хийж "Ахмадын асрамжийн газар"-т хүлээлгэн өглөө.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ, ЭХЧҮҮДИЙН ӨДӨРЛӨГ

Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн уулзалт өдөрлөгт" оролцож, хүүхдийн баярыг тохиолдуулан хүрэлцэн ирсэн хүүхдүүдэд гарын бэлэг өгөв.



ИРЭЭДҮЙН БАЯЛАГ БҮТЭЭГЧ ХӨТӨЛБӨР

Их дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнуудад зориулж өөрийн эзэмшсэн мэргэжилдээ эзэн байх, ирээдүйн баялаг бүтээгч болоход нь дэмжих зорилгоор "НИЙГМИЙН ЗӨВ ХҮН" харилцаа хандлагын сургалтыг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль болон Монгол Солонгосын Политехник Коллежийн оюутнуудад орлоо.




ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

УБТЗ, Говь Хангай мебель ХХК болон БОСА холдинг ХХК-ийн хамт олныг Тогтвортой хөгжил, ХЭМАБ-ын үйл ажиллагаатай танилцуулж, ISO9001:2015; ISO45001:2018 ба ISO14001:2015 стандартууд нэвтрүүлсэн туршлагаа хуваалцлаа.



НООЛУУРЫН САЛБАР




Монгол Улсад 2022 онд 27.6 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 сая буюу 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Манай улс 2022 онд 10.2 мянга орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 0.8 мянган тонн буюу 9 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 48 хувийг хангаж байна.

2022 онд ноолуурын дундаж үнэ 125 мянган төгрөг байсан нь өмнөх оноос 2 хувиар буурсан байна.


СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МОНГОЛ УЛСЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын ямааны тоо толгой /сая/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол улсын түүхий ноолуурын бэлтгэл /мянган тонн/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо /тооцооллын аргаар/

Түүхий эдийн дундаж үнэ /мянган төгрөг/



Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо

Ноолуурын зах зээл /тэрбум төгрөг/



/Түүхий ноолуурын дундаж ханшаар тооцоолов/

ТОГТВОРТОЙ НООЛУУР, ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ

Монгол улсын нийт хүн амын 9.6%, ажиллах хүчний 24.5% -г малчин иргэд эзэлдэг. Зонхилох буюу 98.1% нь уламжлалт аргаар, бэлчээрийн мал аж ахуйг, үлдсэн хэсэг нь фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг. "Малчдын аж байдлын судалгаагаар"* малчин өрхийн нийт орлогын 58%-г ямааны ноолуур дангаараа бүрдүүлдэг ажээ.

* "МУ-ын ноолуурын салбарын ТХ-ийн замын зураглал 2030" хуудас 16, УБ 2022

Сүүлийн жилүүдэд ямааны тоо толгой нэмэгдэж буй нь дэлхий дахинд ихээхэн шүүмжлэл дагуулах сэдэв болсон. Байгаль орчин, цөлжилтийн асуудлыг зөвхөн ямааны тоо толгойтой шууд холбон буруу ташаа ойлгож, гагцхүү тоо толгойг бууруулах нь зөв шийдэл гэж үзэхээс илүүтэй байгаль орчиндоо ээлтэйгээр, малчин иргэдийнхээ орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлөхгүйгээр уламжлалт мал аж ахуйн салбараа хөгжүүлэн авч үлдэх нь манай улсын хөгжлийн том сорилт болоод байна.

Говь ХК нь хөнгөн үйлдвэрийн салбарын түүчээлэгчийн хувьд дээрх асуудлын шийдэлд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад нэгдэж байгууллагынхаа байгаль орчин, нийгэм, засаглалын зорилгын хүрээнд "Тогтвортой ноолуур, гурван талт төсөл" -ийг хэрэгжүүлж буй юм.

Уг төсөл нь Шинжлэх ухаан – Үйлдвэрлэл – Мал аж ахуй эрхлэгчдийн уялдаа холбоог бэхжүүлж, малын эрүүл мэнд, тухайн орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр угсааг дэлгэрүүлэх, шинэ залуу малчдыг ямааны ноолуур бэлтгэлийн зөв технологид дадуулах, улмаар түүхий эдийн гарц, чанарыг сайжруулах юм. Нэг малаас гарах түүхий эдийн чанар, гарц сайжирснаар малын ашиг шим нэмэгдэж, тоо толгой багасан улмаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна мал маллагааны ачааллыг багасгах сайн талтай.

Тус төсөл нь 2025 оныг дуустал үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд Баянхонгор, Хөвсгөл аймагт ноолуурын чиглэлийн үүлдрийн ямаан сүргийн бүтцийг бий болгох, ямар нэг шат дамжлагагүйгээр, малчдаас ноолуурыг нь зах зээлийн үнээр шууд худалдан авах боломжийг бүрдүүлэхээр 3 дахь жилдээ амжилттай хэрэгжин ажиллаж байна.

Төслийн хүрээнд Мал үржүүлгийн технологийн үйл ажиллагааны нэгж (МУТҮАН) нь малын эрүүл ахуй, тавлаг байдлыг хангах болон үржил селекцийн ажлыг удирдан хийх мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг. Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС) нь ямааны аж ахуйн зохистой дадал хэвшүүлэх сургалтууд болон эрдэм шинжилгээний ажил, үржил селекцийн шинжлэх ухааны талаас зөвлөн оролцдог. Харин Говь ХК-ийн хувьд төслийг санхүүжүүлэхээс гадна өөрийн лабораторт ноолуурын чанарын шинжилгээг жил тутам хийж төслийг удирдан ажиллаж байна. Төсөлд хамрагдаж буй сумдын малчид шилмэл үүлдрийн ямаан сүргийн бүтэцтэй, ноолуур бэлтгэлийн зөв дадалтай болох давуу талтайгаас гадна ямааныхаа ноолуурыг зах зээлийн үнээр үндэсний үйлдвэрлэгчдэдээ шууд нийлүүлэх боломж нээгдэх юм.

Төслийн эхний хоёр жилийн үр дүнд шинжилгээний дээжид цуглуулсан ноолуурын голч 2.6% нарийсч, хаг, хогт хольц 36.2%, хялгас 17.2%-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна.






ЗАСАГЛАЛ

———— ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ————

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм. Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, олон улсын сайн засаглалын туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог. ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Мөн Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

Говь ХК нь ТУЗ-ийн үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт болон засаглалын үйл ажиллагаагаа илүү сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ханган ажиллах зорилгоор 2021 оны 9-р сард ТУЗ-ийн ажлын албатай болох шийдвэрийг гаргасан. ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулах, олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, засаглалын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, компанийн засаглалын асуудлыг хариуцах, хувьцаа эзэмшигч нарын санал хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх, мэдээ мэдээллээр хангах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Бид 2022 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ТУЗ-ӨӨС БАТАЛСАН БОДЛОГО, ЖУРМУУД

ШИНЭЧИЛСЭН

- Ёс зүйн код
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Олон нийтэд хүргэх мэдээллийн журам
- ТУЗ-ийн нэрэмжит шагнал олгох журам

ШИНЭЭР БАТАЛСАН

- Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт
- ТУЗ-ийн ажлын албаны журам
- Засаглалын бодлого
- Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
- Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг, нууц хадгалалтын гэрээний загвар

БОЛОВСРУУЛСАН

- ЭБАТ-уудын залгамж халааны бодлого
- ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмуудыг шинээр боловсруулж,
- Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэх төслийг бэлтгэсэн бөгөөд
- 2023 оны эхний ТУЗ-ийн хурлаар батлуулахаар төвлөж байна.

ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙГДСЭН АЖЛУУД

- БОНЗ-ын үнэлгээний тайланг анх удаагаа бэлтгэсэн бөгөөд компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээг 2 удаа хийн үр дүнгээ Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- Жилийн тайланд ногдол ашгийн бодлогын талаар оруулсан.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр Эрсдэл, аудитын хорооны зүгээс холбоотой талуудтай хийсэн гүйлгээний талаарх мэдээллийг танилцуулсан.
- Шүгэл үлээх тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор ТУЗ-ийн гишүүний гарын авлагыг боловсруулсан.
- Засаглалын бодлого, дүрэм журмуудын эмхэтгэлийг шинэчлэн боловсруулж ТУЗ-ийн гишүүд болон удирдлагын багийнханд хүргэсэн.

ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Говь ХК-ийн ТУЗ-өөс 2022 оны 11-р сард компанийн “Засаглалын бодлого”-ыг тодорхойлон баталсан.



Бид компанийн урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй засаглалын тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Энэхүү бодлогодоо үндсэн 9 агуулгын хүрээнд зорилго зорилтуудаа дэвшүүлж, засаглалын хувьд баримтлах зарчмаа тодорхойлсон.

ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

1. Оролцогч талуудын эрх ашгийг хангах
2. ТУЗ-ийн зохистой бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх
3. Тайлагнал мэдээллийн ил тод байдлыг хангах
4. Шударга ёс зүйтэй үйл ажиллагааг явуулах
5. Хяналтын тогтолцоог бүрдүүлэх
6. Компанийн соёлыг төлөвшүүлэх
7. Цалин урамшууллын зохистой системийг бүрдүүлэх
8. Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх
9. Компанийн засаглалыг сайжруулах


ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУД

- Ил тод байдлыг хангах
- Бүх оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах
- Хууль, дүрэм журмыг мөрдөх
- Шударга, ёс зүйтэй байх
- Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх
- Тасралтгүй сайжруулах

2022 оны хувьд Говь ХК-н хариуцлагатай засаглалын хүрээнд онцгой ахиц дэвшилтэй жил байлаа. Нэн ялангуяа байгууллагын ЁС ЗҮЙ, ХҮНИЙ ЭРХИЙН НИЙЦЭЛ-ийг нэг шатаар ахиулж чадсан гэдэгтээ бид итгэлтэй байна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Говь ХК нь бизнесийн үйл ажиллагаандаа бүхий л оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангахыг засаглалын бодлогынхоо зорилт болон зарчимд тусгасан. Үүнийхээ хүрээнд 2022 онд компанийн оролцогч талуудаа тодорхойлон, тэдний зүгээс компанийн үйл ажиллагаанаас хүлээх хүлээлт, сонирхлын түвшин, байгууллагад нөлөөлөх нөлөөллийн түвшин зэргийн тодорхойлсон.



Тайлант онд бид хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон олон нийтийг компанийн талаар үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах зорилгоор “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ыг шинэчлэн баталж, тус журмын дагуу компанийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны мэдээ мэдээллийнхээ агуулгыг сайжруулан, цахим хуудас (info.gobi.mn)-аараа дамжуулж тогтмол мэдээлэн ажилласан.

Мөн оролцогч талуудын оролцоог хангаж, санал хүсэлт болон өргөдөл гомдлыг хүлээн авах шийдвэрлэх процессоо улам сайжруулах зорилгоор “Оролцогч талуудын өргөдөл, санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн баталж, санал гомдлыг нь хүлээн авах сувгуудаа нэмэгдүүлэн, ирсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэн, үйл ажиллагаандаа санал хүсэлтийг нь тусган сайжруулж үр дүнтэйгээр хамтран ажилласан.

Ажилтнуудынхаа эрх ашгийг хангах чиглэн хүний нөөцийн хариуцлагатай менежментийг хэрэгжүүлж эрүүл, аюулгүй орчноор хангах, салбартаа тэргүүлэх цалин урамшуулал олгох, ажлын байрны таатай орчин бүрдүүлж, ажил амьдралын тэнцвэрт байдлыг бий болгосноор ажилтнуудын сэтгэл ханамжийг өсгөх, ажилтнуудын хувийн өсөлт хөгжил болон мэргэжлийн ур чадвараа сайжруулах боломжоор хангах чиглэлд төвлөрч ажилласан. Түүнчлэн нийгэм болон малчид руу чиглэсэн Тогтвортой ноолуур 3 талт төслийг үргэлжлүүлэн амжилттай хэрэгжүүлсэн.

Цаашид ТУЗ-ийн зүгээс оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг боловсруулан баталж тус бодлогын хүрээнд бүх оролцогч талуудынхаа ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдгээрийн зохистой тэнцвэрийг хадгалсан ажлуудыг хэрэгжүүлэн хамтран ажиллахаар төлөвлөж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Манай компани Монголын хөрөнгийн биржээс батлан гаргасан Хувьцаат компаниудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга” буюу компани өөрийгөө үнэлэх асуулгыг ашиглан Засаглалын өөрийн үнэлгээг 2017-2021 онуудад 5 жил хийж гүйцэтгэсэн.

Харин 2022 оны хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос 3-р сард “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсантай холбоотой Монголын хөрөнгийн биржийн зүгээс 2022 оны 6-р сард үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг ТУЗ-ийн ажлын алба хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулан, саналыг тусгасны үндсэн дээр ТУЗ-ийн дарга хянаж баталсан. Мөн манай компанийн өөрийн үнэлгээний үр дүнг Монголын хөрөнгийн биржийн зүгээс хараат бусаар давхар үнэлэн, нотолгоо баримтын хамт хянан үр дүнг баталгаажуулсан болно.


ГОВЬ ХК-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	10	83.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	9	90.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	4	66.7%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	6	75.0%
8	Компанийн соёл	6	6	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	9	90.0%
Нэгдсэн дүн		72	64	64	88.9%



Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 88.9% буюу дунд засаглалтай гэсэн үр дүнтэй гарсан байна. Энэ нь бидэнд анхаарч сайжруулах зүйлсээ олж харах боломжийг олгож байгаа бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид засаглалын түвшинд үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажиллахаар ТУЗ-ийн зүгээс төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Бүрэн хэрэгжүүлсэн Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай МХБ болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО
780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ТОО
23,172

/2022.12.31-ний байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН НЭР	ХУВЬЦААНЫ ТОО (ширхэг)	ЭЗЭМШЛИЙН ХУВЬ
Таван Богд Трейд ХХК	392,640,072	50.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%

Тайлбар: Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

ХИДЕ ИНТЕР ХХК нь Япон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм.

ТАВАН БОГД ТРЕЙД ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд Групп нь 23 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, нийт 12 мянга гаруй ажилтантайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын тэргүүлэгч групп компани юм.

АЖИЛТАНД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Говь ХК нь 2021 оны 6-р сард “Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр”-ийг албан ёсоор эхлүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 7-р сарын 20-ны өдрийн байдлаар ажиллаж байсан ажилтнууддаа компанийнхаа хувьцааг эзэмшүүлсэн. Ингэснээр ажилтнуудын хувьд өөрийн гараар бүтээсэн баялгаасаа хувь хүртэж, сэтгэл хангалуун бөгөөд тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг болохоос гадна ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.

2022 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн 1,053 ажилтан 574,100 ширхэг буюу 0.07% хувьцааг эзэмшиж байна. Цаашид ТУЗ болон компанийн удирдлагуудын зүгээс энэхүү хөтөлбөрөө үргэлжлүүлэн тогтмол хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	КОМПАНИЙН НЭРС	Д/д	КОМПАНИЙН НЭРС
1	Таван Богд Трейд ХХК	20	Таван Богд Хаус ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	21	Таван Богд Резиденс ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК	22	Мон Бийф ХХК
4	Монгол Машин Концерн ХХК	23	Таван Богд Финанс ББСБ ХХК
5	Таван Богд ХХК	24	Таван Богд Капитал ҮЦК ХХК
6	Эйрлинк Монголиа ХХК	25	Таван Богд Билдинг Саплай ХХК
7	Улаанбаатар Гурил ХХК	26	Таван Богд Мон Мийт ХХК
8	Жуулчин ХХК	27	Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК
9	Жуулчин Дюти Фрий ХК	28	Наран Кредит ББСБ ХХК
10	Файв Старс Ин Хархорин ХХК	29	Таван Богд Моторс ХХК
11	Таван Богд Хот Пот ХХК	30	Таван Богд Авто Маркет ХХК
12	Хаан Палас ХХК	31	Хаан Банк ХХК
13	Сэргэлэн Резорт ХХК	32	Замайн Сервисиз ХХК
14	Таван Богд Фүүдс ХХК	33	Дата Бэйнк ХХК
15	Таван Богд Фүүдс Пицца ХХК	34	Тэмүүжин Цогцолбор ХХК
16	Улаанбаатар Принт ХХК	35	Жуулчин Туризм Корпорейшн ХХК
17	Фүүд Сервис Солюшнс ХХК	36	Утаагүй Орчин ХХК
18	Таван Богд Солюшнс ХХК	37	Ар И Ди Эженси ХХК
19	Таван Богд Проперти ХХК	38	Ток Ток ХХК

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Овог нэр	Иргэний харьяалал	Эзэмшлийн хувь	
			Хувь хүн	Нэгдмэл сонирхолтой этгээд
1	Цагаач БААТАРСАЙХАН	Монгол	0.006%	Таван Богд Трейд ХХК 50.33% Таван Богд ХХК 0.40%
2	Хидэо САВАДА	Япон	-	Хиде Интер ХХК 34.00%

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага байна. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 23-ны өдрийн 11:00 цагт компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд амжилттай зохион байгуулагдсан.

ХУРЛЫН ИРЦ

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 284,538,863 саналын эрхтэй 1,046 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 405,499,195 саналын эрхтэй 95 хувьцаа эзэмшигч буюу нийт 690,038,058 саналын эрхтэй 1,141 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.45% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

ХУРЛААР ТАНИЛЦУУЛСАН АСУУДАЛ

1. Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. ТУЗ-өөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
3. 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
4. ТУЗ-ийн 2021 оны ажлын тайлан

ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. ТУЗ-өөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРДАЛ

/мянган төгрөг/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2021	2022	Өсөлт/бууралт %
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	16,478	21,825	32.4%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**ДАМБЫН
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга
Цалин урамшууллын
хорооны дарга,
Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн

Дамбын Гэрэлмаа нь 2013 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Аудитын хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин урамшууллын хорооны даргаар ажиллаж байгаад 2016 оны 10-р сараас эхлэн ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны дарга болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Д.Гэрэлмаа нь ЗХУ, Москва хотын Цахилгаан холбооны дээд сургуулийг Холбооны инженер эдийн засагч мэргэжлээр бакалавр, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Удирдлагын академи"-ийг Удирдахуйн ухааны чиглэлээр доктор зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Тэрээр Радио Телевизийн Техникийн Төвд эдийн засагч, Эдийн Засгийн Хөгжлийн Коллежийн Бизнес удирдлагын тэнхимд багш, тэнхимийн эрхлэгч, Монгол улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь элчин сайдын яаманд нягтлан бодогч, 2006 оноос СЭЗИС-д Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Сургалт эрхэлсэн дэд захирал, Бизнес удирдлагын тэнхимийн профессороор тус тус ажиллаж байгаад 2022 оноос СЭЗИС-ын Ахисан түвшний сургуулийн профессороор ажиллаж байна.



**ДАМБИЙЖАВЫН
ХҮРЭЛБААТАР**

Нэр дэвшүүлэх
хорооны дарга

Дамбийжавын Хүрэлбаатар нь 2008 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Цалин урамшууллын хорооны даргаар ажиллаж байгаад 2016 онд ТУЗ-ийн гишүүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн. Тэрээр 2022 оны 9-р сараас эхлэн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдсон бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллаж байна.

Д.Хүрэлбаатар нь Худалдааны техникумыг нягтлан бодогч мэргэжлээр бакалавр, Улс ардын аж ахуйн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Тэрээр Улсын Банкинд Улсын байцаагч аудитор, Худалдаа Хөгжлийн Банкинд Харилцагчийн үйлчилгээний газрын захирал, Монгол Шуудан Банкинд Дэд захирал, 2007 оноос Худалдаа Хөгжлийн Банкны Гүйцэтгэх захирлын орлогч, ТУЗ-ийн ажлын албаны даргаар тус тус ажиллаж байгаад 2022 онд тэтгэвэрт гарсан.



**МЯГМАРЫН
БАЯР**

Эрсдэл, аудитын
хорооны дарга

Мягмарын Баяр нь 2016 оны 9-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны даргаар тус тус ажиллаж байгаад 2022 оны 9-р сараас эхлэн Эрсдэл, аудитын хорооны даргаар ажиллаж байна.

М.Баяр нь Монгол улсын Техникийн Их Сургуулийг Оёдлын үйлдвэрийн технологич инженер мэргэжлээр бакалавр болон магистр, Франц улсын ENSISA, Инженерийн шинжлэх ухааны доктор, БНСУ-ын Конкук Их Сургуулийг Хувцас үйлдвэрлэлийн шинэ технологи (Digital fashion)-оор пост-доктор зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Тэрээр 1997 оноос ШУТИС-ийн ҮТДС-ийн Оёдлын тэнхимд багш, Хувцас Судлал, Дизайны профессорын багийн Ахлах багш, Дэд профессор, Тэргүүлэх профессор, Нэхмэл судлалын салбарын дэд профессор, Хувцас судлалын төвийн захирлаар ажиллаж байгаад 2021 оноос ШУТИС-ийн ҮТС-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессороор ажиллаж байна.



**АЛТАНГЭРЭЛИЙН
ЖАРГАЛМАА**

Эрсдэл, аудитын
хорооны гишүүн

Алтангэрэлийн Жаргалмаа нь 2019 оны 11-р сараас ТУЗ-ийн хараат бус гишүүнээр анх томилогдсон бөгөөд Эрсдэл, аудитын хорооны гишүүнээр ажиллаж байна.

А.Жаргалмаа нь Оксфорд Брүүксийн их сургуулийг Нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр, АССА-ийн олон улсын мэргэшсэн нягтлан бодогч, Хандонг Глобал их сургуулийг Глобал менежмент чиглэлээр MBA, Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Тэрээр СЭЗИС-д багш, Итезмон ХХК-д Нягтлан бодогч, Иаруди Консалтинг ХХК-д Зөвлөх, Дүнгээ ХХК-д Нягтлан бодогч, Бурий мэдвэдь ХХК-д Нягтлан бодогчоор ажиллаж байгаад 2017 оноос одоог хүртэл GAPE /Global Academy for Professional Education/-д АССА ахлах багш, хөтөлбөрийн удирдагчаар ажиллаж байна.



**Такэши
КАМБЭ**

Цалин урамшууллын
хорооны гишүүн

Такэши Камбэ нь Япон улсын иргэн бөгөөд 2008 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Цалин урамшууллын хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Такэши Камбэ нь Япон улсын Кэйогийн Их Сургуулийг Эдийн засгийн ухааны мэргэжлээр бакалавр болон магистр зэрэгтэйгээр төгссөн.

Тэрээр Япон улсын Asahi Mutual Life Insurance компанид Хүний нөөцийн менежер, Салбарын захиргааны менежер, Худалдааны менежер, Японы хамтын ажиллагааны банкны Гадаадын хамтын ажиллагааны эдийн засгийн фондын зээлийн мэргэжилтэн, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн Банкны хамтран Бангладеш, Шриланк, Мянмар улсуудад хэрэгжүүлсэн төслүүд, Азийн даатгалын компанийн Олон улсын хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын санхүүжилт зээлийн менежер, Гонгконг дахь Азийн хөрөнгө оруулалтын удирдагч, Удирдлагын зөвлөлийн дарга, Азийн үл хөдлөх хөрөнгө ХХК-ийн Зээлийн болон судалгаа шинжилгээний менежер, Номхон далайг хамгаалах нийгэмлэгийн гишүүнээр ажиллаж байсан бөгөөд одоо Азийн даатгалын хамтарсан компанийн үл хөдлөх хөрөнгийн арилжааны хяналтын менежерээр ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**ЦАГААЧИЙН
БААТАРСАЙХАН**

Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн

Цагаачийн Баатарсайхан нь 2007 онд Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажиллаж байгаад 2017 оноос эхлэн Нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Ц.Баатарсайхан нь Монгол улсын Политехникийн их сургуулийг Холбооны инженер мэргэжлээр бакалавр, Япон улсын Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургуулийг Электроникийн инженер мэргэжлээр бакалавр зэрэгтэй тус тус төгссөн.

Тэрээр 1995 онд Таван Богд Группийг үүсгэн байгуулсан бөгөөд Группийн Ерөнхий захирал, Таван Богд Трейд ХХК-ийн Ерөнхий захирал, Жуулчин ХХК-ийн Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирал, МИАТ компанийн Ерөнхий захирлаар ажиллаж байсан бөгөөд одоо Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Палас болон Хаан Палас зочид буудлын ТУЗ-ийн дарга, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



**ДАШДАВААГИЙН
ХУЛАН**

Эрсдэл, аудитын
хорооны гишүүн

Дашдаваагийн Хулан нь 2007 онд Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Аудитын хорооны гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажиллаж байгаад 2017 оноос эхлэн Эрсдэл, аудитын хорооны гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Д.Хулан нь Орос улсын Москвагийн Санхүүгийн Дээд сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр бакалавр, Монгол Улсын Их Сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Тэрээр Монгол Улсын Сангийн Яам, Гадаад харилцааны хэлтэст Эдийн засагч, Говь корпорацийн Токио дахь салбарт Борлуулалтын менежер, Таван Богд Трейд ХХК-ийн Тэргүүн дэд захирал, Худалдаа Хөгжлийн Банкинд Дэд захирлаар ажиллаж байсан бөгөөд одоо Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, Таван Богд Фүүдс ХХК болон Таван Богд Фүүдс Пицца ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн, Люксембургийн Монгол улс дахь өргөмжит консулаар ажиллаж байна.



**ЖАВЗАНДОЛГОРЫН
ОЮУНЧИМЭГ**

Цалин урамшууллын
хорооны гишүүн

Жавзандолгорын Оюунчимэг нь 2016 оны 9-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдсон бөгөөд Цалин урамшууллын хорооны гишүүн, Эрсдэл, аудитын хорооны гишүүнээр тус тус ажиллаж байгаад 2017 оны 12-р сараас эхлэн Цалин урамшууллын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Ж.Оюунчимэг нь Монгол улсын “Шавь” сэтгүүл зүйн дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр бакалавр, МУИС-ийн Монгол судлалын сургуулийг Судлаач багш мэргэжлээр бакалавр, Сэтгүүлч мэргэжлээр магистр, Удирдлагын академийг Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Тэрээр Монголын нүүрс Өнөөдөр сонинд Сэтгүүлч, Монгол нүүрс ХХК-ийн дэргэдэх Оюуны Өргөө Дээд Сургуульд Гүйцэтгэх захирал, Сургалтын албаны дарга, УИХ-ын тамгын газар, УИХ-ын гишүүний ажлын алба, Таван Богд Группийн Маркетингийн хэлтсийн даргаар ажиллаж байсан бөгөөд 2021 оноос Маркетингийн газрын захирлаар ажиллаж байна.



**ХИДЭО
САВАДА**

Хидэо Савада нь Япон улсын иргэн бөгөөд 2009 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр анх сонгогдсон.

Тэрээр Герман улсын Майнзын Их Сургуулийг Эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Хидэо Савада нь Интернейшнл түүрс компанийн үүсгэн байгуулагч, захирал, Австралийн дээрх Вотэмак зочид буудлын эзэн, Skymark Airlines компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, Эйч Ай Эс Кёрицу үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч, Токиогийн Хөрөнгийн биржийн толгой компани Смаймак үнэт цаасны ХХК-ийн Ерөнхийлөгч, H.I.S аялал жуулчлалын компанийн Ерөнхийлөгч, H.S үнэт цаасны компанийн Ерөнхийлөгч, Хаан банкны ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан бөгөөд одоо H.I.S компанийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ удаан хугацаагаар үүрэгт ажлаа биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон тухай 2022 оны 8-р сарын 30-ны өдөр ТУЗ-д албан бичгээр мэдэгдсэн. 2022 оны 9-р сарын 14-ний Нэр дэвшүүлэх хорооны хурал дээр түүний хүсэлтийн тухай хэлэлцэн, 9-р сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар Б.Нандин-Эрдэнэ гишүүнийг чөлөөлсөн.

Компанийн тухай хуулийн 77-р зүйлийн 77.5 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6.2-р зүйлийн 6.2.14 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох хүртэл Д.Хүрэлбаатар-ыг хараат бус гишүүнээр түр томилохоор шийдвэрлэсэн.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

Говь ХК нь компанийн дүрэмдээ заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгон 3 жилийн хугацаатай томилдог.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргадаг.

Говь ХК-ийн “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-ын дагуу Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлон, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар, эсвэл өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах гэсэн арга хэлбэрээс сонгон явуулдаг. Улмаар нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргадаг.

Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

2022.12.31-ний байдлаар


ТУЗ-ийн гишүүний нэр	Говь ХК-ийн хувьцааг эзэмшсэн байдал	
	Хувь хүн	Нэгдмэл сонирхолтой этгээдүүд
Д.Хулан	12,922,652 ширхэг (1.66%)	Таван Богд Трейд ХХК 392,640,072 ширхэг (50.33%)
Ц.Баатарсайхан	50,000 ширхэг (0.006%)	Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Хидэо Савада	-	Хиде Интер ХХК 265,238,300 ширхэг (34.00%)
Д.Хүрэлбаатар	4,800 ширхэг (0.0006%)	-

Дээрх хүснэгтэд нэр нь ороогүй ТУЗ-ийн гишүүд нь Говь ХК-ийн хувьцааг эзэмшдэггүй болно.

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг.

Хамгийн сүүлд 2018 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.



Харин урамшууллын хувьд Говь ХК-д мөрдөгдөж буй Цалин урамшууллын бодлого болон холбогдох журмын дагуу компанийн санхүү үр дүнгийн гүйцэтгэлээс хамааран урамшууллыг олгодог.

2022 ОНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн цалин урамшуулал	2021 он	2022 он	Өсөлт/бууралт %
Үндсэн цалин	128,400	128,400	0.0%
Оролцооны цалин	33,500	34,500	3.0%
Урамшуулалт цалин	12,486	10,000	-19.9%
НДШ	21,079	22,513	6.8%
Дүн	195,465	195,413	-0.0%

ТУЗ-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	6	9	56	59	20	18	40
Эрсдэл, аудитын хорооны хурал	4	1	23	11	26	11	5
Нэр дэвшүүлэх хорооны хурал	2	1	12	8	8	16	-
Цалин урамшууллын хорооны хурал	2	-	9	-	5	9	-
Нийт	14	11	100	78	59	54	45

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2022 онд нийт 14 ээлжит хурал болон 11 ээлжит бус хурал зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан 100 асуудлыг хэлэлцэн, 78 шийдвэр гаргаж, 45 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 59 санал зөвлөмж, 54 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав.

ХУРЛЫН ИРЦ

№	ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ-ийн хорооны гишүүнчлэл	ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-ийн хорооны хурлын ирц
1	Д.Гэрэлмаа	ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
2	Д.Хүрэлбаатар	Нэр дэвшүүлэх хорооны дарга	100%	100%
3	М.Баяр	Эрсдэл, аудитын хорооны дарга	100%	100%
4	А.Жаргалмаа	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	100%	100%
5	Такэши Камбэ	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
6	Ц.Баатарсайхан	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
7	Д.Хулан	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	100%	100%
8	Ж.Оюунчимэг	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
9	Хидэо Савада	-	100%	-

Тайлбар: Япон улсад байдаг хоёр гишүүд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, саналаа цахим шуудангаар илгээдэг. Тиймээс хурлын ирцийг оролцсоноор тооцдог.

ХУРЛЫН ДАВТАМЖ

Ээлжит хурал: ТУЗ-ийн хурал 2 сард нэг удаа буюу жилд 6 удаа, Эрсдэл, аудитын хорооны хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа, Цалин урамшууллын хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа хуралддаг.

Ээлжит бус хурал: ТУЗ болон хороодын ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн гишүүдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч хуралдуулж болно.

ТУЗ-ИЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2022 онд 6 удаа ээлжит хурал, 9 удаа ээлжит бус хурал зохион байгуулж 56 асуудлыг хэлэлцэн, 59 шийдвэр гаргаж, 40 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 20 санал зөвлөмж, 18 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж чиглүүлэн ажиллав.

Дэлхий нийтээрээ тогтвортой, ногоон хөгжил рүү шилжиж буй шинэ замналыг даган бизнесийн хэтийн төлөв, зорилго нь өөрчлөгдөн зөвхөн хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг бий болгоход бус компаниудын үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-д үзүүлэх үр нөлөөг тооцсон оролцогч талуудын урт хугацааны үнэ цэнэ, тогтвортой өсөлтийг бий болгоход чиглэж байна. Үүнтэй зэрэгцэн тогтвортой байдлын хүчин зүйлс нь хэрэглэгч харилцагчдын зүгээс худалдан авалт хийх, хамтран ажиллах шийдвэрээ гаргахад нөлөөлөх чухал бүрэлдэхүүн хэсэг болж өөрчлөгдөж байна. Хөрөнгө оруулагчид ч компаниудын үйл ажиллагаанаас үүдэлтэй учирч болзошгүй БОНЗ-ын эрсдэлүүд, тэдгээрийг удирдах, даван туулах чадавх, улмаар бизнесийн үнэ цэнийг бий болгох чадварыг нь илүү сайн ойлгохын тулд компаниудын тогтвортой байдлын стратеги, арга хандлагад илүүтэй анхааран санхүүгийн шийдвэрээ гаргах болсон.

Үүнтэй уялдан олон улсын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулан дэлхийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй манай компанийн хувьд үйл ажиллагааны бүхий л шатандаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулж, ажилтнууд болон оролцогч талуудынхаа эрх ашгийг ханган, засаглалын түвшинд үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан ажиллах зорилгоор 2021 онд Тогтвортой хөгжлийн хэлтэстэй болсон. 2022 оны хувьд ТУЗ-ийн түвшинд БОНЗ, тогтвортой байдлын асуудалд анхаарал хандуулж ажиллах зорилт тавин, ТУЗ-ийн гишүүд 3-р сард БОНЗ-ын чиглэлээр сургалтад хамрагдаж ойлголтоо нэгтгэн, цаашдын үйл ажиллагаандаа хэрхэн уялдуулж сайжруулалт шинэчлэлийг хийж явахаа тодорхойлсон бөгөөд 4-р сард “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”-ыг баталсан. Улмаар ТУЗ-ийн ээлжит хурал дээр нэг хурал өнжөөд БОНЗ-ын хүрээнд хийгдсэн ажлын тайлантай танилцаж, тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг чиглүүлэн ажиллалаа.

Бид ТУЗ-ийн үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор 8-р сард “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үүрэг оролцоог илүү нарийвчлан тодорхойлж оруулсан. Түүнчлэн жилд нэг удаа хараат бус гишүүдээрээ тусдаа хуралдан компанийн үйл ажиллагааны талаар хараат бусаар хэлэлцэн ажиллахаар болсны дагуу 12-р сард анхны хараат бус гишүүдийн хурлаа зохион байгуулсан. Мөн компанийн соёлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлж ажилласан бөгөөд 11-р сард ТУЗ-өөс “Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”-ыг батлан компанийн хэмжээнд шүгэл үлээх системийг хэрэгжүүлж эхэлсэн.

Бид компанийн засаглалын тогтолцоогоо сайжруулан, хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг ханган ажиллахад тогтмол анхаардаг ба 11-р сард “Засаглалын бодлого”-ыг тодорхойлон баталж, түүний хүрээнд “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулсан. Мөн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгын хүрээнд СЗХ-ноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон МХБ-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу “Олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-аа шинэчлэн баталж хэрэгжилтийг нь ханган ажилласан.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь компанийн нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдалд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавин чиглүүлэх, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар ТУЗ-ийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Эрсдэл, аудитын хороо нь 2016 оны 8-р сард хорооны үйл ажиллагааны дүрмээ шинэчлэн баталсан.

2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл аудитын хороо нь 2022 онд 4 удаа ээлжит хурал, 1 ээлжит бус хурал зохион байгуулж, 23 асуудлыг хэлэлцэн, 11 шийдвэр гарган 5 тогтоол баталсан. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 26 төрлийн санал зөвлөмж, 11 үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд 3-р сард Орос-Украин улсын хооронд үүссэн нөхцөл байдалтай холбоотой компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийн болон хариу арга хэмжээний талаар ээлжит бусаар хуралдан хэлэлцэж удирдлагуудад санал зөвлөмж өгсөн. Хорооны ээлжит хурлууд дээрээ Гүйцэтгэх удирдлагын зүгээс дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх ажлын явц, эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, тайлантай цаг тухай бүрд танилцаж удирдамжаар ханган ажилласан.

Эрсдэл, аудитын хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу Гүйцэтгэх удирдлагын зүгээс “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого”-ыг тодорхойлон баталсан ба оны сүүлийн хорооны хурал дээр Дотоод аудитын хэлтсийн 2026 он хүртэлх дунд хугацааны төлөвлөгөө болон 2023 оны төсөв, ажлын төлөвлөгөөг батлахаас гадна компанийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг шинэчлэх төсөлтэй танилцан, гишүүдийн зүгээс саналаа тусган ТУЗ-ийн хурлаар батлуулсан.

Мөн 2021 оны санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2022 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, санал өгч оролцон ТУЗ-ийн хурлаар Кэй Пи Эм Жи Аудитыг сонгов. Түүнчлэн хөндлөнгийн аудитын байгууллагаас аудитын бус үйлчилгээ авах процессыг хэлэлцэн, цаашид аудитын бус үйлчилгээ авах нөхцөл үүссэн тохиолдолд гэрээт ажил тус бүрээр хороонд танилцуулан зөвшөөрөл авдаг байхаар шийдвэрлэв.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Хүрэлбаатар

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан

ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг компанийн Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг сонгон шалгаруулах бодлогыг тодорхойлох, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Нэр дэвшүүлэх хороо нь 2017 оны 12-р сард хорооны үйл ажиллагааны дүрмээ шинэчлэн баталсан.

2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2022 онд 2 удаа ээлжит хурал, 1 удаа ээлжит бус хурал зохион байгуулж, 12 асуудлыг хэлэлцэн, 8 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 8 төрлийн санал зөвлөмж, 16 үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажиллав.

2022 оны 9-р сард ТУЗ-ийн хараат бус гишүүн урт хугацаагаар үүрэгт ажлаа биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон тухай хүсэлтээ өгсөн тул түүний оронд түр томилох гишүүнийг хэлэлцэх зорилгоор ээлжит бусаар хуралдан шийдвэрлэсэн.

Энэ онд тус хороо нь 2022 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг хэлэлцэв. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүдийн санамж бичиг, нууц хадгалалтын гэрээний загварыг хэлэлцэн баталсан бөгөөд “ТУЗ-ийн нэрэмжит шагнал олгох журам”-ыг шинэчлэх, “Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого”, “ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-ыг боловсруулах асуудлыг хэлэлцэн, сайжруулах санал оруулж ТУЗ-ийн хурлаар батлуулав.

Мөн Менежмент багийн удирдлагуудын хагас жилийн болон жилийн тайлантай танилцаж, тус тайланд гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцан үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв. Менежмент багийнхны жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав.

Тус хорооны оны сүүлийн хурал дээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн зүгээс ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх санал гаргасныг хэлэлцэн, 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлон батлав.

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ
ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг

ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь Төлөөлөн удирдах зөвлөлийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, тэдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах, компанийн цалин урамшууллын жилийн төсвийг батлан гүйцэтгэлд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино. Цалин урамшууллын хороо нь 2017 оны 12-р сард хорооны үйл ажиллагааны дүрмээ шинэчлэн баталсан.

2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2022 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 9 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 5 төрлийн санал зөвлөмж, 9 үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн хэмжээнд цалин урамшуулал, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлын тайлантай танилцсан. Мөн 2021 онд хэрэгжүүлж эхэлсэн “Хөрөнгө оруулагч ажилтан” буюу ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн явц, цаашид тус хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэн авч явах тухай хэлэлцсэн.


Говь ХК нь 2022 онд компанийн хэмжээнд цалин урамшууллын систем, гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээ шат дараатай шинэчлэх ажлыг хийсэн бөгөөд тус хорооны зүгээс энэхүү цалин урамшууллын шинэчилсэн системийн үр дүнтэй танилцан нэмэлт санал зөвлөмж удирдлагаар хангасан.

Мөн байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн болон түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Тус хорооны оны сүүлийн хурал дээр хорооны чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2023 оны цалин урамшууллын төсвийг баталсан. Мөн ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэн санал боловсруулсан бөгөөд 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулахаар төлөвлөж байна.

ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани дотоод хяналтын тогтолцоондоо “Хамгаалалтын гурван шугам” загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.



Хамгаалалтын I шугам:

Компанийн үндсэн үйл ажиллагааг явуулж буй нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын II шугам:

Компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг нэгжүүд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу өдөр тутмын хяналтыг давхар хэрэгжүүлж, тайлагнадаг.

Хамгаалалтын III шугам:

Гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтын тогтолцоо нь хэрэгжиж байгаа эсэх, оновчтой байгаа эсэх дээр баталгаажуулалтыг хийж, үндсэн чиг үүргийн хувьд Эрсдэл, аудитын хороонд, захиргааны хувьд Гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг.

ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГО

ТУЗ-ийн зүгээс 2021 оны 10-р сард компанийн Дотоод хяналтын бодлогыг боловсруулан баталсан. Тус бодлогын зорилго нь компанийн үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахтай холбоотой дараах харилцааг зохицуулах, нягтлан шалгах, хяналт тавихад оршино. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмын дагуу үр ашигтайгаар удирдан явуулах;
- Компанийн эд хөрөнгийг хамгаалах, найдвартай байдлыг хангах;
- Ашиглан, залилангийн үйлдэл болон алдаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, засах;
- Нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах;
- Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бодитоор бэлтгэн гаргах;
- Эрсдэлийг тогтмол хянах, удирдах;

Говь ХК нь дотоод хяналтыг Бүх ажилтан, Нэгжийн удирдлага, Гүйцэтгэх удирдлагын баг, Дотоод аудитын хэлтэс, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо, ТУЗ, Хөндлөнгийн аудит гэсэн шатлалтайгаар хэрэгжүүлнэ.

Дотоод хяналтын бодлогын баримт бичигт эдгээр оролцогч талуудын эрх, үүргийг тусган оруулсан бөгөөд ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан компанийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.

ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЗОРИЛГО

Дотоод аудитын зорилго нь компанийн засаглалын үйл явц, эрсдэлийн удирдлагын үр нөлөөтэй байдал, дотоод хяналтын үр ашигт байдалд үнэлгээ хийх тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэхэд оршино. Үйл ажиллагаандаа Олон улсын дотоод аудиторудын институтийн батлан гаргасан ёс зүйн дүрэм, үндсэн зарчмууд болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод аудитын үйл ажиллагаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Дотоод аудитын хэлтэс нь 1 хэлтсийн дарга, 2 ахлах аудитор, 3 аудитор гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. Эрсдэл, аудитын хороо нь Дотоод аудитын дүрэм, стратеги зорилт, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, нөөцийн төсвийг батлах, хэлтсийн даргыг томилж цалин урамшууллыг тогтоохоос гадна аудитын төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж, Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Компанийн зорилго, зорилтууддаа хүрэхийн тулд шийдвэр гаргалт, бодлого тодорхойлолт, бизнесийн болон дэмжих ажиллагааны процессууд, комплаенс болон тайлагналын үйл ажиллагааг хамруулан хуваарилагдсан үүрэг хариуцлагыг биелүүлж, чанартай гүйцэтгэл гаргаж байгаа эсэхийг баталгаажуулдаг.

2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

- Баталгаажуулах ажлаар нийт 71 анхаарах асуудлыг дэвшүүлэн үүсэж болох эрсдэл, шалтгааныг тодорхойлон, шийдвэрлэх санал, зөвлөмжөөр хангаж ажилласан.
- Мониторингийн ажлаар 9 багц бүхий 94 зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн дүгнэсэн.
- Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэхийг чухалчилсан.
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх удирдлагаас санал авч хэлэлцэн гүйцэтгэдэг бөгөөд шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлж, хамтран ажилласан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгсөн.
- Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээг өөрсдөө хийж, дотоод аудитын үйл ажиллагаанд анхаарах асуудлуудыг тодорхойлон сайжруулалтыг хийн ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЗОРИЛГО

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл өгөөжийн харьцаатай уялдуулан бизнест учирч болох аливаа эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар компанийн ашигт ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү үйл явц нь байгууллагын тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд компанийн ерөнхий үзэл баримтлал, үнэ цэнд нийцтэй удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулахад оршино.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр бизнесийн эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, ажилтнуудын эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулан, удирдлагын түвшинд стратегийн оновчтой шийдвэр гаргах, бизнесийн зорилго, зорилтыг дэмжихэд болон бизнест тулгарах алдагдал, хохирол, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Говь ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх эрсдэлийн засаглалын бүтэц нь "Гурван давхар хамгаалалтын шугам"-аар зохицуулагддаг.

Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь ТУЗ-ийн үндсэн зорилгуудын нэг юм. Эрсдэлийн удирдлагын 2-р шугамын хамгаалалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг хариуцан ажиллаж ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу улирал бүр хянах байдлаар эрсдэлийг удирддаг бөгөөд үр дүнгээ Эрсдэл, аудитын хороонд тайдагнадаг. Эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Тэргүүн дэд захирал ахлан ажиллаж байна.

2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэлийн удирдлагын хүрээ


- Говь ХК нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж ISO/IEC31000:2018 стандарт болон Хамгаалалтын гурван шугам загвар, олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөмж зэрэг олон улсын тэргүүн туршлагын дагуу байгууллагын үйл ажиллагааг сайжруулан холбогдох бодлого, журмаа шинэчлэхээр шат дараатай ажлуудыг эхлүүлээд байна.
- Энэ хүрээнд компанийн онцлогт тохирсон учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэх, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж, үүсэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахаар удирдан ажиллалаа.
- Байгууллагад ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг цаг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна.
- Байгууллагын хэмжээнд эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ, шинжилгээг хийн, эрсдэлийн нэгдсэн бүртгэл үүсгэн, үлдсэн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан эрсдэлийг үр дүнтэй зохистой түвшинд удирдах, удирдлагыг эрсдэлд суурилсан шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.
- Байгууллагын бүтэц зохион байгуулалтын дагуу эрсдэлийн удирдлагын багийн томилгоог шинэчлэн батлуулав.
- Эрсдэлийн аппетит (эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ хэмжээ) болон хүлцэх чадварыг илүү өргөн хүрээнд олон улсын ахисан түвшний арга, аргачлалд тулгуурлан гол эрсдэлүүд тус бүрээр шинэчлэн тодорхойлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлууд хийгдэж байна.
- Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн тайланг Эрсдэл, аудитын хороонд тогтмол тайлагнаж ажиллалаа.
- Компанийн үйл ажиллагаанд бодлогын чанартай баримт бичгүүд 2020 оноос хойш олноор шинээр батлагдсан байгаа учир тэдгээр бодлогуудтай уялдуулан Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн боловсруулсан бөгөөд тус бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэхээр төлөвлөж байна.

Эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хэрэгжилтийг байгууллагадаа бүрэн суулгах зорилтын хүрээнд:

- “Эрсдэлийн соёл”-ын судалгааны өнгөрсөн оны үр дүнд уялдуулан Эрсдэлийн соёл сайжруулах ажлуудыг хийсээр байна.
- Говь ХК-ийн нэгж бүр өөрийн хариуцдаг үйл ажиллагааны процессыг тодорхойлж, тухайн процесст оролцогчдийн чиг үүргийг тодорхойлон байгууллагын үйл ажиллагааны эрсдэлээс амжилттай хамгаалан ажиллаж байна.
- Ажилтнуудыг эрсдэлийн удирдлагын талаар мэдлэг ойлголтоор хангаж, тогтмол хөгжүүлэн сайжруулахаар зорьж байна.
- Эрсдэлийн хамгаалалтын 1-р шугамын Эрсдэл хариуцагч буюу нэгжийн удирдлагуудад “Эрсдэлээ хэрхэн үнэлэх”-ийн тулд эрсдэлийн ангилал бүрийг нарийн задлаж шинжиллээ.
- Эрсдэлийн үнэлгээний арга, аргачлалыг энгийн, ойлгомжтой тодорхой байдлаар загварлах, газар нэгжүүдтэй хамтран голлох эрсдэлүүдийн индикаторыг тодорхойлохоор ажиллаж байна.
- Эрсдэлийн удирдлагын сайн туршлагыг бий болгох, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхээр ажиллалаа.

2022 ОНЫ ЭРСДЭЛИЙН МОНИТОРИНГИЙН АРГА ХЭМЖЭЭ




2022 оны 1-р сарын байдлаар удирдах арга хэмжээ авах шаардлагатай 168 эрсдэл байсан бөгөөд дундаж оноо нь 7.3 буюу ДУНД түвшинд байв. Тайлант хугацааны туршид бид эрсдэлийн дундаж оноог оны эцэс гэхэд БАГА түвшинд хүргэнэ гэсэн зорилттой ажилласан билээ.

Эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулж хэрэгжүүлснээр 2022 оны 4-р улирлын эцэс гэхэд нийт 168 эрсдэл бүртгэлтэй байснаас 8 эрсдэл бүрэн хаагдаж, 160 эрсдэл болж буурсан бөгөөд дундаж оноо нь 3 буюу БАГА түвшинд байна. Эрсдэлийн удирдлагын баг нь эдгээр эрсдэлийг хяналтандаа байлгаж тогтмол удирдан ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Эрсдэлийг удирдахын тулд таван үе шаттай мөчлөг бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.



2022 ОНД ҮҮССЭН ЭРСДЭЛ БОЛОН АВСАН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Үйл ажиллагааны чиглэл	Үүссэн эрсдэл	Хариу арга хэмжээ
Санхүү удирдлага	<ul style="list-style-type: none"> Макро орчны нөлөөлөөр үүсэх гадаад валютын ханшийн эрсдэл, Үндсэн болон туслах материалын үнэ инфляциас хамааран өсөх эрсдэл үүссэн. 	<ul style="list-style-type: none"> Говь ХК-ийн гадаад борлуулалтаас валютаар борлуулалтын орлого орж ирдэг ба валютын борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх замаар ханшийн эрсдлээ бууруулж ажилласан. Үндсэн болон туслах материалын үнийн өсөлттэй уялдуулан бүтээгдэхүүний худалдах үнээ нэмж ашгийн маржинаа барьж ажилласан.
Гадаад/онлайн борлуулалт	<ul style="list-style-type: none"> ОХУ болон Украины дайны байдлаас шалтгаалан Европын тээвэрт эрсдэл нэмэгдсэн. БНХАУ-д “Zero-COVID” бодлого хэрэгжиж байсантай холбоотой хил гаалийн хяналт шалгалт өндөр, удаашралтай байгаагаас ачилт урьдчилан тооцоолсон хугацаанаас хоцрогдолтой очсон хэвээр байсан. 	<ul style="list-style-type: none"> Дайн дуустал Оросын вэбсайтаа хааж, дэлхий дахинд болж буй холбоотой мэдээ судалгааг тогтмол хийсэн. Экспорт хийх улс руу тээвэрлэлтийн асуудал үүссэн тохиолдолд хаагаагүй замаар тээвэрлэх боломжуудыг судлан, тухайн улсын хилийн ачааллыг урьдчилан тооцоолж тээвэрлэлтийг зохион байгуулж ажилласан.
Дотоод борлуулалт	<ul style="list-style-type: none"> Улс орны нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалан хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурах, цаашдын борлуулалтанд нөлөөлөх, Харилцагчийн үйлчилгээтэй холбоотой ёс зүйн болон харилцаа хандлагын эрсдэл гарах магадлалтай байсан. 	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийн гомдлыг сар бүр бүртгэн журмын дагуу 100% шийдвэрлэж ажиллав. Хэрэглэгчээс бэлэн бүтээгдэхүүнтэй холбоотой гомдол энэ онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.8% буурсан байна. Бизнесийн орчинд ёс зүйтэй харилцааг эрхэмлэх компанийн бүхий л оролцогч талуудад зориулсан “Шүгэл үлээх систем” ашиглалтанд оруулсан. Ёс зүй, хүний эрх, шүгэл үлээх тогтолцооны талаар НҮБГ-ын жендерийн зөвлөлтэй хамтран сургалтыг зохион байгуулсан. Ажилтнуудын “Харилцагчийн үйлчилгээний стандарт”-ын болон “Харилцааны ёс зүй”-н мэдлэг, ойлголтыг сайжруулахад анхаарч ажилласан.

Үйл ажиллагааны чиглэл	Үүссэн эрсдэл	Хариу арга хэмжээ
Үйлдвэрлэл/Ханган нийлүүлэлт	<ul style="list-style-type: none"> Улс орны эдийн засгийн өөрчлөлт, ОХУ Украины мөргөлдөөн, БНХАУ-ын “Zero-COVID” бодлогын хэрэгжилт зэргээс шалтгаалан түүхий эд материалын хомсдолд орох эрсдэл үүссэн. 	<ul style="list-style-type: none"> Тээвэрлэх хугацааг урьдчилан тооцоолж үйлдвэр төлөвлөлтөд тохируулан тээвэрлэлтийг зохион байгуулсан. Бараа материал болон түүхийн эдийн шаардлагатай нөөцийг зөв тодорхойлж, худалдан авалтуудыг урьдчилан тооцоолон, зохистой нөөцийг бүрдүүлсэн. Бараа материал болон түүхийн эдийн үлдэгдэлийн насжилтыг тогтмол тодорхойлж бууруулах арга хэмжээ авсан. Үйлдвэр төлөвлөлтийг цаг үеийн байдалтай уялдуулан уян хатан байдлаар төлөвлөсөн.
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Зах зээл дээрх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ огцом өсч (30-40%) ажилтнууд ажлаас гарч, гадаад руу явах нь нэмэгдсэнээс ажиллах хүчний хомсдолд орох эрсдэл үүсгэсэн. 	<ul style="list-style-type: none"> Түлхүүр ажилтныг тогтоон барих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн. Ур чадварын үнэлгээг сайжруулах, сургалтын хөгжлийн үйл ажиллагааг сайжруулж ажилласан. Нийгмийн халамжийн системийг сайжруулсан. Ажилтныг тогтвортой ажиллуулах зорилгоор бүтээмжийн нэмэгдлийг бий болгож, үе шаттайгаар цалин нэмэгдүүлэн ажиллаж байна.

ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдийг малчдын гараас хүлээн авахаас эхлэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ үндэсний болон олон улсын стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаад, онлайн сувгуудаар хэрэглэгчдэд хүргэдэг.

Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрээр чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, үндэсний 102 MNS стандарт, компанийн 16 бодлого, 134 журам, технологийн горим, 23 ажлын заавар, зааварчилгаа, 14 гарын авлагыг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас нь Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-TEKS байгууллагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг анх 2020 онд авч байсан бол 2022 онд гэрчилгээгээ 3 дахь удаагаа сунгасан.

Энэхүү гэрчилгээ нь хэрэглэгчдэд Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас ямар нэг химийн хортой бодис агуулаагүй бөгөөд хүний эрүүл мэндэд аюулгүй, найдвартай гэдгийг дахин нотлон харуулж байна.




Говь ХК-ийн Анхан шатны үйлдвэр нь 2022 онд Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" буюу SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 2 дахь удаагаа амжилттай хамрагдаж "Алтан батламжлал" гардан авсан.

Энэ нь анхан шатны үйлдвэртээ түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчиндоо ээлтэйгээр тогтвортой арга зарчмыг баримтлан үйлдвэрлэж буйгаа хэрэглэгчид, харилцагчиддаа нотлон харуулж буй хэрэг юм.



Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах зорилгоор 2021 онд MNS 6926:2021 "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл" Монгол Улсын Үндэсний стандарт батлагдан гарсан.

Говь ХК уг стандартын баталгаажуулалтад 2022 оны 5 болон 11-р саруудад амжилттай орж №01 тоот батламжийг гардан авснаар байгальд ээлтэй, зөв засаглалтай, хүнд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, менежментийн зөв тогтолцоог үйлдвэрлэлийнхээ шат дамжлага бүрт бий болгон ажиллаж буйг ийнхүү баталгаажуулав.




Говь ХК-ийн угааж самнасан ноолуур, ноолууран утас, ноолууран нэхмэл драп, нэхмэл, сүлжмэл, оёмол ноолууран бүтээгдэхүүн нь холбогдох стандарт, норматив техникийн баримт бичгийн шаардлагыг хангаж байгааг нотлох гэрчилгээг 3 жилээр сунгасан.

КОМПЛАЕНСЫН УДИРДЛАГА

Говь ХК-ийн тогтвортой хөгжлийн бодлого, зорилгод Ёс зүйн нийцлийг тодотгон тусгасан байдаг бөгөөд энэ хүрээнд авч буй арга хэмжээг комплаенсын удирдлагаар зохицуулдаг.

Комплаенсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь ажилтан, харилцагч болон дотоод, гадаад хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлэх, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.



Говь ХК нь 2022 онд Комплаенсын бодлого, зорилго зорилтуудыг баталсан. Уг бодлого нь НҮБ-н 17 зорилгын “5. Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэх”, “8. Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих”, “16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох” зорилгуудыг чиг үүргээ болгосон болно.

Мөн 2022 онд бид “Ёс зүйн код” болон “Үнэт зүйлс”-ээ шинэчилсэн билээ. Чанартай, загварлаг, тогтвортой, нийцэмжит үнэтэй тансаг ширхэгт Монгол ноолууран бүтээгдэхүүнээ дэлхийн хэрэглэгчдэд хүргэхийн төлөө манай хамт олон шинэчилсэн үнэт зүйлсэд нэгдсэн.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ ТОГТОЛЦОО


2022 онд хийсэн онцлох ажлын нэг бол “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо” -г нэвтрүүлсэн явдал байлаа. Уг ажлын хүрээнд шүгэл үлээх системийг ашиглалтад оруулах үйл ажиллагаанд ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа хүний эрхийн элч төлөөлөгчөөр сонгогдон ажиллалаа. Дээрх системд ирсэн мэдээллийг хамрах хүрээнээс нь шалтгаалан Төлөөлөн удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Ёс зүйн хороо шууд хүлээн авч, аливаа ёс зүйн зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, сайжруулах, шударга тогтолцоог ханган ажиллахаар зохицуулагдсан.

Ёс зүйн хорооны баг нь нийт ажилтны төлөөллөөс нээлттэй сонгуулийн зарчмаар сонгогдсон, тал бүрийн мэдлэг, ур чадвар, туршлага бүхий ажилтнуудаас бүрдсэн. Ингэснээр олон талт ялгаатай байдлыг эрхэмлэж ажиллана гэсэн үнэт зүйл биеллээ олох, тухайн гишүүд нь нэр дэвшсэн газар бүртээ ёс зүйн хэм хэмжээг түгээн нийт ажилтнуудад илүү нээлттэй ойр байх нөхцөл бүрдсэн.

Цаашид Ёс зүйн хороо болон Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааг сайжруулах, хянах, нийт ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг таниулах ажлуудыг тогтмол хийхээр төлөвлөж байна.

Комплаенсын хүрээнд хийсэн онцлох ажлуудыг цаг хугацааны дарааллаар жагсаавал:

2022 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД



КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дээд шатны удирдлага:

- Гүйцэтгэх захирлын шууд удирдлага дор Борлуулалт хариуцсан Тэргүүн дэд захирал, Дизайн, үйлдвэрлэл, дэмжих үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн дэд захирал, Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захиралтай болсон.

Санхүү удирдлагын газар:

- Санхүү удирдлагын газрын харьяанд байсан Менежмент удирдлагын хэлтсийн гүйцэтгэх үүргийг Хөрөнгө удирдлагын хэлтэс болон Санхүү төлөвлөлтийн хэлтэст шилжүүлсэн.


Онлайн борлуулалтын газар:

- Онлайн борлуулалтын газрын нэршлийг Гадаад борлуулалтын газар болгон өөрчилсөн.

Тогтвортой хөгжлийн газар:

- Тогтвортой хөгжлийн газарт харьяалагдаж байсан Тогтвортой хөгжлийн хэлтэс, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны хэлтсийг Дизайн, үйлдвэрлэл, дэмжих үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн дэд захирлын харьяанд шилжүүлж Тогтвортой хөгжлийн хэлтэс гэсэн бие даасан хэлтэс болгосон.

ГОВЬ ГРУППИЙН БҮТЭЦ



ГОВЬ ГРУППИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

2022 оны 3-р сарын 11-ний ТУЗ-ийн хурлын шийдвэрээр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад охин компани байгуулсан.

ОХИН КОМПАНИ, САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

№	Охин компанийн нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Кашмер Европ ХХК	Герман улс, Шонефелд хот	Худалдаа үйлчилгээ
2	Говь Кашмер Өвөр Монгол ХХК	Хятад улс, Эрээн хот	Худалдаа үйлчилгээ
3	Говь Кашмер Америк ХХК	АНУ, Лос Анжелес	Худалдаа үйлчилгээ
4	Говь Кашмер Их Британи ХХК	Их Британи улс, Лондон хот	Худалдаа үйлчилгээ
5	Гоёо Кашмер ХХК	Монгол улс, Улаанбаатар хот	Үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээ
№	Салбарын нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Австрали	Австрали улс, Сидней хот	Худалдаа үйлчилгээ



МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУД



Цагаачийн БААТАРСАЙХАН
Гүйцэтгэх захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 16 жил



Батчулууны АРИУНАА
Тэргүүн дэд захирал
/Борлуулалт/

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 10 жил



Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД
Тэргүүн дэд захирал
/Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 3 жил



Мэндсайханы ХИШИГМӨНХ
Гадаад борлуулалт хариуцсан
захирал /БНХАУ/

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 2 жил



Гантөмөрийн АНУДАРЬ
Экспортын борлуулалт хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 8 жил



Эрдэнэцэцэгийн ЗОЛЗАЯА
Үйлдвэр удирдлага хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 4 жил



Баатарсайханы АМАРСАЙХАН
Стратеги, өсөлт хөгжил
хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 3 жил



Отгонтөгсийн МИШЭЭЛ
Гадаад борлуулалт хариуцсан
дэд захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 6 жил



Батсуурийн БОЛОРМАА
Дизайн, үйлдвэрлэл хариуцсан
дэд захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 16 жил



Амарын УЧРАЛ
Дизайн хөгжүүлэлт хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 8 жил



Дүйхэржавын СОДГЭРЭЛ
Санхүү бүртгэл хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 12 жил



Төмөрсанаагийн БАЯСГАЛАН
Мэдээлэл технологи хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 1 сар



Батсүхийн ЭНХМАНДАХ
Санхүү хариуцсан
дэд захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 9 сар



Дэмбэрэлнямын СОЁЛМАА
Хүний нөөц хариуцсан
захирал

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 9 сар



Чулуунбатын ҮНЭНБАТ
Гадаад борлуулалт хариуцсан
захирал /Хойд Америк, Европ/

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 2 жил



Цогтбаярын ЦАСЧИХЭР
Хуулийн хэлтсийн дарга

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 9 жил



Мөнхбатын СЭЛЭНГЭ
Төлөөлөн удирдах зөвлөлийн
нарийн бичгийн дарга

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 6 жил



Нямжавын САЙНЗУЛ
Дотоод аудитын хэлтсийн
дарга

Говь ХК-д ажиллаж
буй хугацаа: 8 жил

МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУДЫН ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

Менежмент багийн удирдлагын нэр	Албан тушаал	Говь ХК-ийн хувьцааг эзэмшсэн байдал	
		Дангаараа	Нэгдмэл сонирхолтой этгээдүүд
Ц.Баатарсайхан	Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн	50,000 ширхэг (0.006%)	Таван Богд Трейд ХХК 392,640,072 ширхэг (50.33%), Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)
Ц.Оргилболд	Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/	-	
Б.Амарсайхан	Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал	1,000 ширхэг (0.0001%)	
Б.Ариунаа	Тэргүүн дэд захирал /Борлуулалт/	1,000 ширхэг (0.0001%)	-
О.Мишээл	Гадаад борлуулалт хариуцсан дэд захирал	1,000 ширхэг (0.0001%)	-
Б.Болормаа	Дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	1,000 ширхэг (0.0001%)	-
Ч.Үнэнбат	Гадаад борлуулалт хариуцсан захирал /Хойд Америк, Европ/	1,000 ширхэг (0.0001%)	-
М.Хишигмөнх	Гадаад борлуулалт хариуцсан захирал /БНХАУ/	800 ширхэг (0.0001%)	-
Г.Анударь	Экспортын борлуулалт хариуцсан захирал	800 ширхэг (0.0001%)	-
А.Учрал	Дизайн хөгжүүлэлт хариуцсан захирал	800 ширхэг (0.0001%)	-
Э.Золзаяа	Үйлдвэр удирдлага хариуцсан захирал	1,000 ширхэг (0.0001%)	-
Д.Содгэрэл	Санхүү бүртгэл хариуцсан захирал	800 ширхэг (0.0001%)	-
Ц.Цасчихэр	Хуулийн хэлтсийн дарга	1,000 ширхэг (0.0001%)	-
М.Сэлэнгэ	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга	185 ширхэг (0.0000%)	-
Н.Сайнзул	Дотоод аудитын хэлтсийн дарга	800 ширхэг (0.0001%)	-

Дээрх хүснэгтэд нэр нь ороогүй Менежмент багийн удирдлагууд нь Говь ХК-ийн хувьцааг эзэмшдэггүй болно.

МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУДЫН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Говь ХК нь ТУЗ-өөс батлагдсан Цалин урамшууллын бодлого болон Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан Цалин хөлс олгох журмын дагуу нийт ажилтнуудынхаа цалин хөлсний хэмжээг тогтоон, тооцон олгодог. 2022 онд компанийн хэмжээнд цалин урамшууллын системээ шинэчлэн, бүтээмж болон гүйцэтгэлд суурилсан цалингийн систем рүү шат дараатайгаар шилжсэн.

Менежмент багийн удирдлагуудын хувьд цалингийн бүтэц нь дараах байдалтай байна.

Үндсэн цалин

+

Гүйцэтгэлээс хамаарсан нэмэгдэл цалин /KPI/

- Компанийн борлуулалт, ашгаас хамаарсан үзүүлэлт
- Тухайн ажилтны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт

Харин урамшууллын хувьд Говь ХК-д мөрдөгдөж буй Цалин урамшууллын бодлого, Үр дүнгийн урамшуулал олгох журмын дагуу компанийн санхүү үр дүнгийн гүйцэтгэлээс хамааран тухайн жилийн бизнес төлөвлөгөөний борлуулалтын гүйцэтгэл, цэвэр ашгийн гүйцэтгэлийн тодорхой шалгуурыг хангасан үед урамшууллыг олгодог.

2022 ОНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Менежмент багийн цалин урамшуулал	2021 он	2022 он	Өсөлт/бууралт %
Цалин урамшуулал	1,350,688	1,566,703	16.0%

КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2022.12.31-ний хаалтын ханшаар 193,717,536,000 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	2022 он	Өсөлт/бууралт %
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /ширхэг/	780,112,500	780,112,500	-
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	325.64	248.32	-23.7%
Хамгийн их үнэ	393.62	311.50	-20.9%
Хамгийн бага үнэ	193.01	242.73	25.8%
Дундаж үнэ	270.67	272.19	0.6%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	4,338,588	1,234,986	-71.5%
Хамгийн бага /өдөрт/	2,768	392	-85.8%
Дундаж /өдөрт/	81,860	30,701.6	-62.5%
Нийт	20,464,962	7,552,604	-63.1%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	1,106,339,940	336,411,123	-69.6%
Хамгийн бага /өдөрт/	539,822	107,018	-80.2%
Дундаж /өдөрт/	22,492,411	8,519,435	-62.1%
Нийт	5,623,102,771	2,095,780,903	-62.7%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	254,035,834,500	193,717,536,000	-23.7%

НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

ТУЗ-өөс 2018 онд баталсан “Ногдол ашгийн журам”-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- 2.1 Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдан байна.
- 2.2 Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- 2.3 Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- 2.4 Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 2.5 Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- 2.6 Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- 2.7 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо /ширхэг/	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төгрөг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төгрөг/	НОГДОЛ АШИГ ТАРААЛТ
1996	7,801,125	61.00	475,868,625	
1997	7,801,125	153.80	1,199,813,025	
1998	7,801,125	150.00	1,170,168,750	
1999	7,801,125	166.00	1,294,986,750	
2000	7,801,125	100.00	780,112,500	Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
2001	7,801,125	20.16	157,270,680	
2005	7,801,125	60.00	468,067,500	
2006	7,801,125	60.00	468,067,500	
2010	7,801,125	100.00	780,112,500	
2011	7,801,125	100.00	780,112,500	
2012	7,801,125	125.00	975,140,625	
2013	7,801,125	130.00	1,014,146,250	Компани дээрээ тараах болон ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх аргыг хослуулан 100% тараасан.
2014	7,801,125	140.00	1,092,157,500	
2015	7,801,125	140.00	1,092,157,500	
2016	7,801,125	200.00	1,560,225,000	
2017	7,801,125	220.00	1,716,247,500	
2018	780,112,500	6.80	5,304,765,000	
2019	780,112,500	-	-	
2020	780,112,500	-	-	Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
2021	780,112,500	-	-	
2022	780,112,500	-	-	

2022 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2-р сарын 3-ны өдрийн №2 тоот тогтоолын дагуу 2022 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.



ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ
ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН
2022 ОНЫ 12-Р САРЫН 31

ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэн батлуулдаг. Мөн хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавихаас гадна удирдлагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж чиглүүлэн ажилладаг.

Говь ХК-ийн 2022 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайланд Кэй Пи Эм Жи Аудит ХХК хөндлөнгийн аудит хийсэн. Гэрээний дүн 228,174,328 төгрөг.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2013 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн.

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ
ОХИН КОМПАНИУД

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12-Р САРЫН 31

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД:

Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан	1
Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	2
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	3
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан	4
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд	5

Ерөнхий мэдээлэл

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	Д. Гэрэлмаа
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд	Ц. Баатарсайхан Д. Хулан Ж. Оюунчимэг Хидэо Савада
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд	Такэши Камбэ Д. Хүрэлбаатар М. Баяр А. Жаргалмаа
Нарийн бичгийн дарга	М. Сэлэнгэ
Харилцагч банкууд	Хаан Банк Голомт Банк Хас Банк Худалдаа Хөгжлийн Банк Америкийн Банк Корпораци Дойче Банк Эй Жи Хятадын Бүтээн Байгуулалтын Банк Корпораци
Албан хаяг	Говь үйлдвэрийн байр, үйлдвэрийн гудамж Хан-Уул дүүрэг, 3-р хороо Улаанбаатар-17062, Монгол улс
Хараат бус аудитор	КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай Тауэр, 602 тоот

Гүйцэтгэх Удирдлагын Мэдэгдэл

Говь ХК-ийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.


Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Группийн удирдлага нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үгэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн удирдлага нь Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үгэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 4-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг удирдлага шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.



Ц. Баатарсайхан
ГОВЬ ХК-ийн удирдлагын
Гүйцэтгэх Захирал

Б. Энхмандах
Санхүү Хариуцсан Дэд Захирал

Улаанбаатар хот,
Монгол Улс

Онгоо: 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас: +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Говь Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Говь ХК (цаашид "Толгой Компани" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС-ын Стандартууд (цаашид "СТОУС-ын Стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЕЗОУС3-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бус байж, НБЕЗОУС3-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.



Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 25.1, мөн Тодруулга 2.12-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
<p>Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Бид борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхэд уг эрсдэлийг авч үзсэн ба уг эрсдэлийг удирдлагад үүсч буй төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалтаас үүдэлтэй байж болно гэж тодорхойлсон.</p> <p>Дээрх зүйлстэй холбоотойгоор бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.</p>	<p>Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд:</p> <ul style="list-style-type: none"> - Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн оршин байх, үнэн зөв байх болон цаг хугацаанд нь бүртгэх зэрэг хяналтуудыг шалгасан. - Бид Группийн хэрэгжүүлсэн борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх бодлогыг удирдлагатай ярилцлага хийх, борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч буй цаг хугацааг холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг борлуулалтын гэрээнүүдээс түүвэр байдлаар сонгон ажил гүйлгээний хүргэлтийн нөхцлүүдийг ойлгох үүднээс нягтлан шалгасан. - Борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн дуусгавар болох хугацааны үед хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнүүдээс түүврээр сонгон авч бараа материалын зарлагыг илэрхийлэх баримтууд, борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч талаас хүлээн зөвшөөрсөн холбогдох баримт бичгүүдтэй тулган шалгасан. - Бид Группийн борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээлэлд үндэслэн борлуулалтын орлогыг дахин тооцоолж үзсэн. - Бид Групп болон түүний худалдан авагч нарын хооронд хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнд тулган баталгаажуулалт хийх гэх мэт аудитын горимтуудыг хэрэгжүүлсэн. - Бид тайлант жилийн дараа үед хийгдсэн борлуулалтын буцаалтууд болон худалдан авагч нь бодитой байсан эсэхийг шалгасан. - Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан.



Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бүүруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс уг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Гүн Пён Шиг, аудитын компанийн Ерөнхий Захирал нь Г. Соёлмаа нар болно.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Баталгаажуулсан:

Г. Соёлмаа
Ерөнхий Захирал

Баталсан:

Гүн Пён Шиг
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2022	2021
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	9,034,919	4,389,479
Урьдчилгаа	7	2,318,495	2,509,612
Дансны болон бусад авлага	6	3,318,986	2,258,129
Бараа материал	8	128,791,463	138,030,372
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	9	17,227	-
		143,481,090	147,187,592
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	137,432,575	145,404,533
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	11	731,724	1,328,307
Хойшлогдсон татварын хөрөнгө	24.3	14,879,483	4,634,777
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	13	1,587,295	1,612,453
		154,631,077	152,980,070
Нийт хөрөнгө		298,112,167	300,167,662
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны болон бусад өглөг	14	20,969,192	15,982,955
Гэрээний өр төлбөр	14.1	1,983,898	1,370,281
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	15	26,503	-
Богино хугацаат түрээсийн өглөг	16	777,988	914,850
Орлогын албан татварын өглөг	24.2	3,683,126	111,894
Богино хугацаат зээл	17	129,853,617	132,650,889
		157,294,324	151,030,869
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат түрээсийн өглөг	16	112,069	672,587
Урт хугацаат зээл	17	95,686,234	93,407,780
Бусад урт хугацаат өглөг	18	30,984,941	25,622,107
Хойшлогдсон татварын өр төлбөр	24.3	8,206,834	309,195
		134,990,078	120,011,669
Нийт өр төлбөр		292,284,402	271,042,538
Эздийн өмч			
Хувьцаат капитал	19	780,113	780,113
Дахин үнэлгээний нөөц	22	44,568,540	48,870,401
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	23	(11,436,010)	561,878
Хуримтлагдсан алдагдал		(28,084,878)	(21,087,268)
Нийт эздийн өмч		5,827,765	29,125,124
Нийт өр төлбөр ба эздийн өмч		298,112,167	300,167,662

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2022	2021
Борлуулалтын орлого	25.1	193,427,609	144,344,329
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25.2	(97,766,831)	(85,543,487)
Нийт ашиг		95,660,778	58,800,842
Бусад орлого	27.1	1,162,425	853,608
Борлуулалт ба маркетингийн зардал	25.4	(61,767,484)	(60,568,067)
Ерөнхий ба удирдлагын зардал	25.5	(14,138,399)	(14,636,714)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	31.1	49,464	16,378
Бусад зардал	27.2	(13,355)	(78,409)
Үйл ажиллагааны ашиг (алдагдал)		20,953,429	(15,612,362)
Санхүүгийн орлого	26	29,261	2,974,464
Санхүүгийн зардал	28	(30,979,282)	(25,474,286)
Татварын өмнөх алдагдал		(9,996,592)	(38,112,002)
Орлогын албан татварын өгөөж	24	2,998,982	165,974
Тайлант жилийн цэвэр алдагдал		(6,997,610)	(37,946,028)
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	10, 22	-	(104,435)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл	22	(4,301,861)	-
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой зүйлс			
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	23	(11,997,888)	1,923,910
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого		(16,299,749)	1,819,475
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(23,297,359)	(36,126,553)
Нэгж хувьцаанд ногдох алдагдал			
Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)	21	(8.97)	(48.64)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

Тодруулга	Хувьцаат капитал	Дахин үзлэгээний нооц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц		Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,974,836	(1,362,032)	16,858,760	65,251,677	
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(37,946,028)	(37,946,028)	
Бусад дэлгэрэнгүй орлого	22, 23	(104,435)	1,923,910	-	1,819,475	
Зарласан ногдол ашиг	20	-	-	-	-	
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,124	
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,124	
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>						
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,997,610)	(6,997,610)	
Бусад дэлгэрэнгүй орлого	22, 23	(4,301,861)	(11,997,888)	-	(16,299,749)	
Зарласан ногдол ашиг	20	-	-	-	-	
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,436,010)	(28,084,878)	5,827,765	

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2022	2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн цэвэр алдагдал			
		(6,997,610)	(37,946,028)
Тохируулгууд:			
Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл ба хорогдлын зардал	25.3	11,872,940	11,829,178
Орлогын албан татварын өгөөж	24	(2,998,982)	(165,974)
Хүүгийн зардал	28	25,600,326	25,034,081
Хүүгийн орлого	26	(29,261)	(30,585)
Гадаад валютын ханшийн зөрүүний (олз) / гарз		6,498,317	(4,254,445)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	31.1	(49,464)	(16,378)
Бараа материалын хасагдуулгын зардал	8	738,563	494,616
Үндсэн болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	27.2	13,355	78,409
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	27.1	-	(48,066)
		34,648,184	(5,025,192)
Өөрчлөлт:			
Дансны болон бусад авлага		12,664,331	1,528,742
Урьдчилгаа		228,243	(231,297)
Бараа материал		8,500,346	54,823,041
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө		(17,227)	646,063
Дансны ба бусад өглөг		14,542,458	(4,888,790)
Буцаах эрхтэй барааны өр төлбөр		26,503	(1,010,634)
Гэрээний өр төлбөр		613,617	(171,104)
		71,206,455	45,670,829
Төлсөн орлогын албан татвар	24.2	(78,714)	(280,600)
Төлсөн хүү	17.2	(25,219,577)	(25,402,704)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		45,908,164	19,987,525
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан хүү	26	29,261	30,585
Худалдсан үндсэн болон биет бус хөрөнгө		7,664	452,393
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	10	(2,934,998)	(418,373)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	13.1	(226,018)	(276,618)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(3,124,091)	(212,013)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	17.2	381,238,895	414,253,570
Гаргасан бонд	17.2	7,906,980	9,877,213
Төлсөн бонд		(17,765,164)	-
Төлсөн зээл	17.2	(396,589,513)	(453,299,174)
Төлсөн түрээсийн төлбөр	17.2	(931,813)	(940,160)
Төлсөн ногдол ашиг	20	(247)	(100)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(26,140,862)	(30,108,651)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)			
Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү	23	(11,997,888)	1,923,910
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		117	(37)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5	4,389,479	12,798,745
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	9,034,919	4,389,479

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Говь ХК (цаашид “Компани” гэх) нь 1981 онд Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан. Компанийн 50.33%-ийг Монгол Улсад бүртгэлтэй Таван Богд Трейд ХХК, 34%-ийг Япон Улсад бүртгэлтэй Хиде Ингер ХХК эзэмшдэг бөгөөд үлдсэн 15.67%-ийг бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Говь ХК нь нийт 23,172 хувьцаа эзэмшигчтэй байсан.

Компани нь Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Говь Хувьцаат Компанийн байранд байрладаг. Говь ХК болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь “Групп” гэх) нь үндсэн үйл ажиллагаагаа Монгол, БНХАУ, АНУ, ХБНГУ, Их Британи зэрэг улсад эрхлэн явуулдаг.

Компани нь Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, улсын бүртгэлийн 2076357 тоот регистрийн дугаартай гэрчилгээ авсан болно.

Групп нь сүлжмэл, оёмол, нэхмэл бэлэн бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн борлуулах болон хуурай хими цэвэрлэгээний үйлчилгээ зэрэг үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг. Группийн үйл ажиллагааны орлогын талаар тодруулга 25.1-д тодруулсан болно. Компанийн охин компаниудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Тодруулга 12-т тодруулсан.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөр Группийн удирдлага батлан гаргасан.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

2.1 Тайлагналын нийцэл

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэж, тайлагнасан болно. Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх зорилгоор тодорхой харьцуулагдах дүнг дахин ангилсан.

2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянгачилан, Группийн бүртгэлийн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр толилуулсан.

2.2.1 Тасралтгүй байх зарчим

Ковид-19 цар тахлын улмаас Хятад улсад үүсэж буй асуудлууд болон хойд хөршид үүсэж буй геополитикийн хурцалдал асуудлуудаас үүдэлтэй валютын ханшийн өсөлт, гадаад тээврийн саатал, хөрш орнуудын хил гаалийн хязгаарлагдмал нөхцөл байдал зэрэг нь 2020–2022 онд бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахад ихээхэн хүндрэл учруулж байгаа билээ.

Говь ХК-ийн 2022 оны нийт борлуулалтын орлого 193.4 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 34%-ийн өсөлттэй байна. Үүнд, дотоод зах зээлийн борлуулалт 93.5 тэрбум буюу 40%-аар, Европ зах зээлийн борлуулалт 32.5 тэрбум буюу 29%-аар, Америк зах зээлийн борлуулалт 13.7 тэрбум буюу 46%-аар, Хятад зах зээлийн борлуулалт 6.1 тэрбум буюу 40%-аар өмнөх онтой харьцуулахад тус тус өссөн байна. Мөн вэбсайтын хурд, дүрслэлийг сайжруулж, бүтээгдэхүүний тайлбар, зургийг шинэчлэн хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй болгосны үр дүнд нийт онлайн хэрэглэгчийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад 2.6 дахин өссөн.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.2 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь (үргэлжлэл)

2.2.1 Тасралтгүй байх зарчим (үргэлжлэл)

2022 онд Говь ХК-ийн үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь 46 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 116%-аар өсөлттэй гарсан. Цэвэр санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс суларсан 26 тэрбум төгрөгөөр нийт зээлээ бууруулж чадсан.

Мөн 2022 онд Монголбанкнаас хэрэгжүүлсэн ноос, ноолуурын салбарыг дэмжих бодлогын хүрээнд Хаан банктай хийсэн зээлийн шугамын гэрээний нэмэлтэнд үндэслэн 3%-ийн хүүтэй 2 жилийн хугацаатай 10 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Монголбанкнаас гаргасан репо санхүүжилтийн хүрээнд Голomt банкнаас 11%-ийн хүүтэй 3 жилийн хугацаатай 20 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилтийг тус тус татсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 264 тоот тогтоолоор 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласан. Үүний хүрээнд, Монгол Улс 2023 онд 1 сая гадаадын жуулчин хүлээн авах төлөвлөгөөтэй байна. Үүнийг 2022 онд 290 мянган гадаадын жуулчин хүлээн авсан үзүүлэлттэй харьцуулахад 3.5 дахин өсөх төлөвлөгөө юм. Хятад Улс “0 Ковид” бодлогоо зогсоож 2023 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн хилээ нээсэнтэй холбогдуулан Хятад жуулчид Монгол Улсад ирэх боломж үүсэж байна. Энэ нь дотоод борлуулалтыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна. Гадаад борлуулалтын хувьд брэндийн танилдалт ихсэхийн хирээр борлуулалт болон хэрэглэгчдийн тоо өсөж байгаа ба мөн Centrics Software компанитай байгуулсан Бүтээгдэхүүний Ашиглалтын мөчлөгийн Менежмент систем нэвтрүүлэх гэрээний үр дүнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн процесс сайжирснаар дотоод болон гадаад хэрэглэгчдийн тоо нэмэгдэн борлуулалт өснө хэмээн төлөвлөж байна. Үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ ихсэж, үйлдвэрийн бүтээмж нэмэгдэхээр байгаа бол үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд Голomt банк болон Хас банкны зээлийн шугамыг ашиглахаар төлөвлөж байна.

2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Говь ХК-ийн толгой компани болох Таван Богд Трейд ХХК-ийн зүгээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаас хойш дор хаяж 12 сараас доошгүй хугацаанд Говь ХК-ийг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах болон өр төлбөрүүдээ төлөх зэрэгт үзүүлдэг санхүүгийн дэмжлэгээ үргэлжлүүлэн үзүүлсээр байгаа илэрхийлсэн захидлыг Говь ХК-д ирүүлсэн. Таван Богд Трейд ХХК нь мөн тус группт хамаарах аж ахуйн нэгжүүдээс авсан зээлийн өр төлбөрийг эргэн төлүүлэх нөхцөл байдал үүсгэхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт зээлийн эх үүсвэрийг олгохыг илэрхийлсэн.

Групп нь тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн зарчим дээр тулгуурлан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын бэлтгэсэн бөгөөд удирдлагын зүгээс үүнийг зохистой гэж үнэлсэн.

2.3 Нэгтгэлийн суурь

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компанийн болон түүний хяналтад байдаг охин компаниудын санхүүгийн тайлангаас бүрддэг. Компани дараах тохиолдолд хяналтыг бий болгодог:

- Санхүүжигчийг удирдах чадвар;
- Санхүүжигчээ өөрийн оролцооны дагуу хувьсах өгөөж хүртэх эсвэл эрхээ шилжүүлэх; болон
- Санхүүжигчийн өгөөжид нөлөөлөх эрх мэдлийг ашиглах чадвар

Дээр дурдсан гурван шалгуурын аль нэгийг өөрчлөх нөхцөл болзол үүссэн тохиолдолд Групп нь санхүүжигчид тогтоосон хяналтаа алдсан эсэх талаар дахин үнэлнэ.

Санхүүжигчид нөлөө үзүүлэх саналын эрхийн олонхыг эзэмшдэггүй хэдий ч Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх бодит чадвартай байвал санхүүжигчид үзүүлэх нөлөө байна гэж үздэг. Компанийн эзэмшиж буй саналын эрх нь санхүүжигчийн холбогдох үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хүч байгаа эсэхийг дараах хүчин зүйлүүдээр үнэлдэг.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.3 Нэгтгэлийн суурь (үргэлжлэл)

- Компанийн саналын эрхийн хэмжээ болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тархалт болон сарнилт
- Компани болон бусад хувьцаа эзэмшигчдийн саналын эрхээ хэрэгжүүлэх чадвар
- Бусад гэрээгээр тохирсон саналын эрх
- Компанийн саналын эрх нь одоогийн холбогдох үйл ажиллагаанд нөлөөлж чадах бусад хүчин зүйлүүд

Компани охин компанийг хяналтдаа оруулсан өдрөөс эхлэн нэгтгэсэн санхүүгийн тайланд уг охин компанийг нэгтгэх ба охин компани дахь хяналтаа алдсан өдрөөс эхлэн нэгтгэхээ зогсоодог. Тусгайлан, охин компанийн тайлант жилийн орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахдаа тухайн охин компани дахь хяналтыг олж авсан өдрөөс тухайн охин компани дахь хяналтаа алдсан өдөр хүртэл тасалбар болгон тайлант жилийн орлого, зардлыг ашиг, алдагдал болон бусад нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайланд нэгтгэдэг.

Охин компанийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох хэсэг гэж ангилан харуулдаг. Охин компанийн нийт дэлгэрэнгүй орлогыг Группийн эзэд болон хяналтын эрхгүй хувь оролцоонд хуваарилах бөгөөд үүнийг хяналтын эрхгүй хувь оролцоо хасах үлдэгдэлтэй болох байсан ч хэрэгжүүлнэ.

Хэрэв шаардлагатай бол, Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд охин компанийн санхүүгийн тайланд тохируулга хийдэг.

Толгой болон охин компаниудын хооронд гарсан орлого, зардал, мөнгөн гүйлгээ болон хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансны үлдэгдлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд бүрэн устгадаг.

2.3.1. Группийн охин компани дахь эзэмшлийн хувийн өөрчлөлт

Охин компани дахь Группийн эзэмшлийн хувийн өөрчлөлтийг охин компани дахь хяналтын багцаа алдаагүй л бол эзэмшигчийн өмчийн ажил гүйлгээ байдлаар бүртгэнэ. Охин компани дахь Группийн хувь эзэмшил болон хяналтын эрхгүй хувь оролцооны дансны үнийг эзэмшлийн хувьд гарсан өөрчлөлтөөр зарлуулдаг. Хяналтын эрхгүй хувь оролцоон дахь өөрчлөлт ба төлсөн эсвэл хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг өмчид шууд хүлээн зөвшөөрч, Группийн эзэмшигчдэд хуваарилдаг.

Групп нь охин компани дахь хяналтын багцаа алдсан үед олз, гарзыг (i) хүлээн авсан зүйлсийн бодит үнэ цэнэ ба үлдсэн эзэмшлийн хувийн бодит үнэ цэнийн нийлбэр (ii) охин компанийн хөрөнгө (гүүдвиллийг оролцуулаад) ба өр төлбөрийн дансны үнэ ба хяналтын эрхгүй хувь оролцооны зөрүүгээр тодорхойлно.

Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд охин компанигай холбоотой бүртгэсэн өмнөх бүх дүнг тэдгээр хөрөнгийн данснаас хасалт байдлаар бүртгэнэ (холбогдох СТОУС-ын Стандартад заасны дагуу ашиг, алдагдал руу ангилж тайлагнах эсвэл хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ). Өмнөх охин компанид үлдсэн аливаа хөрөнгө оруулалтын хяналтаа алдсан өдрөөрх бодит үнэ цэнийг СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт* –ийн дагуу анхдагч хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнээр эсвэл хэрэв тохиромжтой бол хараат эсвэл хамтарсан хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын анхдагч хүлээн зөвшөөрөлтийн өртгөөр тооцно.

2.4 Бараа материал

Бараа материалыг жигнэсэн дундаж өртгийн аргаар хэмжсэн худалдан авалт ба/эсвэл үйлдвэрлэлийн өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Худалдан авах зардал нь тайлант хугацаан дахь худалдан авалтын холбогдох нэмэлт зардлыг агуулдаг. Үйлдвэрлэлийн зардал нь шууд хамааралтай зардлууд ба бүтээгдэхүүнтэй холбоотойгоор гарсан шууд бус зардлын зарим хэсгийг багтаана. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тооцоолсон борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ. Бараа материалын хүлээгдэж буй хэрэглээ болон цэвэр боломжит үнэ цэнийг харгалзан бараа материал, бүтээгдэхүүний хувьд хасагдуулга нөөцийг шаардлагатай үед тодорхойлно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.5 Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх хөрөнгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дуусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст Групп урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

2.6 Үндсэн хөрөнгө

Группийн эзэмшиж буй газрын эрхийг анх хүлээн авсан өдрийн бодит үнэ цэнээр нь Группийн үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Групп нь газар эзэмших эрхийг олж эзэмшсэн өдрөөс эхлэн холбогдох газрын төлбөрийг улсад тушаадаг бөгөөд энэхүү төлбөрийн хэмжээ харцангуй бага хэмжээтэй юм. Газрын эрхийг элэгдүүлдэггүй бөгөөд дахин үнэлсэн үнэ цэнээр хэмжинэ. Дуусаагүй барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнана.

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг дараах зардлуудаас бүрдэнэ. Үүнд:

- Хөнгөлөлт, урамшууллын дараах худалдан авсан үнэ, гаалийн татвар болон худалдан авалттай холбоотой буцаан олгогдохгүй татвар
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан аливаа шууд зардлууд

Худалдаж авсан программ хангамж нь холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой бол тухайн тоног төхөөрөмжийн нэг хэсэг байдлаар капиталжуулна.

Үндсэн хөрөнгийн өртөгт мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бэлтгэл шаардагдах хөрөнгийн хувьд Группийн 2.16-д тусгасан бодлогын дагуу капиталжуулсан зээлийн хүүгийн зардлыг багтаадаг. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болгож суурилуулах үед тохирох үндсэн хөрөнгийн төрөлд нь ангилан бүртгэнэ.

Тайлант үеийн эцэст газар болон барилгаас бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.

Дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн газар болон барилгыг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тэдгээрийн дахин үнэлсэн дүнгээр тайлагнах ба мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний зах зээлийн бодит нотолгоонд үндэслэн дахин үнэлсэн өдрийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнадаг. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлдог.

Дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн жилийн ашиг, алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшинг нэмэгдүүлэх замаар Группд эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед өртгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг. Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.6 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгийн өртөг эсвэл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэгдэл өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил:

Барилга байгууламж	10 - 40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил	2 - 10 жил
Тээрийн хэрэгсэл	10 жил
Түрээсийн сайжруулалт	2 - 5 жил

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг тооцох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

2.7 Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар, биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолон хүлээн зөвшөөрдөг. Тооцоолсон ашиглалтын жил болон хорогдол бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 2-оос 10 жил байна.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

2.8 Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант үеийн эцэс бүрт Групп нь үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө ба биет бус хөрөнгийн дансны үнэд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлох шалгуур хийдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол үнэ цэнэ бууралтын гарз (ийм гарз гарсан бол)-ыг тогтоохын тулд тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тухайн хөрөнгийн хувьд тооцоолох боломжгүй бол Групп нь уг хөрөнгийн харьяалагдах “мөнгөн орлого үүсгэгч нэгж”-ийн нөхөгдөх боломжтой үнийг тооцоолно. “Мөнгөн орлого үүсгэгч нэгж”-д хуваарилах боломжийн бөгөөд тууштай суурь үзүүлэлтийг тодорхойлж чадвал аж ахуйн зориулалттай хөрөнгийг тодорхой “мөнгөн орлого үүсгэгч нэгж”-д хуваарилах ба ийм боломжгүй бол хамгийн боломжийн бөгөөд тууштай ашиглах боломжтой суурь үзүүлэлтийг ашиглан хамгийн жижиг “мөнгөн орлого үүсгэгч нэгж”-д хамааруулан шалгадаг.

Хөрөнгийн эсвэл “мөнгөн орлого үүсгэгч нэгж”-ийн нөхөгдөх боломжтой үнэ гэдэг нь хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж ба хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртөг зардлыг хассан цэвэр дүн хоёрын аль ихээр нь тогтоогдоно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (үргэлжлэл)

2.8 Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ одоогийн мөнгөний үнэ цэнийн зах зээлийн үнэлэмж болон хөрөнгийн тусгайлсан эрсдэлийг тусгасан татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Үнэ цэнэ бууралтын шалгуурын зорилгоор дангаар нь шалгах боломжгүй хөрөнгийг бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс (“мөнгөн орлого үүсгэгч нэгж”) хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан шалгадаг.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харьяалагдах “мөнгөн орлого үүсгэгч нэгж”-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжтой тооцоолсон үнээс их байвал үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэж, ашиг, алдагдлаар тусгана. “Мөнгөн орлого үүсгэгч нэгж”-ийн хувьд тодорхойлсон үнэ цэнэ бууралтын гарзыг бүртгэхдээ эхлээд тухайн нэгжид хуваарилагдсан гүүдвиллийн дансны үнийг бууруулах ба үлдсэн алдагдлын дүнгээр тухайн нэгж (бүлэг нэгж)-д багтсан бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүлэн бууруулна.

Өмнөх жилүүдэд бүртгэсэн үнэ цэнэ бууралтын алдагдал буурсан эсвэл алдагдал үгүй болсон эсэхийг илрүүлэхийн тулд үнэ цэнэ бууралтын алдагдлыг тайлангийн өдрөөр дахин хянана. Нөхөгдөх боломжтой дүнг тодорхойлоход ашигласан тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана, үүнд гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын алдагдал хамаарахгүй. Үнэ цэнийн бууралт бүртгээгүй байсан бол байх байсан элэгдэл, хорогдлыг хассан хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй байхаар бодож үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

2.9 Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг Групп тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үүссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр (ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

2.10 Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

2.10.1 Санхүүгийн хөрөнгийн ангилал

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС-ын Стандартуудад нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үед тус тус тусгадаг.

3.1 Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж

3.1.1 Газрын эрхийн ашиглалтын жил ба элэгдэл

Групп нь Монгол Улсад орших газрыг 15-аас 60 жилээр эзэмшдэг.

Монгол Улсын Газрын тухай хууль нь Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд газрын эрх эзэмших эрх зүйн үндсийг тогтоосон.

Групп газрыг гэрээний дагуу олж эзэмшсэн бодит үнэ цэнээр нь анх бүртгэлд тусгадаг. Групп өнгөрсөн жилүүдэд газар эзэмших эрхийн хугацааг маш бага хэмжээний жил тутмын төлбөр төлж амжилттай сунгуулсан. Группийн удирдлага газар эзэмших эрхийн хугацааг бага хэмжээний төлбөр төлж, цаашид тодорхойгүй хугацаагаар эзэмшинэ гэдэгт итгэлтэй байна. Тиймээс нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд 17,982,615 мянган төгрөгийн (2021 онд 17,959,888 мянган төгрөг) дансны үнэ бүхий газар нь үнэ цэнийн бууралтыг хассан, дахин үнэлсэн дүнгээр илэрхийлэгдсэн бөгөөд газрыг элэгдүүлдэггүй.

3.1.2 Монгол Улсын татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтэцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд, бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна. Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Групп татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Групп-д татварын эрсдэл байсаар байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.1.3 Хувьсах дүнг тооцоолох болон хязгаарлалтыг үнэлэх аргыг тодорхойлох нь

Бараа бүтээгдэхүүн борлуулах зарим гэрээнүүдэд буцаах нөхцөл бүхий хувьсах хүчин зүйлийг агуулсан байдаг. Групп нь буцаан олгоно гэж буй таамаглаж буй дүнг тооцоход тохирох аргад үндэслэн хүлээгдэж буй үнэ цэнийн арга болон хамгийн боломжит дүнгийн аргыг ашиглан тооцоолдог.

Групп нь адил төстэй олон тооны хэрэглэгчийн гэрээнүүдийн хувьд буцаагдах эрх бүхий бараануудын хувьсах төлбөрийг тооцоолоход хүлээгдэж буй үнэ цэнийн арга нь тохиромжтой арга гэж үзсэн.

Гүйлгээний үнэ дэх хувьсах хэмжигдэхүүнийг оруулахын өмнө Групп нь хувьсах төлбөрийн дүн хязгаарлагдаж байгаа эсэхийг авч үздэг. Групп нь хувьсах зардлын тооцооллыг Группийн түүхэн туршлага, бизнесийн таамаглал, одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан хязгаарлаагүй болохыг тогтоосон. Үүнээс гадна хувьсах төлбөрийн тодорхойгүй байдлыг богино хугацаанд шийдвэрлэдэг.

2022 онд борлуулалтын орлого нь 12,447,074 мянган төгрөгийн буцаалт, хөнгөлөлтийг хассаны дараа 193,427,609 мянган төгрөг (2021 онд борлуулалтын орлого нь 1,113,597 мянган төгрөгийн буцаалтыг хассаны дараа 144,344,329 мянган төгрөг) байсан.

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдэд дараах таамаглал төсөөллийг ашиглан, нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

3.2.1 Алдагдлын нөөц сангийн тооцоолол

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдал болон салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолсон.

Энэ тохиолдолд удирдлагын үнэлгээ нь харилцагч талын нөхцөл байдал, харилцаа холбоо, түүний талаарх тодорхой байгаа зах зээлийн мэдээлэл болон зээлийн талаарх мэдээ тайлан зэрэг дээр үндэслэн хийгддэг. Групп нь цуглуулагдахаар хүлээгдэж буй дүнг илэрхийлэх үүднээс хасагдуулгыг удирдлагын үнэлгээний дагуу тооцоолдог. Энэхүү тусгайлсан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

Үнэлгээ болон тооцоолол хийсэн аргачлалаас хамааран бүртгэсэн зардлын дүн болон хугацааны хувьд нөөц сангууд ялгаатай байж болно. Найдваргүй авлагын нөөц сан өсвөл үйл ажиллагааны зардал өсөх ба эргэлтийн хөрөнгө буурах нөлөөтэй.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Группийн дансны ба бусад авлагын дансны үнэ нь 3,318,986 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,771,075 мянган төгрөг (2021 онд: дансны ба бусад авлагын дансны үнэ нь 2,258,129 мянган төгрөг, авлагын нөөц сангийн үлдэгдэл 1,843,519 мянган төгрөг) байсан.

3.2.2 Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгын нөөц

Группийн удирдлага удаан гүйлгээтэй, зарагддаггүй болон эвдэрч гэмтсэн бараа материалыг тодорхой хугацаагаар хянадаг ба үнэлэмж болон тооцооллыг ашигладаг. Тооцоолол болон холбогдох төсөөллүүд нь түүхэн туршлага дээр үндэслэдэг ба бодит үр дүн нь тооцооллоос зөрүүтэй байж болно.

Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь бараа материалыг үйлдвэрлэж дуусгаснаас хойш борлуулаагүй бол хугацаа, насжилт болон бараа материалын зэрэглэлээс хамаарч ангилалын дагуу хасагдуулга байгуулна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2.2 Удаан гүйлгээтэй бараа материалын хасагдуулгын нөөц (үргэлжлэл)

Удирдлага дээрх бараа материалын үнэлгээг тодорхойлоход хэрэглэсэн төсөөлөл болон үнэлэмж зохистой буюу тохиромжтой гэдэгт итгэж байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх бараа материалын дансны үнэ нь 128,791,463 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын үлдэгдэл нь 2,357,493 мянган төгрөг (2021 онд бараа материалын дансны үнэ нь 138,030,372 мянган төгрөг, бараа материалын хасагдуулгын үлдэгдэл 1,791,496 мянган төгрөг) байсан.

3.2.3 Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолох

Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцож буй үнээс түүнийг борлуулахад шаардагдах тооцон зардлыг хассан дүн юм. Гэмтэлтэй, хоцрогдсон болон удаан хугацаанд хөдөлгөөнд ороогүй бараа материал байгаа эсэхийг удирдлагын зүгээс тогтмол хянадаг.

Компани өөрийн тооцооллыг үнэн зөв, бодитой гэж үзэж байгаа боловч аливаа бодит нөхцөл байдал эсвэл нөлөө бүхий хүчин зүйлсээс шалтгаалан тооцоололд өөрчлөлт орсон тохиолдолд ашиг, алдагдал болон өмчид материаллагаар нөлөө үүсч болзошгүй.

3.2.4 Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил

Тодруулга 2.6-д тайлбарласнаар, Групп үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцооллыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрөөр хянадаг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай бол залруулдаг. Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийн тооцоололд өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоолоход үнэлэмж ашигладаг ба уг тооцоолол нь тайлант жилийн цэвэр ашигт нөлөө үзүүлэх боломжтой.

Удирдлага дээрх тооцоолсон үндсэн хөрөнгийн ашиглалтын жил уг хөрөнгийн бодитой эдийн засгийн ашиглах жил гэдэгт итгэж байна.

3.2.5 Барилга ба газрын бодит үнэ цэнийн хэмжилт

Газар болон барилга нь санхүүгийн тайлагналын зорилгоор бодит үнэ цэнээр хэмжигдсэн. Групп хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо ажиглаж болох зах зээлийн үнийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээлийн үнэ цэнийн мэдээлэл (1-р түвшин) тодорхойгүй бол Групп хараат бус мэргэжлийн үнэлгээнээр хөрөнгийн үнэлгээг тооцоолуулдаг. Эдгээр тооцоолоос хамаарч газар болон барилгын үнэлгээ өөрчлөгдөх боломжтой.

Барилга болон газрын бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан мэдээлэл болон үнэлгээний аргачлалын талаар тодруулга 10.2-г харна уу.

3.2.6 Хойшлогдсон орлогын албан татвар

Групп нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцоолохдоо Монгол Улсын хуулиар тогтоосон татварын хувь хэмжээ, татвараас хасагдахгүй зардлууд, татварын хуульд орсон өөрчлөлтүүд болон удирдлагын хүлээж буй ирээдүйн үр дүн зэргийг харгалзаж үздэг. Хойшлогдсон орлогын албан татварыг түр зөрүүн дээр суурилан тооцоолдог ба энэ нь санхүүгийн тайланд тайлагнасан орлого, зардал болон татварын хуулийн дагуу тодорхойлсон татвар ногдох орлого, зардлын хоорондох зөрүү юм. Эдгээр түр зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг нэгтгэсэн санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр тусгадаг.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

3. Нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж ба тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2 Тодорхой бус байдал дахь таамаглал, тооцооллын үндсэн эх сурвалж (үргэлжлэл)

3.2.6 Хойшлогдсон орлогын албан татвар (үргэлжлэл)

Группийн удирдлага нь хойшлогдсон татварын хөрөнгө хэрэгжихгүй гэж үзэж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй. Бодит үр дүн нь энэ таамаглалаас зөрүүтэй байх тохиолдолд ирээдүйн тайлант үеүдэд уг таамаглалын залруулга хийх ба тайлант жилийн санхүүгийн байдал болон орлогод материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэх шаардлага тулгарч болно.

Групп 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд нийт 14,879,483 мянган төгрөг болон 4,634,777 мянган төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрсөн.

Групп 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд нийт 8,206,834 мянган төгрөг болон 309,195 мянган төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрсөн. Тодруулга 2.23 болон 24.3-ыг харна уу.

4. Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС-ын Стандартууд

4.1 Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэчлэгдсэн СТОУС-ын Стандартууд болон шинэ тайлбарууд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2022 оны 01 дүгээр 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын Стандартуудын өөрчлөлтүүдийг Групп тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэчлэгдсэн стандартууд болон өөрчлөлтүүд
2022 оны 01 сарын 01	<ul style="list-style-type: none"> НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлт Алдагдалтай гэрээ - Гэрээний биелэлтийн өртөг 2018-2020 оны СТОУС-ын Стандартуудын жилийн сайжруулалтын өөрчлөлтүүд НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт Үндсэн хөрөнгө: Ашиглахаас өмнө хөрөнгийн орлого СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт Үзэл баримтлалын тайлбар

Шинэчлэгдсэн СТОУС-ын Стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг батлан гаргах үед батлагдсан байсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Групп эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрднө.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

4. Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС-ын Стандартууд (үргэлжлэл)

4.2 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд (үргэлжлэл)

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2023 оны 01 сарын 01	<ul style="list-style-type: none"> СТОУС 17 Даатгалын гэрээ НББОУС 1 ба СТОУС-ийн практик мэдэгдлийн 2-г оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулах нь НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар СТОУС 17 болон СТОУС 9-ийн анхны хэрэгжүүлэлт - Харьцуулагдах мэдээлэл (СТОУС 17-ийн нэмэлт өөрчлөлт)
2024 оны 01 сарын 01	<ul style="list-style-type: none"> Борлуулаад буцаан түрээслэх ажил гүйлгээний түрээсийн өр төлбөр (СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт) НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт Эргэлтийн ба Эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан	<ul style="list-style-type: none"> СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч болон хараат эсвэл хамтарсан компанийн хөрөнгийн борлуулалт эсвэл худалдах үнэ

Групп нь нэгтгэсэн санхүүгийн тайланд эдгээр стандартын нэмэлт өөрчлөлтүүд томоохон нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

5. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

	2022	2021
Касс дахь бэлэн мөнгө	40,544	12,258
Банк дахь харилцах данс	8,994,375	4,377,221
	9,034,919	4,389,479

Групп нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөтэй харгалзах санхүүгийн зээлийн эрсдэлийн түвшинг бага гэж үзсэн.

6. Дансны ба бусад авлага

	2022	2021
Дансны авлага	2,905,206	2,289,402
Үнэ цэнийн бууралтын сан	(1,640,363)	(1,698,935)
	1,264,843	590,467
Холбоотой талаас авах авлага (Тодруулга 29.2-г үзнэ үү)	17,222	30,222
Бусад авлага	2,167,633	1,782,024
Үнэ цэнийн бууралтын сан	(130,712)	(144,584)
	3,318,986	2,258,129

6.1 Дансны авлага

Группийн зээлийн борлуулалтын урьдчилан батлагдсан зээлийн хязгаарт багтаан төлөгдөх дундаж хугацаа 30-90 хоног байна. Аливаа шинэ харилцагчийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Группийн удирдлага харилцагчийн зээлийн эрсдэлийн чанарыг үнэлэн зээлийн хязгаарыг харилцагч тус бүрийн хувьд тодорхойлдог.

Групп дансны авлагын хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо харилцагч тус бүрийн бие даасан нөхцөл байдлын үнэлгээ, эдийн засгийн нөхцөл байдал болон салбарын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тооцоолсон.

Эдгээр тохиолдолд тухайн харилцагчдын авлагын үлдэгдэл, хамтын ажиллагааны түүх болон зах зээлийн мэдэгдэж буй хүчин зүйлс дээр үндэслэсэн эсрэг талын одоогийн санхүүгийн байдал, боломжит хамгийн сайн баримт, нөхцөлийг үнэлэн дүгнэлт хийсэн. Групп нь харилцагч бүрд хүлээгдэж буй эргэн төлөгдөх дүнг бууруулсантай холбоотойгоор тусгайлан нөөцийг бүртгэсэн. Энэхүү тусгайлан хасагдуулгын тооцоолсон дүнд нөлөөлөхүйц аливаа өөрчлөлт гарвал түүнийг дахин тооцон үзэж тохируулдаг.

Групп нь харилцагч санхүүгийн хүнд байдалд орсон тухай мэдээлэл хүлээн авсан, авлагын эргэн төлөгдөх бодитой төлөв байхгүй үед, өөрөөр хэлбэл, эдгээр тохиолдолын аль нэг нь үүссэн буюу хариуцагч татан буугдсан, дампуурлын үе шатанд орсон, эсвэл борлуулалтын авлага нь арваас дээш жилийн насжилттай болсон тохиолдолд борлуулалтын авлагын хасалдуулга бүртгэдэг. Хууль сахиулах байгууллагын шийдвэрээр данснаас хассан авлага байхгүй.

Группийн түүхэн зээлийн алдагдал нь харилцагчийн сегмент бүрийн хувьд эрс ялгаатай хэв шинжийг харуулдаггүй тул өнгөрсөн үеийн төлөв байдалд суурилсан алдагдлын санг Группийн харилцагчийн сегментээр ялгаж харуулаагүй болно.

6.2 Бусад авлага

	2022	2021
НӨАТ-ын авлага	1,394,152	930,707
Ажилчдаас авах авлага	495,474	468,918
Бусад	278,007	382,399
	2,167,633	1,782,024

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

7. Урьдчилгаа

	2022	2021
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа	1,100,746	1,383,448
Урьдчилж төлсөн зардал	1,217,749	1,126,164
	2,318,495	2,509,612

8. Бараа материал

	2022	2021
Түүхий эд материал	39,237,700	29,398,700
Дуусаагүй үйлдвэрлэл	13,904,765	14,277,420
Бэлэн бүтээгдэхүүн	64,176,011	84,336,801
Хангамжийн материал	10,245,875	11,656,100
Замд яваа бараа	3,584,605	152,847
	131,148,956	139,821,868
Бараа материалын үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(2,357,493)	(1,791,496)
	128,791,463	138,030,372

Түүхий эд материалд түүхий ноолуур, самнасан ноолуур, ноолууран утас, даавуу болон драп багтсан. 2022 онд бараа материалаас борлуулсан бүтээгдэхүүний өртөг 101.5 тэрбум төгрөг (2021 онд 83.6 тэрбум төгрөг) бүртгэсэн.

Бараа материалын үнэ цэнийн бууралтын хасагдуулгын хөдөлгөөн:

	2022	2021
Эхний үлдэгдэл	1,791,496	1,766,807
Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулга	738,563	494,616
Данснаас хассан	(172,566)	(469,927)
Эцсийн үлдэгдэл	2,357,493	1,791,496

2022 онд нийт 121.7 тэрбум төгрөг (2021 онд 151.7 тэрбум төгрөг)-ийн бараа материалыг банкны зээлд барьцаалсан.

9. Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө

	2022	2021
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	17,227	-
	17,227	-

Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө нь Группийн худалдан авагчдаас борлуулалтын гэрээний дагуу буцаагдах магадлалтай барааг илэрхийлнэ.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

10. Үндсэн хөрөнгө

	Газар	Барилга	Тонг тохиромж	Тавилга, эд хогшил	Тээврийн хэрэгсэл	Дуусаагүй барилга*	Түрээсийн сайжруулалт	Нийт
<i>Өртөг болон дахин үнэлгээ:</i>								
2021 оны 01 сарын 01	17,959,888	79,489,188	89,208,462	5,977,193	2,534,743	18,353,735	622,574	214,145,783
Нэмэгдсэн	-	-	154,131	216,303	-	47,939	-	418,373
Хасагдсан	-	-	(277,279)	(454,571)	(831,418)	-	-	(1,563,268)
Бараа материал руу ангилсан	-	-	(194,925)	(41,066)	-	(12,531)	-	(248,522)
Үндсэн хөрөнгө хооронд ангилсан	-	39,887	9,107,959	14,401	-	(9,162,247)	-	-
2021 оны 12 сарын 31	17,959,888	79,529,075	97,998,348	5,712,260	1,703,325	9,226,896	622,574	212,752,366
Нэмэгдсэн	22,727	1,663,991	233,904	514,364	475,596	24,416	-	2,934,998
Хасагдсан	-	-	(54,130)	(25,058)	-	-	-	(79,188)
Биет бус хөрөнгө руу ангилсан	-	-	-	(6,929)	-	-	-	(6,929)
Үндсэн хөрөнгө хооронд ангилсан	-	-	9,232,941	-	-	(9,232,941)	-	-
2022 оны 12 сарын 31	17,982,615	81,193,066	107,411,063	6,194,637	2,178,921	18,371	622,574	215,601,247
<i>Хуримтлагдсан эзлэгдэл:</i>								
2021 оны 01 сарын 01	-	6,673,087	46,827,481	2,974,111	1,123,209	-	304,571	57,902,459
Байгуулсан эзлэгдэл	-	2,378,437	6,884,947	884,825	243,992	-	303,739	10,695,940
Хасагдсан	-	-	(274,872)	(395,567)	(471,945)	-	-	(1,142,384)
Бараа материал руу ангилсан	-	-	(82,602)	(25,580)	-	-	-	(108,182)
2021 оны 12 сарын 31	-	9,051,524	53,354,954	3,437,789	895,256	-	608,310	67,347,833
Байгуулсан эзлэгдэл	-	2,404,373	7,545,344	728,169	166,427	-	-	10,844,313
Хасагдсан	-	-	(53,180)	(5,807)	-	-	-	(58,987)
Биет бус хөрөнгө руу ангилсан	-	-	-	(6,929)	-	-	-	(6,929)
Галаад валютын ханшийн хөрвүүлэлтийн хөдөлгөөн	-	-	11,827	19,755	10,860	-	-	42,442
2022 оны 12 сарын 31	-	11,455,897	60,858,945	4,172,977	1,072,543	-	608,310	78,168,672
<i>Дансны үнэ:</i>								
2021 оны 12 сарын 31	17,959,888	70,477,551	44,643,394	2,274,471	808,069	9,226,896	14,264	145,404,533
2022 оны 12 сарын 31	17,982,615	69,737,169	46,552,118	2,021,660	1,106,378	18,371	14,264	137,432,575

*Дуусаагүй барилга, ашиглаж эхлээгүй хөрөнгөд баригдаж дуусаагүй үйлдвэрийн барилга болон усарч суурилуулж дуусаагүй тоног тохиромж багтсан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

10. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

10.1 Барьцаалсан үндсэн хөрөнгө

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 134.8 тэрбум төгрөг (2021 онд 141.3 тэрбум төгрөг)-ийн дансны үнэтэй үндсэн хөрөнгийг банкны зээлд барьцаалсан (тодруулга 17.1-г харна уу).

10.2 Группийн газар болон барилгын дахин үнэлгээ

Группийн газар болон барилга нь хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтыг хассан дахин үнэлсэн дүнгээр тусгагдсан. Группийн газар болон барилга 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр Группээс хараат бус мэргэжлийн үнэлгээчний тодорхойлсон бодит үнэ цэнээр дахин үнэлэгдсэн.

СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт-д тодорхойлсны дагуу хэмжигдсэн үндсэн хөрөнгийн үнэ цэнийг дараах бодит үнэ цэнийн шаталсан түвшнээр ангилсан.

	2022 оны 12 сарын 31		2021 оны 12 сарын 31	
	Бодит үнэ цэнэ	Зэрэглэл 3	Бодит үнэ цэнэ	Зэрэглэл 3
Газар	17,982,615	17,982,615	17,959,888	17,959,888
Барилга	69,737,169	69,737,169	70,477,551	70,477,551
	87,719,784	87,719,784	88,437,439	88,437,439

Газар болон барилгын бодит үнэ цэнийг хэмжихдээ дараах үнэлгээний арга техникийг ашигласан:

Төрөл	Үнэлгээний арга техник
Барилга	Зах зээлийн харьцуулалтын болон өртгийн арга: Уг үнэлгээний загвар нь зах зээлийн жишиг үнэ байгаа үед ижил төрлийн зүйлсийн зах зээлийн үнийг, мөн тохиромжтой үед хорогдуулсан орлуулалтын өртгийг авч үздэг. Хорогдуулсан орлуулалтын өртөг нь биет хоцрогдол болон хуучралт, мөн үйл ажиллагааны болон эдийн засгийн хоцрогдол зэргийг авч үздэг.
Газар	Өртгийн арга: Газрын өртгийн бодит үнэ цэнийг өртгийн аргаар тооцоолсон.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн үр дүнд нийтдээ 33,327,139 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл үүссэн.

2020 оны 9 дүгээр сарын 30-ний өдрөөрх бодит үнэ цэнийн шатлалын ангилал

Бодит үнэ цэнийн хэмжилт	Бодит үнэ цэнийн нөлөөлөл		
	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3
Газар	15,345,890	-	15,345,890
Барилга	17,981,249	-	17,981,249
Нийт	33,327,139	-	33,327,139

Групп 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр газар эзэмших эрхийн бодит үнэ цэнийг дахин тооцож үзсэн ба дансны үнээс материаллагаар залруулга хийх шаардлагагүй гэж үзсэн. Тиймээс НББОУС 16-гийн дагуу үнэд тохируулга хийгээгүй.

Группийн газар болон барилгуудыг түүхэн өртгийн үндсэн дээр хэмжсэн бол дансны үнэ нь дараах байдалтай байхаар байна:

	2022	2021
Газар	2,613,998	2,613,998
Барилга	49,943,903	52,117,738
	52,557,901	55,731,736

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

10. Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

10.3 Бүрэн элэгдсэн үндсэн хөрөнгө

	2022	2021
Өртөг	36,454,214	28,492,345

10.4 Ашиг, алдагдлаар болон бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрсөн элэгдэл болон хорогдуулга

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн:

	2022	2021
Үндсэн хөрөнгийн элэгдэл	1,920,898	3,925,102
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 11)	831,016	976,411
Биет бус хөрөнгийн хорогдол (Тодруулга 13.1)	197,611	156,827
	2,949,525	5,058,340

Бараа материалд хүлээн зөвшөөрсөн зардал:

Тайлант жилд Групп нь 8,923,415 мянган төгрөг (2021 онд 6,770,838 мянган төгрөг)-ийн элэгдлийн зардлыг бараа материалын өртөгт хүлээн зөвшөөрсөн.

11. Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө

	2022	2021
Өртөг:		
01 дүгээр сарын 01	3,428,914	4,033,897
Нэмэгдсэн	234,433	143,572
Хасагдсан	(387,456)	(748,555)
12 дугаар сарын 31	3,275,891	3,428,914
Хуримтлагдсан элэгдэл:		
01 дүгээр сарын 01	2,100,607	1,402,793
Байгуулсан элэгдэл	831,016	976,411
Хасагдсан	(387,456)	(278,597)
12 дугаар сарын 31	2,544,167	2,100,607
Дансны үнэ:		
12 дугаар сарын 31	731,724	1,328,307

11.1 Түрээслэгч талын түрээс

Групп нь дэлгүүр болон агуулахын талбайг түрээсэлдэг. Дундаж түрээсийн хугацаа 3 жил ба түрээсийн хөрөнгийг түрээсийн хугацааны эцэст худалдан авах сонголт түрээсийн гэрээнд тусгагдаагүй.

Групп нь түрээсийн 4 гэрээг СТОУС 16-аар хүлээн зөвшөөрч бүртгэсэн (2021 онд 4 түрээсийн гэрээ) бөгөөд эдгээр түрээсийн гэрээнүүд нь цуцлах сонголтыг агуулсан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

11. Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө (үргэлжлэл)

11.1 Түрээслэгч талын түрээс (үргэлжлэл)

Түрээсийн өр төлбөрийн төлөвийг Тодруулга 16-аас харна уу.

i. Ашиглах эрхтэй хөрөнгө

	2022	2021
01 дүгээр сарын 01	1,328,307	2,631,104
Нэмэгдсэн	234,433	143,572
Хасагдсан	(387,456)	(748,555)
Тухайн жилийн элэгдэл	(831,016)	(976,411)
Хасагдсан элэгдэл	387,456	278,597
12 дугаар сарын 31	731,724	1,328,307

ii. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн

	2022	2021
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	831,016	976,411
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал (Тодруулга 28)	183,245	363,392
Богино хугацаат түрээсийн зардал (Тодруулга 25.4)	206,865	564,802

iii. Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрсөн

	2022	2021
Түрээсийн төлбөрт төлсөн мөнгөн дүн	931,813	940,160

11.2 Түрээслүүлэгч талын түрээс

2022 болон 2021 оны 12 дугаар 31-ний байдлаар Групп түрээслүүлэгчийн хувьд цуцлагдах боломжгүй урт хугацааны үйл ажиллагааны түрээс байхгүй байна.

Групп нь холбоотой талуудтай 12 сарын хугацаатай, цуцлах боломжгүй үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээтэй. Эдгээр түрээсийн гэрээнд гэрээг цуцлах саналыг түрээслэгч эсвэл түрээслүүлэгч гаргаагүй бол анхны түрээсийн хугацаа буюу 12 сараар сунгах сонголтыг багтаасан.

Түрээслэгч нь түрээсийн хугацаа дуусмагц барилгыг худалдан авах сонголтгүй. Группийн 2022 онд хүлээн зөвшөөрсөн түрээсийн орлого 369,439 мянган төгрөг (2021: 255,979 мянган төгрөг) байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цуцлагдах боломжгүй үйл ажиллагааны түрээсийн ирээдүйн хамгийн бага түрээсийн орлого дараах байдалтай байна.

	2022	2021
1 жилээс доош	274,382	247,240
1-ээс дээш 2-оос доош жил	-	-
2-оос дээш 3-аас доош жил	-	-
3-аас дээш 4-өөс доош жил	-	-
4-өөс дээш 5-аас доош жил	-	-
5-аас дээш жил	-	-
	274,382	247,240

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

12. Охин компани дахь хөрөнгө оруулалт

Охин компанийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Үйл ажиллагаа явуулж буй улс	Группийн эзэмшлийн хувь болон саналын эрх	
			2022	2021
Говь Кашмер Европ	Гадаад худалдаа	Герман	100%	100%
Говь Кашмер Өвөр Монгол	Гадаад худалдаа	Хятад	100%	100%
Гоёо ХХК	Гадаад худалдаа	Монгол	100%	100%
Говь Кашмер Америк	Гадаад худалдаа	Америк	100%	100%
Говь Кашмер Их Британи*	Гадаад худалдаа	Их Британи	100%	-

* 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Групп Их Британи улсад шинээр бүрэн эзэмшилтэй охин компани болох Говь Кашмер Их Британи-г байгуулсан.

Охин компаниудын санхүүгийн мэдээлэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар охин компаниудын хураангуй санхүүгийн мэдээлэл дараах байдалтай байна:

2022	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Борлуулалтын орлого	Ашиг (алдагдал)
Говь Кашмер Европ	13,922,880	68,084,246	32,613,789	(12,079,847)
Говь Кашмер Өвөр Монгол	14,148,628	23,574,391	6,147,370	(3,613,415)
Гоёо ХХК	8,752,048	17,760	-	(139,132)
Говь Кашмер Америк	11,333,927	30,449,152	13,714,082	(5,433,793)
Говь Кашмер Их Британи	4,486,988	4,536,993	1,866,549	(50,517)

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар охин компаниудын хураангуй санхүүгийн мэдээлэл дараах байдалтай байна:

2021	Нийт хөрөнгө	Нийт өр төлбөр	Борлуулалтын орлого	Ашиг (алдагдал)
Говь Кашмер Европ	16,757,648	52,890,175	27,080,144	(21,534,846)
Говь Кашмер Өвөр Монгол	10,681,151	15,798,518	4,389,019	(3,706,184)
Гоёо ХХК	8,928,951	55,531	-	30,428
Говь Кашмер Америк	8,795,758	19,796,655	9,393,206	(7,905,631)

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

13. Бусад эргэлтийн бус хөрөнгө

	2022	2021
Биет бус хөрөнгө	448,992	437,024
Түрээсийн дэлгүүрт байршуулсан барьцаа	590,477	557,284
Урьдчилгаа төлбөр	547,826	618,145
	1,587,295	1,612,453

13.1 Биет бус хөрөнгө

	2022	2021
Өртөг:		
01 дүгээр сарын 01	1,381,356	1,225,490
Нэмэгдсэн	226,018	276,618
Үндсэн хөрөнгөөс ангилсан	6,929	-
Хасагдсан	(818)	(120,752)
12 дугаар сарын 31	1,613,485	1,381,356
Хуримтлагдсан хорогдол:		
01 дүгээр сарын 01	944,332	798,339
Хасагдсан	-	(10,834)
Тайлант жилийн хорогдол	197,611	156,827
Үндсэн хөрөнгөөс ангилсан	6,929	-
Гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн хөдөлгөөн	15,621	-
12 дугаар сарын 31	1,164,493	944,332

Дансны үнэ:

12 сарын 31	448,992	437,024
--------------------	----------------	----------------

2022 онд биет бус хөрөнгө нь 226,689 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн программ хангамж (2021 онд 222,378 мянган төгрөг) болон 222,303 мянган төгрөгийн барааны тэмдэгт (2021 онд 214,646 мянган төгрөг)-ээс бүрдэж байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

14. Дансны ба бусад өглөг

	2022	2021
Дансны өглөг	13,906,484	869,894
Холбоотой талд өгөх өглөг (Тодруулга 29.2)	47,583	186,325
Цалингийн өглөг	1,710,470	1,292,523
Бусад татварын өглөг (орлогын албан татварын өглөг ороогүй)	3,922,058	2,065,186
Ногдол ашгийн өглөг (Тодруулга 20)	166,686	166,933
Бондын өглөг	-	9,877,213
Бусад өглөг	1,215,911	1,524,881
	20,969,192	15,982,955

Дансны өглөг нь голчлон гадаадын болон дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөгөөс бүрдэх ба төлбөрийн нөхцөл нь 30-90 хоногийн хооронд байна. Групп санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогынхоо дагуу өр төлбөрийг гэрээний хугацааны дагуу төлдөг.

Говь ХК нь 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр биржийн бус зах зээл дээр эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 9%-ийн хүүтэй 10 тэрбум төгрөгийн бонд гаргасан. Бондын хүүгийн төлөлт хагас жил тутам, үндсэн төлбөрийн эргэн төлөлт хугацааны эцэст гэсэн хуваарьтай байсан. 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр уг бондын хүү болон эргэн төлөлт бүрэн хийгдэж дууссан.

14.1 Гэрээний өр төлбөр

	2022	2021
Урьдчилан хүлээн авсан дүн - богино хугацааны өр төлбөрөөр харуулав	1,983,898	1,370,281
	1,983,898	1,370,281

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гэрээний өр төлбөрийг 2023 онд борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

15. Буцаах эрхтэй барааны өр төлбөр

	2022	2021
Борлуулалтын буцаалтаас үүссэн өр төлбөр	26,503	-
	26,503	-

Буцаах эрхтэй барааны өр төлбөр нь борлуулалтын гэрээний дагуу харилцагчдын худалдан авсан барааг буцаах эрхтэй холбоотой. Борлуулалтын орлогын хүлээн зөвшөөрөх үед буцаах эрхтэй барааны өр төлбөр болон хүлээгдэж буй борлуулалтын буцаалтыг тооцоолон бүртгэдэг.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

16. Түрээсийн өр төлбөр

	2022	2021
Төлөгдөх хугацаагаар ангилбал:		
1 жилийн дотор	837,663	1,092,584
1-ээс дээш 2-оос доош жил	118,446	702,823
2-оос дээш 5-аас доош жил	-	6,080
	956,109	1,801,487
Хасах: Ирээдүйд хүлээн зөвшөөрөх хүү	(66,052)	(214,050)
	890,057	1,587,437
	2022	2021
Хугацаагаар нь ангилсан харуулбал:		
Богино	777,988	914,850
Урт	112,069	672,587
	890,057	1,587,437

Групп түрээсийн өр төлбөрөөс томоохон хөрвөх чадварын эрсдэл хүлээдэггүй.

17. Зээл

	2022	2021
<i>Богино хугацаат:</i>		
Богино хугацаат зээл	127,762,048	130,751,028
Хуримтлагдсан хүүгийн өглөг	2,091,569	1,899,861
Нийт богино хугацаат зээл	129,853,617	132,650,889
<i>Урт хугацаат:</i>		
Урт хугацаат зээл	95,686,234	93,407,780
Нийт урт хугацаат зээл	95,686,234	93,407,780
Нийт	225,539,851	226,058,669

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

17. Зээл (үргэлжлэл)

Зээлийн үлдэгдэлтэй зээлүүдийн нөхцөлүүд дараах байдалтай байна:

Зээлүүдэгч	Валют	Нэрлэсэн хүү	Дуусах хугацаа	2022 оны 12 сарын 31		2021 оны 12 сарын 31	
				Галаад валют (мянган)	Дансны Үнэ	Галаад валют (мянган)	Дансны Үнэ
Голомт банк (Зээлийн шугам) (i)	Ам. Доллар	7.20%	2023	-	-	3,400	9,685,920
Голомт банк (Урт хугацаат) (i)	Төгрөг	11.00%	2025	-	20,000,000	-	-
Европ Сэргэн Босголтын Банк (Транч 1А) (ii)	Ам. Доллар	(2021: 5.3% + 6 сар LIBOR) 7.49%	2024	1,818	6,262,910	2,545	7,251,491
Европ Сэргэн Босголтын Банк (Транч 1В) (ii)	Ам. Доллар	(2021: 6.0% + 6 сар LIBOR) 6.93%	2024	2,727	9,394,364	3,818	10,877,236
Европ Сэргэн Босголтын Банк (Транч 2) (ii)	Ам. Доллар	(2021: 5.3% + 6 сар LIBOR)	2024	3,273	11,273,235	4,364	12,431,128
Хаан банк (Зээлийн шугам) (iii)	Төгрөг	12.60%	2024	-	-	-	-
Хаан банк (iii)	Төгрөг	3.00%	2024	-	10,000,000	-	-
Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	Төгрөг	12.00%	2023	-	42,900,000	-	42,900,000
Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	Төгрөг	11.50%	2022	-	33,333,333	-	33,333,333
Хас банк (Зээлийн шугам) (v)	Төгрөг	13.20%	2023	-	9,566,000	-	10,000,000
Худалдаа Хөгжлийн Банк (АХБ) (vi)	Төгрөг	(2021: 14.40%) 8.00%	2022	-	-	-	990,000
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк (vii)	Евро	4.25%	2027	8,000	29,352,160	16,000	51,567,840
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк (vii)	Евро	5.25%	2027	14,000	51,366,280	14,000	45,121,860
Нийт					223,448,282		224,158,808

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

17. Зээл (үргэлжлэл)

17.1 Зээлийн гэрээний хураангуй

- (i) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт Банкнаас авсан зээлүүд дараах байдалтай байна:
- Групп нь 2018 оны 3 дугаар сарын 19-ний өдөр эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Голомт банкнаас 2 жилийн хугацаатай, нийт 90 тэрбум төгрөг болон түүнтэй тэнцэх ам.долларын зээлийн лимиттэй, 16.8%, 8.4%-ийн хүүтэй олон валютын зээлийн шугамыг авсан.
 - 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр зээлийн хугацааг 12 сараар сунгасан бол 2021 оны 3 дугаар сарын 19 хүртэл сунгасан. Мөн шинэчилсэн гэрээгээр жилийн хүү төгрөгийн зээлийн хувьд 13.5%, ам.долларын зээлийн хувьд 7.2% болж өөрчлөгдсөн. Уг зээлд Группийн бараа материал болон тоног төхөөрөмжийг барьцаалж, ирээдүйн орлого, дансны авлага болон борлуулалтын авлагыг сулласан.
 - 2022 оны 5 сарын 02-ны өдөр Групп нь 20 тэрбум төгрөгийн эрхтэй 36 сарын хугацаатай 11%-ийн хүүтэй урт хугацаат репо санхүүжилт авсан.
- (ii) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (цаашид "ЕСБХ Банк")-наас авсан зээлүүд дараах байдалтай байна:
- Групп нь 2017 болон 2018 онд ЕСБХБанкнаас төлбөрийн чадвар болон ажлын капитал аа нэмэгдүүлэх зорилгоор жилийн LIBOR+5.3% болон LIBOR+6.0%-ийн хүүтэй, нийт 16 сая ам.долларын зээл авсан. Уг зээлийн эргэн төлөлтийг 2024 он хүртэл хийж, хуваарийн дагуу төлж барагдуулна. Уг зээлд Группийн барилга, үйлдвэрийн тоног төхөөрөмж болон бараа материалыг барьцаалсан.
 - 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зээлийн гэрээ шинэчлэгдэн зээлийн хүү тус бүр Транч 1А – 6.79%, Транч 1В – 7.49%, Транч 2 – 6.93% тус бүр тогтмол хүүтэй болсон. Уг гэрээний тогтмол хүүгийн нөхцөл 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 8.2 сая ам.долларын зээлийн үндсэн төлбөрийг зээлийн хүүгийн төлөлттэй хамт төлсөн.
- (iii) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хаан Банкнаас авсан зээлүүд дараах байдалтай байна:
- 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Таван Богд Трейд болон түүний охин компаниудын эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Таван Богд Трейд ХХК-тай байгуулсан зээлийн шугамын гэрээнд Говь ХК-ийг нэмсэн. 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр тус зээлийн шугамын гэрээний зээлийн хүү нь төгрөгийн хувьд 12.6%, ам долларын хувьд 7% болж шинэчлэгдсэн. 2022 оны 8 дугаар сарын 03-ны өдөр зээлийн дүн 53 тэрбум төгрөг болсон.
 - 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Говь ХК нь ноолуурын түүхий эд бэлтгэх, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зорилгоор Монгол Улсын Засгийн Газрын “Ноос, ноолуур, арьс ширний үйлдвэр эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, тогтворжуулах” бодлогын хүрээнд Хаан Банкнаас 3% хүүтэй 24 сарын хугацаатай 10 тэрбум төгрөгийн зээлийг авсан.
- (iv) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Улсын Хөгжлийн Банкнаас авсан зээлүүд дараах байдалтай байна:
- Групп нь 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр ноолуурын түүхий эд бэлтгэх, эргэлтийн хөрөнгөд зарцуулах зорилгоор 42.9 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 12% хүүтэй, 24 сарын хугацаатай авсан. 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орж зээлийн хугацааг 2023 оны 6 дугаар сарын 14 хүртэл сунгасан.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

17. Зээл (үргэлжлэл)

17.1 Зээлийн гэрээний хураангуй, үргэлжлэл

- (iv) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Улсын Хөгжлийн Банкнаас авсан зээлүүд дараах байдалтай байна, үргэлжлэл:
- Групп нь 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор 40 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 3% хүүтэй, 12 сарын хугацаатайгаар авсан. 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр зээлийн гэрээнд зээлийн хүүг 11.5%, зээлийн хугацааг 2022 оны 5 дугаар сарын 22-ны өдөр хүртэл болгож нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг зээлд Группийн газар, барилга, тоног төхөөрөмж, тавилга, тээврийн хэрэгсэл, түүхий ноолуур болон дансны орлогыг барьцаалсан. 2022 оны эцэс дэх зээлийн үлдэгдлийн дүн 33.3 тэрбум төгрөг байна. Групп нь банктэй зээлийн гэрээний сунгалтын талаар харилцан тохиролцож, банк зээлийн хугацааг сунгахыг зөвшөөрсөн. Одоогийн байдлаар зээлийн гэрээний шинэчлэгдсэн нөхцөл бэлэн болоогүй байна.
- (v) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хас Банкнаас авсан зээлүүд дараах байдалтай байна:
- 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Групп 24 сарын хугацаатай, 14.4%-ийн хүүтэй 15 тэрбум төгрөгийн зээлийн шугам авсан. Групп гэрээний дагуу 2022 оны 10 дугаар сараас өмнө буюу 10 дугаар сарын дотор үлдэгдэл төлбөрөө төлөхийг зөвшөөрсөн. Групп зээлийн шугамыг 2021 оны 7 дугаар сарын 30-нд төлсөн.
 - 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Групп болон Таван Богд Трейд ХХК, Таван Богд Проперти ХХК нь Хас Банктэй жилийн 13.2%-ийн хүүтэй, 24 сарын хугацаатай, 25 тэрбум төгрөгийн зээлийн шугамын гэрээ байгуулсан.
 - 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр тус шугамын зээлийн гэрээний хүү 2.4%-аар нэмэгдэж 15.6% болсон. Уг гэрээний нөхцөл 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- (vi) 2021 болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Худалдаа Хөгжлийн Банкаар дамжуулан Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжүүлсэн зээл дараах байдалтай байна:
- 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Худалдаа Хөгжлийн Банкнаас 60 сарын хугацаатай, жилийн 8%-ийн хүүтэй, 6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зээл авсан. 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдөр уг зээлийн хугацааг 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хүртэл сунгасан ба сарын 330 сая төгрөгийн эргэн төлөлтийн нөхцөлтэй байсан. Групп газар, барилга байгууламж болон бараа материал барьцаанд тавьсан байсан.
 - 2022 онд Азийн Хөгжлийн Банкны зээл үндсэн төлбөр хүүгийн хамт бүрэн төлөгдөж дууссан.
- (vii) 2021 он болон 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкнаас авсан зээл дараах байдалтай байна:
- 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Групп Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банктэй нийт 30 сая еврогийн зээлийн гэрээ байгуулсан. 2020 оны 5 дугаар сард Групп жилийн 5.25%-ийн хүүтэй 14 сая евро, 2020 оны 6 дугаар сард жилийн 4.25%-ийн хүүтэй 16 сая евро хүлээн авсан. 14 сая еврогийн зээлийн хугацаа 2027 оны 5 дугаар сарын 15-ны өдөр, 16 сая еврогийн зээлийн хугацаа нь анх олгосон өдрөөс хойш 12 сарын хугацаанд төлөгдөх бөгөөд эргэн төлөлтийн дараа төлөгдсөн дүнгээр дахин авах боломжтой.
 - 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зээлийн гэрээнд өөрчлөлт орж “Facility A” 14 сая еврогийн зээл 2027 оны 5 дугаар сард төлөгдөхөөр, “Facility B” 8 сая еврогийн зээл 2027 оны 5 дугаар сард төлөгдөж дуусахаар хуваарьтай болсон.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

17. Зээл (үргэлжлэл)

17.2 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрийг тохируулах нь

	Зээл, холбоотой талаас бусад (Тод. 17)	Холбоотой талаас авсан зээл (Тод. 17&29)	Холбоотой талаас авсан урт хугацаат зээл (Тод. 18&29)	Бондын өглөг (Тод. 14)	Түрээсийн өглөг (Тод. 16)	Нөгдөл ашгийн өглөг (Тод. 20)	Нийт
2022 оны 01 сарын 01	226,058,669	-	25,622,107	9,877,213	1,587,437	166,933	263,312,359
Авсан зээл	256,422,309	124,816,586	-	-	-	-	381,238,895
Шингэр гаргасан бонд	-	-	-	7,906,980	-	-	7,906,980
Төлсөн бонд	-	-	-	(17,765,164)	-	-	(17,765,164)
Төлсөн зээл	(281,772,927)	(114,816,586)	-	-	-	-	(396,589,513)
Төлсөн түрээсийн төлбөр	-	-	-	-	(931,813)	-	(931,813)
Төлсөн нөгдөл ашиг	-	-	-	-	-	(247)	(247)
Гадаад валютын ханшийн зөрүүний нөлөө	14,451,051	-	5,358,625	-	-	-	19,809,676
Бусад өөрчлөлт	-	-	-	(19,029)	234,433	-	215,404
Хүүгийн зардал	21,735,036	1,048,398	2,219,369	414,278	183,245	-	25,600,326
Төлсөн хүү	(21,375,657)	(1,027,028)	(2,219,369)	(414,278)	(183,245)	-	(25,219,577)
2022 оны 12 сарын 31	215,518,481	10,021,370	30,980,732	-	890,057	166,686	257,577,326

	Зээл, холбоотой талаас бусад (Тод. 17)	Холбоотой талаас авсан зээл (Тод. 17&29)	Холбоотой талаас авсан урт хугацаат зээл (Тод. 18&29)	Бондын өглөг (Тод. 14)	Түрээсийн өглөг (Тод. 16)	Нөгдөл ашгийн өглөг (Тод. 20)	Нийт
2021 оны 01 сарын 01	264,172,594	8,000,000	14,230,453	-	2,902,049	167,033	289,472,129
Авсан зээл	333,533,381	80,720,189	-	-	-	-	414,253,570
Шингэр гаргасан бонд	-	-	-	9,877,213	-	-	9,877,213
Төлсөн зээл	(364,578,985)	(88,720,189)	-	-	-	-	(453,299,174)
Төлсөн түрээсийн төлбөр	-	-	-	-	(940,160)	-	(940,160)
Холбоотой талд өгөх өглөгөөс ангилсан (Тод.14)	-	-	11,395,400	-	-	-	11,395,400
Төлсөн нөгдөл ашиг	-	-	-	-	-	(100)	(100)
Гадаад валютын ханшийн зөрүүний нөлөө	(6,699,698)	-	(3,746)	-	-	-	(6,703,444)
Бусад өөрчлөлт	-	-	-	-	(374,452)	-	(374,452)
Хүүгийн зардал	20,124,594	2,512,953	2,033,142	-	363,392	-	25,034,081
Төлсөн хүү	(20,493,217)	(2,512,953)	(2,033,142)	-	(363,392)	-	(25,402,704)
2021 оны 12 сарын 31	226,058,669	-	25,622,107	9,877,213	1,587,437	166,933	263,312,359

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

17. Зээл (үргэлжлэл)

17.3 Зээлийн шалгуур үзүүлэлтийн хангалт болон шалгуурын чөлөөлөлт

(а) Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ЕСБХБ-аас авсан барьцаат зээлийн 26,930,509 мянган төгрөгийн үлдэгдэлтэй (2021: 30,559,855 мянган төгрөг) байна. Тус зээлийг ирэх 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөх хуваарьтай. Тус зээл нь улирал бүрийн эцэст эргэлтийн харьцаа 1.1-ээс хэтрэхгүй байх, санхүүгийн өр болон ЕВГДА харьцаа 3-аас хэтрэхгүй байх, өрийн үйлчилгээнд хамрах харьцаа 1.6-аас хэтрэхгүй байх зэрэг гэрээний санхүүгийн харьцааны нөхцөлүүдтэй.

Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дээрх гэрээний санхүүгийн харьцааны үүргүүдээ хангаагүй бөгөөд ЕСБХБ-аас шалгуур үзүүлэлтүүдээс чөлөөлөх зөвшөөрөл хүлээн аваагүй. Тиймээс тус зээлийг богино хугацааны зээл гэж ангилсан.

(б) Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкнаас авсан барьцаат зээлийн 80,718,440 мянган төгрөгийн үлдэгдэлтэй (2021: 96,689,700 мянган төгрөг) байна. Тус зээлийг ирэх 5 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөх хуваарьтай. Уг зээл нь улирал бүрийн эцэст хүү нөхөх харьцаа 2:1-ээс багагүй байх, холбогдох хугацаанд хөшүүргийг 3.5:1-ээс хэтрүүлэхгүй байх зэрэг гэрээний санхүүгийн нөхцөлүүдийг агуулдаг.

Групп нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дээрх санхүүгийн харьцааны үүргээ хангаагүй. Гэсэн хэдий ч, Группийн удирдлага 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкнаас шалгуур үзүүлэлтүүдээс чөлөөлөх зөвшөөрөл хүлээн авсан. Үүний дагуу 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус зээлийг шаардсан үед эргэн төлөх нөхцөл үүсээгүй гэж үзсэн.

18. Урт хугацаат өглөг

	2022	2021
Ток Ток ХХК	4,209	-
Таван Богд Трейд ХХК	30,980,732	25,622,107
	30,984,941	25,622,107

Таван Богд Трейд ХХК-тай хийсэн 7.8% хүүтэй (өмнө нь жилийн 8%) зээлийн гэрээнд 2021 оны 9 сарын 01-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж зээлийн хугацааг 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хүртэл сунгасан. 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Таван Богд Трейд ХХК-тай хийсэн зээлийн гэрээнд хэсэгчлэн төлөх нөхцөлийг оруулж, зээлийн төлөлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 5 дугаар сарын 24-ний өдөр болгож өөрчилсөн.

19. Хувьцаат капитал

	Хувьцааны тоо		Хувьцаат капитал	
	2022	2021	2022	2021
Эхний үлдэгдэл	780,112,500	780,112,500	780,113	780,113
Эцсийн үлдэгдэл	780,112,500	780,112,500	780,113	780,113

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Группийн 780,112.5 мянган төгрөгийн хувьцаат капитал нь нэг бүр нь 1 төгрөгийн үнэтэй 780,112,500 ширхэг (2021 онд нэг бүр нь 1 төгрөгийн үнэтэй 780,112,500 ширхэг) зөвшөөрөгдсөн ба гаргасан хувьцаанаас бүрдэж байна.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

20. Ногдол ашиг

	2022	2021
Эхний үлдэгдэл	166,933	167,033
Зарласан ногдол ашиг	-	-
Төлсөн ногдол ашиг	(247)	(100)
Эцсийн үлдэгдэл	166,686	166,933

2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 03 тоот тогтоолын дагуу 2022 онд ногдол ашиг хуваарилаагүй болно.

21. Нэгж хувьцаанд ногдох алдагдал

Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдлыг энгийн хувьцаа эзэмшигчид ногдуулсан ба энгийн хувьцааны жигнэсэн дунджаар дараах байдалтай байна:

	2022	2021
Тайлант жилийн алдагдал	(6,997,610)	(37,946,028)
Энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо	780,112,500	780,112,500
Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)	(8.97)	(48.64)

Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдлыг тооцохдоо Группийн алдагдлыг жилийн туршид эргэлтэд байсан хувьцааны жигнэсэн дунджаар тооцоолсон. Энгийн хувьцаанаас өөр эргэлтэд байгаа хувьцаа болон опцион байхгүй тул нэгж хувьцаанд ногдох алдагдлыг бууруулаагүй болно.

22. Хөрөнгийн дахин үнэлгээний нооц

	2022	2021
Эхний үлдэгдэл	48,870,401	48,974,836
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний татварын нөлөөлөл	(4,301,861)	-
Дахин үнэлгээний бууралт	-	(104,435)
Эцсийн үлдэгдэл	44,568,540	48,870,401

23. Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц

	2022	2021
Эхний үлдэгдэл	561,878	(1,362,032)
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн хөрвүүлэлтийн ханшийн зөрүү	(11,997,888)	1,923,910
Эцсийн үлдэгдэл	(11,436,010)	561,878

24. Орлогын албан татварын зардал (өгөөж)

	2022	2021
Тайлант жилийн татвар:		
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	3,649,946	86,126
Хойшлогдсон татвар:		
Тайлант жилд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын нөхөлт	(6,648,928)	(252,100)
	(2,998,982)	(165,974)

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

24. Орлогын албан татварын зардал (өгөөж) (үргэлжлэл)

24.1 Тайлант жилийн татвар

Тайлант жилийн татварын зардлыг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас тооцсон тохируулга:

	2022	2021
Татварын өмнөх алдагдал	(9,996,592)	(38,112,002)
Хуулиар тогтоосон татварын 25% (2021: 10%)-аар тооцсон татвар	(2,499,148)	(3,811,200)
Хасагдахгүй зардлын нөлөөлөл	836,322	560,984
Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл	(186,577)	(118,373)
Тусгай хувь хэмжээгээр тооцсон татвар	50,639	86,126
Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй тайлант жилийн алдагдал	5,214,018	-
Өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй татвар ногдох түр зөрүүг хүлээн зөвшөөрсөн дүн	452,248	1,120,761
Өмнөх жилтэй холбоотой тооцооллын өөрчлөлт	(6,866,484)	-
Хүлээн зөвшөөрөгдөөгүй хасагдах түр зөрүү	-	1,995,728
Орлогын албан татварын өгөөж	(2,998,982)	(165,974)

Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуульд зааснаар жилд 6 тэрбум төгрөг (2021 онд 6 тэрбум төгрөг) хүртэлх хэмжээний албан татвар ногдох орлогод 10 хувь (2021 онд 10%), 6 тэрбум төгрөгөөс дээш орлогод нэмэлт 25% (2021 онд 25%) татвар ногдуулна.
